



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ 2016 - I УЛИРАЛ

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	6
1.1 Хувьцааны зах зээл	6
1.2 Бондын зах зээл	9
БҮЛЭГ 2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ, БАЙДАЛ	11
БҮЛЭГ 3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ	13
Оршил	13
3.1. Олон улсын санхүүгийн зах зээлийн шинэчлэл, хэрэгцээ, шаардлага	14
3.2. Санхүүгийн байгууллагуудыг тогтвортой, уян хатан болгох	15
3.3. Системийн ач холбогдол бүхий санхүүгийн байгууллагууд төлбөрийн чадваргүй болох, дампуурахаас сэргийлэх	16
3.4. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн найдвартай байдлыг хангах	18
3.5. Сүүдрийн банкны системийг зах зээлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлэх	19
БҮЛЭГ 4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ	25
4.1. Зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд	25
4.1.1. Зах зээлийн үнэлгээ	25
4.1.2. Зах зээлийн үнэлгээний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, хөрвөх чадвар	26
4.1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд	26
4.2. Үнэт цаасны зах зээлийн оролцогчид	27
4.3. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлтийн талын хүчин зүйлс	28
4.3.1. Хувьцааны арилжаа	28
4.3.2. Засгийн газрын үнэт цаасны арилжаа	29
4.3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	29
4.4. Үнэт цаасны зах зээлийн эрэлтийн талын хүчин зүйлс	29
4.5. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үзүүлэлтүүд болон Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа	30
4.5.1. Үнэт цаасны арилжааны мөнгөн гүйлгээ	30
4.5.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд	30
4.5.3. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үзүүлэлтүүд	30
БҮЛЭГ 5. ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ОРЧИН	31
БҮЛЭГ 6. ДААТГАЛЫН САЛБАР	34
6.1. Даатгалын салбарын хөгжлийн үзүүлэлтүүд	34
6.2. Даатгалын салбарын төлөв байдал	35
6.2.1. Даатгалын салбарын бүтэц	35
6.2.2. Даатгалын салбарын үйл хөдлөл /market conduct/	37
6.2.3. Даатгалын салбарын гүйцэтгэл	37
6.3. Даатгалын салбарын дэд бүтэц, зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт	38
БҮЛЭГ 7. ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН ХӨГЖИЛ БА ХАНДЛАГА	39
БҮЛЭГ 8. БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР	44
8.1. Банк бус санхүүгийн байгууллага	44
8.1.1. Банк бус санхүүгийн байгууллагын эдийн засагт үзүүлэх нөлөө	44
8.1.2. Банк бус санхүүгийн байгууллагын үр ашигт байдал	46
8.2. Хадгаламж, зээлийн хоршоо	48
8.2.1. Хадгаламж, зээлийн хоршоодын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө	48
8.2.2. Зээлийн батлан даалтын сан	50
БҮЛЭГ 9. ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨРИЙН БОДЛОГО	52

ДҮРСЛЭЛ

БҮЛЭГ 1

- Дүрслэл 1. S&P 500 индекс
- Дүрслэл 2. FTSE индекс
- Дүрслэл 3. Nikkei 225 индекс
- Дүрслэл 4. CSI 300 индекс
- Дүрслэл 5. MSCI хөгжиж буй зах зээлтэй орнуудын индекс

БҮЛЭГ 3

- Дүрслэл 6. Хямралаас улбаалсан зардлын хэмжээний өсөлт
- Дүрслэл 7. Банкуудын өөрийн хөрөнгө болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны өөрчлөлт
- Дүрслэл 8. СТБЗ-ийн гишүүдийн зохицуулалтын дэглэм
- Дүрслэл 9. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалтын хэрэгжилт
- Дүрслэл 10. ССР, арилжааны тайлагналын хэрэглээ
- Дүрслэл 11. Санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө
- Дүрслэл 12. Сүүдрийн банк болон ДНБ-ний хамаарал
- Дүрслэл 13. Гишүүн орнуудын сүүдрийн банкны системд эзлэх хувь
- Дүрслэл 14. ДНБ-д эзлэх Сүүдрийн банк, БСЗБ, Банкуудын хувь
- Дүрслэл 15. МЗЗС-ийн бодлогын хэрэгжилт

БҮЛЭГ 4

- Дүрслэл 16. Зах зээлийн үнэлгээ
- Дүрслэл 17. ДНБ/ЗЗҮ
- Дүрслэл 18. ТОП-20 индекс
- Дүрслэл 19. Хувьцаат компанийн тоо
- Дүрслэл 20. Шинээр болон нэмж үнэт цаас гаргагчдын тоо

БҮЛЭГ 6

- Дүрслэл 21. Даатгалын нягтрал
- Дүрслэл 22. Ердийн даатгалын нөөц сангийн бүтэц
- Дүрслэл 23. Зах зээлийн төвлөрөл
- Дүрслэл 24. Борлуулалт, маркетингийн зардал

БҮЛЭГ 7

- Дүрслэл 25. Бичил даатгалын бүтээгдэхүүний хувьсал

БҮЛЭГ 8

- Дүрслэл 26. ББСБ-ын нийт хөрөнгийн бүтэц
- Дүрслэл 27. ББСБ-ын нийт зээл, зээлийн чанар
- Дүрслэл 28. Бүртгэлтэй ББСБ-ын тоо
- Дүрслэл 29. Хадгаламж, зээлийн хоршоодын актив
- Дүрслэл 30. ХЗХ-дын нийт зээлийн чанар
- Дүрслэл 31. ХЗХ-дын нийт хадгаламж
- Дүрслэл 32. ХЗХ-дын өөрийн хөрөнгө, өр төлбөр
- Дүрслэл 33. ХЗХ-дын тоо
- Дүрслэл 34. ХЗХ-дын ашигт ажиллагаа

БҮЛЭГ 9

- Дүрслэл 35. Бодлогын сувгийн нөлөөлөл

ХҮСНЭГТ

БҮЛЭГ 1

- Хүснэгт 1. Олон улсын санхүүгийн зах зээлийн индексийн өгөөж
- Хүснэгт 2. СТБЗ-ийн гишүүн орнууд, түнш байгууллагууд
- Хүснэгт 3. Сүүдрийн банкны системийн аргачлал
- Хүснэгт 4. Эдийн засгийн үүргийн ангилал
- Хүснэгт 5. Санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө

БҮЛЭГ 4

- Хүснэгт 6. Зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй 30 компани
- Хүснэгт 7. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо
- Хүснэгт 8. Зохицуулалттай этгээдийн тоо
- Хүснэгт 9. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт
- Хүснэгт 10. Хөрөнгийн биржээр хийгдсэн ЗГҮЦ-ны арилжаа
- Хүснэгт 11. Монголбанкаар хийгдсэн ЗГҮЦ-ны арилжаа
- Хүснэгт 12. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
- Хүснэгт 13. Мөнгөн гүйлгээний задаргаа
- Хүснэгт 14. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ

БҮЛЭГ 5

- Хүснэгт 15. Зохицуулалт, хяналтын орчны харьцуулалт

БҮЛЭГ 6

- Хүснэгт 16. Даатгалын гүнзгийрэлт
- Хүснэгт 17. Даатгалын нягтрал
- Хүснэгт 18. Дүрмийн сангийн бүтэц
- Хүснэгт 19. Даатгалын мэргэжлийн оролцогчид
- Хүснэгт 20. Ашигт ажиллагаа

БҮЛЭГ 7

- Хүснэгт 21. Түгээлтийн сувагт ашиглагддаг технологийн хэлбэрүүд

БҮЛЭГ 8

- Хүснэгт 22. ББСБ-уудын статистик үзүүлэлтүүд
- Хүснэгт 23. ББСБ-ын үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл
- Хүснэгт 24. ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүд
- Хүснэгт 25. Орлого, зарлага, ашигт ажиллагаа
- Хүснэгт 26. Зохистой харьцааны үзүүлэлт
- Хүснэгт 27. Батлан даалт гаргасан байдал
- Хүснэгт 28. Батлан даалтын тоо
- Хүснэгт 29. Батлан даалтын хүртээмж
- Хүснэгт 30. Санхүүжилтийн эх үүсвэр

БҮЛЭГ 9

- Хүснэгт 31. Эрсдэлийн удирдлагын аргачлал

БҮЛЭГ 1.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ¹

1.1 ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ

Олон улсын зах зээл дээр хувьцааны үнэ 2016 оны 2 дугаар сарын дундуур огцом буурч, улирлын эцэст өсөлт гаран V хэлбэрт трендийг үзүүлсэн.

- АНУ-ын хувьцааны зах зээл өсөлттэй гарч, компаниудын ашгийн хэмжээ нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн шалтгаан нь Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны зүгээс бодлогын хүүгээ нэмэгдүүлэхээр төлөвлөөд байсан арга хэмжээ хойшлогдсонтой холбоотой.
- Европын хувьцааны зах зээл харьцангуй тогтворгүй төлөв байдлыг харуулсан. Европын төв банкны зүгээс 2016 оны 1 дүгээр сард авч хэрэгжүүлэх мөнгөний зөөлөн бодлогыг эрчимжүүлэх ажиллагаа удаашралтай байсан нь банкуудад тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд улмаар хувьцааны зах зээлд сөрөг нөлөөг үзүүлсэн байна.
- Япон улсын төв банкны зүгээс бодлогын хүүгээ сөрөг төлөв хүртэл бууруулсан үйл явдал нь хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг бууруулж, хувьцааны зах зээл тайлант улиралд агшихад хүргэжээ.
- Хөгжиж буй зах зээлтэй орнуудын хувьцааны зах зээл хөгжсөн зах зээлтэй орнуудаас илүү өндөр өгөөжтэй гарсан бөгөөд чангараад байсан ам.долларын ханш эргээд сулрах төлөвтэй болсон нь голлох нөлөөг үзүүлжээ.
- Олон улсын бондын зах зээл дээр Засгийн газар болон компанийн бондын өгөөж өсөлттэй гарсан хэдий ч, АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 2016 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 2.3-аас 1.8 хувь болж буурсан.

АНУ: 2016 оны 1 дүгээр улиралд хувьцааны зах зээлийн хувьд 2 дугаар сарын доод үнийн түвшингээс S&P 500 индекс сэргэснээр 1.3 хувийн өсөлттэй гарсан. ХНБ-ны зүгээс бодлогын хүүгээ нэмж өсгөхөөр төлөвлөж байсан хэдий ч уг бодлогын арга хэмжээг хойшлуулсан бөгөөд 2 дугаар сард ХНБ-ны дарга Janet Yellen "... бодлогын хүү өссөн нь санхүүгийн зах зээлд өндөр эрсдэлийг бий болгохын зэрэгцээ бодит эдийн засгийн өсөлт удаашрахад нөлөөлж байна ..." гэсэн мэдэгдлийг Конгресст тавьжээ.

Улмаар 2016 оны 3 дугаар сард ХНБ-ны Нээлттэй зах зээлийн хороонд цаашид бодлогын хүүгээ өсгөхөө зогсоож, эдийн засгаа дэмжих талаар мэдэгдээд байна.

Дүрслэл 1. S&P 500 индекс



Эх сурвалж: money.cnn.com

Олон улсад эдийн засгийн өсөлт удааширсантай холбоотойгоор 2016 оны эхнээс хувьцааны зах зээл огцом бууралтыг үзүүлсэн. Тайлант оны 3 дугаар сарын байдлаар компаниудын ашгийн түвшин өмнөх оны мөн үетэй

харьцуулахад төдийлөн өсөөгүй нь АНУ-ын эдийн засаг, санхүүгийн зах зээлд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн гэсэн ойлголт хөрөнгө оруулагчдын дунд бий болсонтой холбоотой.

¹ "Schroders" хөрөнгийн удирдлагын компаниас боловсруулсан тайлан, тоо мэдээнд үндэслэн олон улсын зах зээлийн судалгааг хийсэн болно

Үүнээс улбаалан 2016 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар S&P 500 индекс 11.4 хувиар унасан байна. Гэвч газрын тосны үнэ болон макро эдийн засгийн үзүүлэлтүүд өссөн нь хувьцааны зах зээл сэргэхэд голлох нөлөөг үзүүлснээр S&P 500 индекс өсөв.

Евро бүс: 2016 оны 1 дүгээр улирлын эхний хагаст Европын зах зээл дээр хувьцааны үнэ буурч, сөрөг үзүүлэлттэй гарсан боловч улирлын сүүлийн хэдэн долоо хоногт өсчээ. MSCI EMU индекс 6.6 хувийн сөрөг өгөөжтэй байсан бол 3 дугаар сард 2.8 хувь болж өсөөд байна.

Олон улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд Хятад улсын эдийн засгийн өсөлтийн удаашрал, газрын тосны үнийн бууралт зэрэг хүчин зүйлс хүчтэй сөрөг нөлөөг үзүүлэх болсон. 2015 оны жилийн эцсийн байдлаар Европын холбооны орнуудын эдийн засаг 0.3 хувиар өссөн бөгөөд цаашид ч энэ төлөв хэвээр хадгалагдаж, эдийн засгийн өсөлт саарах хандлагатай байна. Тайлант хугацаанд инфляцын түвшин -0.2 хувьд хүрсэн нь Европын төв банк (ЕТБ)-ны зорилтот түвшин болох 2.0 хувиас хол зөрүүтэй байгаа билээ. Санхүүгийн салбарын хувьд ЕТБ-аас бодлогын хүүгээ сөрөг төлөвт оруулсан нь банкуудад дарамт болж, тэдгээрийн үйл ажиллагааны орлого, ашгийг бууруулахад хүргэжээ.

Дүрслэл 2. FTSE индекс



Эх сурвалж: londonstockexchange.com

Англи улс Европын холбооноос гарч болзошгүй гэсэн хүлээлтээс үүдэн фунт стерлингийн ханш сулрахад гол шалтгаан нь болсон бөгөөд валютын ханшийн сулрал нь хил дамнасан үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн салбарын компаниудын ашгийн түвшинг нэмэгдэхэд дэмжлэг болов.

Банкны салбарын хувьд зээлийн хүүгийн маржин буурсантай холбоотойгоор ашгийн түвшин буурсан ба цаашид зээлийн хүү бага түвшинд хадгалагдахаар байна.

2016 оны 1 дүгээр улирлын эцэст үнэт цаасны зах зээлд хувьцааны үнийн хэлбэлзэл багасч эхэлсэн бөгөөд энэ үеэс батлан хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ) өндөр компаниудын хувьцаа өсөлттэй гарчээ. Харин дундаж ЗЗҮ-тэй компаниудын хувьд 2, 3 дугаар саруудад алдагдалтай ажилласан байна.

Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд өсөлттэй гарсан бөгөөд эрчим хүчний салбартай адилаар

2 Хөрөнгө оруулалтын бондууд бол зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон өндөр чанартай бонд. Харин өндөр өгөөжтэй бондууд бол илүү эрсдэлтэй, зэрэглэл доогуур бонд

ЕТБ-ны зүгээс 3 дугаар сард мөнгөний бодлогыг хэвийн түвшинд хүргэж, банкуудад учирч буй дарамтыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талаар мэдэгдэл хийв. Дээрх бодлогын арга хэмжээнд санхүүгийн хөрөнгө худалдан авалтыг нэмэгдүүлэх, банкны салбарын бус хөрөнгө оруулалтын бондыг² дэмжих хөтөлбөр багтаж байгаа юм. Харин хадгаламжийн хүү буурч, -0.4 хувьд хүрсэн тул төв банкны зүгээс цаашид банкуудыг дэмжиж, зээл олголтыг нэмэгдүүлэх хүрээнд урт хугацааны санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо.

Англи: Тайлант хугацаанд хувьцааны зах зээл тогтвортой, хэлбэлзэл багатай гарч, 2 дугаар сарын доод түвшнөөс өссөн хэдий ч, FTSE All share индекс -0.4 хувьд хүрч буурлаа. Харин газрын тос, байгалийн хий болон хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарууд зах зээлийн үзүүлэлтэд эерэгээр нөлөөлжээ. Мөн АНУ-ын долларын ханш суларсан нь олон улсын зах зээлд бараа, түүхий эдийн ханш өсөхөд хүргэсэн, "Royal Dutch Shell" болон "BG" компаниуд нэгдсэн зэрэг нь сэргээгдэх эрчим хүчний салбар өсөлттэй гарахад гол нөлөөг үзүүлэв.

хил дамнасан үйл ажиллагаанаас ашгийн түвшинг нэмэгдүүлж чаджээ. Мөн сэргээгдэх эрчим хүчний салбарт ойрын хугацаанд сөрөг нөхцөл байдал бий болохгүй гэсэн хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд үүсээд байна.

Япон: 2016 оны 1, 2 дугаар сард Японы хувьцааны индексүүд огцом буурсан ба 3 дугаар сард сэргэн өсөлтийг үзүүлсэн хэдий ч, 1 дүгээр улирлын эцэст 12.0 хувиар буурсан. Хувьцааны зах зээлийн үзүүлэлт буурахад нөлөөлсөн гол шалтгаан нь олон улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарсан сөрөг хүчин зүйлс байсан бөгөөд 2016 оны 1 дүгээр сарын эцэст Японы төв банкны зүгээс бодлогын хүүгээ сөрөг төлөвт оруулсан нь зах зээлийн гүйцэтгэл буурахад давхар нөлөөлжээ.

Үнэт цаасны зах зээлийн үзүүлэлтүүд муудаж, өсөлт удааширсан нь хөрөнгө оруулагчдын дунд тодорхойгүй байдлыг бий болгосон ба дээр дурдсан шинэ бодлогын хүүгийн нөлөөлөл нь банкуудын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж, банкны салбар хамгийн муу гүйцэтгэлтэй салбар болсон бол үл хөдлөх хөрөнгийн зах зээлд эсрэгээр дэмжлэг болсон байна.

Дүрслэл 3. Nikkei 225 индекс



Эх сурвалж: money.cnn.com


Гадаадын хөрөнгө оруулагчид хувьцаагаа ихээр худалдах хандлага ихэссэн нь Засгийн газрын хэрэгжүүлж буй "Abenomics" бодлогын үр дүнд эргэлзэж эхэлсэнтэй холбоотой. Хэдийгээр Японы төв банкны зүгээс инфляцыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсэн ч, санхүүгийн зах зээл болон бодит эдийн засагт төдийлөн тусгалаа олж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр иенийн ханш чангарсан нь уг бодлогын оновчтой бус байдлыг тодруулсан алхам болжээ.

Ази (Японоос бусад): Азийн орнуудын хувьцааны индексүүд 2016 оны эхэнд өндөр хэлбэлзэлтэй байсан бөгөөд тайлант улирлын эцсийн байдлаар өсөлттэй гарсан байна.

2016 оны 1 дүгээр сард Хятадад долоо хоногийн дотор хоёр ч удаа хувьцааны арилжааг зогсоосон бөгөөд томоохон хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа худалдахыг хориглосон шийдвэрийн хүчинтэй хугацаа дуусгавар болж, юанийн ханш суларсан зэрэг нь Хятадын хувьцааны зах зээлийн үзүүлэлт буурахад нөлөөлөв. Үүнтэй холбоотойгоор Хятадын Засгийн газрын зүгээс хувьцаа худалдах хоригийг тодорхой хугацаанд сунгаснаар зах зээлд уналт үргэлжлэх эрсдэлийг хязгаарлажээ.

Мөн Хятадын төв банкны зүгээс заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулсан нь бодит эдийн засгийг дэмжихэд чухал алхам болсон байна.

Дүрслэл 4. CSI 300 индекс



Source: Bloomberg

BloombergBriefs.com

Эх сурвалж: bloomberg.com

Хятадад сүүлийн арваад жилийн хугацаанд хамгийн муу хөрөнгө оруулалтад тооцогдоод байсан түүхий эд боловсруулагч компаниудын хувьцаа 2016 онд огцом өссөн бөгөөд үүнд "Wuhan Iron & Steel Corporation" болон "Shaanxi Coal Industry Corporation" зэрэг компаниудын хувьцааны ханш 27.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн 2016 оны 1 дүгээр улирлын эцэст CSI 300 индекст багтсан дээрх салбарын компаниудын хувьцааны ханш 15.0, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцаа 18.0 хувиар тус тус өсөв.

Хонконгийн хөрөнгийн зах зээлийн хувьд Хятадын эдийн засгийн өсөлтийн сааралт болон хувьцааны арилжааны

өндөр хэлбэлзэл зэргээс улбаалан зах зээлийн үнэлгээ буурчээ. Тайвань улсад технологийн салбарын өндөр өсөлт нь дотоодын хувьцааны зах зээл өсөхөд голлох нөлөөг үзүүлсэн бол БНСУ-д экспортын эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор биржид бүртгэлтэй компаниудын борлуулалт, ашгийн түвшин нэмэгдэж, хувьцааны индексүүд өндөр өсөлттэй гарсан байна. Энэтхэг улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй шинэчлэлийн бодлогын удаашрал нь хувьцааны зах зээл төдийлөн өсөөгүйд нөлөөлөв.

Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо /ASEAN/-ны гишүүн орнуудаас Индонез улсын хувьцааны зах зээл эерэг

үзүүлэлттэй гарсан ба тус улсын Төв банкны хэрэгжүүлж буй мөнгөний зөөлөн бодлого үүнд голлох нөлөөг үзүүлэв. Мөн Малайз улсын хувьцааны индексүүд өсөлттэй гарчээ.

Хөгжиж буй зах зээл: 2016 оны 1 дүгээр улиралд MSCI хөгжиж буй зах зээлтэй орнуудын индекс MSCI дэлхийн индексийг гүйцэтгэлээрээ тэргүүлж, өсөлттэй гарлаа. ХНБ-аас мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэхээ хойшлуулсан болон АНУ-ын долларын ханш сулрах төлөв ажиглагдсантай холбоотойгоор хөгжиж буй зах зээл өсөлттэй гарлаа. Тухайлбал, Латин Америкийн орнуудын үнэт цаасны зах зээл харьцангуй өндөр өгөөжтэй гарсан

ба Бразил улсад улс төрийн эерэг өөрчлөлт гарна гэсэн хүлээлтээс улбаалан үнэт цаасны зах зээл нь өндөр өсөлтийг үзүүлж чаджээ.

Тайлант улиралд MSCI хөгжиж буй зах зээлтэй орнуудын индекс 5.17 хувиар өссөн нь АНУ-ын долларын ханшийн сулралт болон олон улсын зах зээл дээр газрын тосны үнэ нэмэгдсэнтэй холбоотой. АНУ болон Европын холбооны зүгээс Турк улсын урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх болсон нь тус улсын үнэт цаасны зах зээл сэргэхэд нөлөөлөв.

Дүрслэл 5. MSCI хөгжиж буй зах зээлтэй орнуудын индекс



Эх сурвалж: markets.ft.com

Хөгжиж буй зах зээлтэй Азийн орнуудаас Тайланд улсын үнэт цаасны зах зээл хамгийн өндөр өсөлттэй гарсан. Тус улсын Засгийн газрын зүгээс төсвийн зардлын хэмжээг ДНБ-ий 0.4 хувь хүртэл нэмэгдүүлэх, мөн газар тариалангийн бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх болсон нь гол нөлөөг үзүүлжээ. Хятад улсын хувьд бүс нутгийн хэмжээнд хамгийн муу гүйцэтгэлтэй үнэт цаасны зах зээлтэй орон болсон бөгөөд эдийн засгийн өсөлт удааширсан, юанийн ханш суларсан зэргээс гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн гадагшлах урсгалыг нэмэгдүүлсэн байна.

Иймд Хятадын төв банкны зүгээс эдийн засгийг эрчимжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор заавал байлгах нөөцийн шаардлагыг 0.5 хувиар бууруулж, дотоодын бондын зах зээлийг гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй болгосон нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн алхам боллоо.

1.2 БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант улиралд хөрөнгө оруулагчид эрсдэл өндөртэйгөөс илүүтэйгээр бага өгөөжтэй, эрсдэлгүй хөрөнгө оруулалтаар багцаа шинэчлэх болсонтой холбоотойгоор бондын өгөөж огцом буурсан. Тухайлбал, АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 12 дугаар сарын 2.27 хувиас 3 дугаар сарын эцэст 1.77 хувь болж буурсан байна. Английн Засгийн газрын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 1.96-аас 1.42 хувь, Германы Засгийн газрын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 0.63-аас 0.15 хувь болж тус тус буурлаа.

Харин компанийн бондын зах зээлийн хувьд, "Bank of America Merrill Lynch"-аас тооцдог олон улсын бондын индекс 2016 оны 1 дүгээр улиралд 3.3 хувийн өгөөжтэй байсан ба өнгөрсөн 3 дугаар сард хөрөнгө оруулагчдын бондын худалдан авалт нэмэгдсэн байна.

Улирлын эцэст АНУ-ын хөрөнгийн зах зээл өсөлттэй гарч, өгөөжийн түвшин нэмэгдсэн нь хөрөнгө оруулагчид өндөр эрсдэлтэй, 6.0 хувийн өгөөжтэй компанийн бондоос татгалзаж, 1-ээс 3 хувийн дундаж өгөөжтэй бондод хөрөнгө оруулах болсонтой холбоотой. Евро болон фунт стерлингээр хөрөнгө оруулсан бондын зах зээл эерэг үзүүлэлттэй гарлаа.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ 2016 - I УЛИРАЛ

Хүснэгт 1. Олон улсын санхүүгийн зах зээлийн индексийн өгөөж
2016 оны 1 дүгээр улирал

Хувьцаа	3 сар			12 сар		
	Евро	Ам.доллар	Фунт стерлинг	Евро	Ам.доллар	Фунт стерлинг
MSCI World	-4.86	-0.19	2.35	-8.49	-2.90	0.29
MSCI World Value	-4.45	0.24	2.79	-9.73	-4.21	-1.07
MSCI World Growth	-5.26	-0.62	1.92	-7.25	-1.58	1.65
MSCI World Smaller Companies	-3.90	0.80	3.37	-9.03	-3.47	-0.30
MSCI Emerging Markets	0.82	5.76	8.45	-16.78	-11.70	-8.80
MSCI AC Asia ex Japan	-2.95	1.80	4.40	-16.68	-11.59	-8.69
S&P 500	-3.39	1.35	3.93	-4.08	1.78	5.13
MSCI EMU	-6.58	-2.01	0.49	-13.03	-7.72	-4.69
FTSE Europe ex UK	-6.50	-1.92	0.58	-12.55	-7.21	-4.16
FTSE All-Share	-7.42	-2.88	-0.41	-12.33	-6.98	-3.92
TOPIX*	-10.25	-5.86	-3.46	-10.32	-4.85	-1.72

Засгийн газрын бонд	3 сар			12 сар		
	Евро	Ам.доллар	Фунт стерлинг	Евро	Ам.доллар	Фунт стерлинг
JPM GBI US All Mats	-1.44	3.38	6.02	-3.43	2.47	5.84
JPM GBI UK All Mats	-2.17	2.62	5.23	-5.64	0.13	3.41
JPM GBI Japan All Mats**	6.71	11.94	14.79	7.06	13.60	17.33
JPM GBI Germany All Mats	3.93	9.02	11.80	0.58	6.73	10.23

Компанийн бонд	3 сар			12 сар		
	Евро	Ам.доллар	Фунт стерлинг	Евро	Ам.доллар	Фунт стерлинг
BofA ML Global Broad Market Corporate	-0.18	4.71	7.38	-3.76	2.12	5.47
BofA ML US Corporate Master	-0.93	3.92	6.57	-4.83	0.98	4.30
BofA ML EMU Corporate ex T1 (5-10Y)	3.23	8.29	11.05	0.64	6.78	10.19
BofA ML Non-Gilts	-4.24	0.45	3.01	-8.37	-2.78	0.42

Хөрөнгө оруулалтын бус бондууд	3 сар			12 сар		
	Евро	Ам.доллар	Фунт стерлинг	Евро	Ам.доллар	Фунт стерлинг
BofA ML Global High Yield	-0.93	3.92	6.57	-6.46	-0.75	2.51
BofA ML Euro High Yield	1.77	6.76	9.48	-0.47	5.61	9.08

*-12.04% үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцов

Эх сурвалж: Datastream

**4.59% үндэсний мөнгөн тэмдэгтээр тооцов.

БҮЛЭГ 2.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ, БАЙДАЛ

Уул уурхайн салбарын супер мөчлөг дуусгавар болсон нь хөгжиж буй орнууд тэр дундаа уг салбараас хамаарал бүхий манай орны хувьд томоохон сорилтыг үүсгэж, макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдэд шууд нөлөөлөв.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2016 оны эхний улиралд 2,937.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 3.1 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 10.7 хувь, үүнээс уул уурхайн салбарынх 16.2 хувь, хөдөө аж ахуйн салбарынх 3.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. 2016 оны эхний улиралд ДНБ оны үнээр 4,705.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 хувиар өссөн байна.

Мөнгөний захын үзүүлэлтүүд (M2): Мөнгөний нийлүүлэлт өссөн дүнгээр 10.1 их наяд төгрөг болж, өмнөх сарынхаас 1.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.1 хувиар өсчээ. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 658.6 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 0.5 хувиар өссөн бол өмнөх оны мөн үеийнхээс 6.3 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 11.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх сарынхаас 1.7 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 3.6 хувиар буурсан бол хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл тайлант хугацаанд 967.6 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 2.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 72.9 хувиар өсчээ.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлсэн нь өмнөх сарынхаас 0.3 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 3.6 пунктээр нэмэгдсэн байна. Банкны системийн чанаргүй зээл өссөн дүнгээр 965.4 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 6.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 37.3 хувиар тус тус өсч 8.2 хувьтай гарлаа.

Улсын төсөв: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 1,095.2 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1,710.9 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 615.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Энэ үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 471.1 тэрбум төгрөгөөр өссөн ба үүнд орлого 10.8 хувиар буурч, зарлага 24.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

- Нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар 2.4-36.0 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч бусад татвар, төлбөр хураамж 52.8 хувь,

орлогын татвар 29.2 хувиар тус тус буурав. Улсын нэгдсэн төсвийн орлогын 88.8 хувийг татварын орлого, 11.2 хувийг татварын бус орлого эзэлжээ.

- Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1,710.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 24.6 хувиар өссөн. Үүнд урсгал зардал 187.2 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 134.3 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 48.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 83.6, хөрөнгийн зардал 15.8 хувийг тус тус эзэлжээ.

Гадаад худалдаа: Монгол Улс 2016 оны эхний улиралд дэлхийн 115 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 1,558.0 сая ам.долларт хүрснээс экспорт 959.0 сая ам.доллар, импорт 599.1 сая ам.доллар байлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 221.4 сая ам.доллар буюу 12.4 хувиар буурчээ.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний үнийн индекс 2016 оны 3 дугаар сард өмнөх сарынхаас 0.5 хувь, өмнөх оны эцсийнхээс болон өмнөх оны мөн үеийнхээс тус бүр 1.7 хувиар улсын хэмжээнд өссөн дүнтэй байна.

Төлбөрийн тэнцэл: Урсгал данс 11.0 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 141.0 сая долларын ашигтай гарч, нийт төлбөрийн тэнцэл 38.0 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц энэ дүнгээр буурчээ. Улсын нөөцийн хэмжээ 1,546.3 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Гадаад өрийн үзүүлэлт: Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл тайлант улирлын эцэст 22,599.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар нэмэгджээ. Энэхүү өсөлтийн 30.0 хувийг Засгийн газрын гадаад өр, 13.0 хувийг Төв банкны гадаад өглөг, 30.0 хувийг банкуудын гадаад өр, 8.0 хувийг бусад сектор (аж ахуйн нэгж, иргэд, Хөгжлийн банк)-ын гадаад өр, 19.0 хувийг гадаадын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгжийн толгой компаниасаа авсан зээл эзэлжээ.

Гадаадын хөрөнгө оруулалт: 2016 оны 1 дүгээр улиралд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 165.0 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 278.0 сая ам.доллараар өссөн байна. Үүнд, аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн санхүүжилт өнгөрсөн оны түвшнээс 309.0 сая ам.доллараар нэмэгджээ.

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл, өмнөх оны мөн үеэс БНХАУ, БНСУ-ын хөрөнгө оруулалт 147.0, 96.0 хувиар тус тус буурсан бол Япон улсын хөрөнгө оруулалт 35.0 хувиар өсчээ.

Салбараар нь үзвэл, уул уурхайн салбарт нийт хөрөнгө оруулалтын 38.9 хувь (64.7 сая ам.доллар), бөөний болон жижиглэн худалдааны салбарт 24.6 хувь, үйлчилгээний бусад салбарт 9.4 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтад 9.1 хувь, мэргэжлийн шинжлэх ухаан, технологийн салбарт 5.7 хувь тус тус хамаарч байна.

Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үндэсний компаниудын хувьцааны үнэ 2016 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеийн хаалтын ханштай харьцуулахад дунджаар 35.0 хувиар буурсан үзүүлэлттэй байлаа.

БҮЛЭГ 3.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

ОРШИЛ

“Их 20”-ийн 2008 оны уулзалтаас “Санхүүгийн системийн шинэчлэл”-ийн хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөр батлагдсанаар олон улсын санхүүгийн хямралын үндсэн шалтгааныг арилгах, санхүүгийн салбарыг илүү нээлттэй, тогтвортой болгон уг салбарын бодит эдийн засагт гүйцэтгэх үр ашгийг дээшлүүлэн санхүүжилтийн эх үүсвэрийн эрсдэлийг багасгах боломж бүрдсэн.

Дээр дурдсан санхүүгийн системийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд 2009 онд “Их 20”-оос Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /Financial Stability Board/ (СТБЗ)-ийг үүсгэн байгуулсан ба тус зөвлөл олон улсын санхүүгийн системд хяналт тавих, зохицуулалтын хүрээг тодорхой болгох, шаардлагатай хөгжлийн бодлогыг боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

2008 оны хямралаас өмнө АНУ-ын санхүүгийн зах зээл их хэмжээгээр тэлсэн ба банкны салбараас олгосон зээл, өр төлбөрийн хэмжээ хурдацтай нэмэгдэж, өрийн зохих удирдлага алдагдсанаас улбаалан санхүүгийн системд томоохон эрсдэлийг бий болгосон нь хямрал нүүрлэх гол шалтгаан болжээ.

Тухайн үед зохицуулагч байгууллагуудын зүгээс банкны салбарт үүсээд байсан эрсдэлийг урьдчилан илрүүлж чадаагүй бөгөөд АНУ-ын санхүүгийн системийн хямрал олон улсын зах зээлд маш хүчтэй нөлөөлсөн. Үүнтэй холбоотойгоор санхүүгийн зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын тоо эрс буурч, улмаар системийн ач холбогдол бүхий санхүүгийн байгууллагууд төлбөрийн чадваргүй болж, үйл ажиллагаа нь доголдсон байна.

Энэ үед Засгийн газрын зүгээс төлбөрийн чадваргүй болсон зарим санхүүгийн байгууллагыг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, хамгаалснаар Засгийн газрын зардлыг

нэмэгдүүлж, төсвийн алдагдал өссөн. Нөгөөтэйгүүр санхүүгийн хямрал нь АНУ-ын эдийн засгийн өсөлтийг удаашрахад хүргэж, иргэд, аж ахуйн нэгжүүд хүндрэлтэй нөхцөл байдалд орсон ба макро эдийн засгийн үзүүлэлтүүд эргэн сайжирч, эдийн засаг сэргэх үйл явц нилээд урт хугацаанд үргэлжилсэн.

2008 оны санхүүгийн хямралаас хойшхи хугацаанд СТБЗ-ийн гишүүн орнууд хямралын үндсэн шалтгааныг тодорхойлох, өргөн хүрээний санхүүгийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхээр нэгдсэн шийдэлд хүрсэн бөгөөд илүү уян хатан, тогтвортой санхүүгийн байгууллага, зах зээлийг бий болгох, хэт томоос уналт бий болох “too big to fail”- үйл явцыг дуусгавар болгох, үүсмэл санхүүгийн зах зээлийн эрсдэлийг бууруулах, “сүүдрийн банкны систем”-ийг зах зээлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх зэрэг 4 үндсэн чиглэлээр хэтийн зорилгоо тодорхойлсон.

Цаашид санхүүгийн системд үүсэх эрсдэлийг бууруулж, бодит эдийн засагт хүндрэл учруулах санхүүгийн тогтворгүй байдлыг үүсгэхгүй байхад санхүүгийн системийн шинэчлэл маш чухал бөгөөд “Их 20”-ийн зүгээс уг шинэчлэлийг эхлүүлсэн нь цагаа олсон бодлогын арга хэмжээ болжээ. СТБЗ нь санхүүгийн системийг шинэчлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үйл явцын талаар “Их 20”-д тухай бүр тайлагнах үндсэн үүрэгтэй. Энэхүү чиг үүргээ цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор СТБЗ нь 2011 онд санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтын хүрээг тодорхойлон ажиллаж байна.

СТБЗ-д нийт 24 орон, 1 бүс нутгийн холбоо гишүүнээр бүртгэлтэй байгаа ба гишүүд нь СТБЗ-өөс баталсан бодлогын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй. Мөн олон улсын санхүүгийн 4, стандарт тогтоох олон улсын 6 байгууллагатай хамтарч ажилладаг.

Хүснэгт 2. СТБЗ-ийн гишүүн орнууд, түнш байгууллагууд

Гишүүн орнууд		Олон улсын санхүүгийн байгууллагууд		Стандарт тогтоох байгууллагууд	
1	Аргентин	1	Олон улсын валютын сан	1	Базелийн хороо
2	Австрали				
3	Бразил				
4	Солонгос				
5	Мексик				
6	Голланд	2	Дэлхийн банк	2	Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбоо (IAIS)
7	ОХУ				
8	Канад				
9	Сауди Араб				
10	Хятад				
11	Сингапур	3	ЭЗХАХБ (OECD)	3	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)
12	Өмнөд Африк				
13	Франц				
14	Испани				
15	Герман				
16	Швейцар	4	Олон улсын төлбөр тооцооны банк (BIS)	4	ОУ-ын санхүүгийн системийн хороо (CGFS)
17	Хонг Конг				
18	Турк				
19	Энэтхэг				
20	Индонез				
21	Итали	6		5	ОУ-ын НББ-ийн стандартын зөвлөл (IASB)
22	Япон				
23	Их Британи				
24	АНУ				
25	Европын холбоо				
				6	Зах зээлийн дэд бүтэц, төлбөрийн хороо (CPMI)


3.1. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЭЧЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

2008 оны санхүүгийн хямрал нь дэлхийн эдийн засагт хүчтэй сөрөг нөлөөг үзүүлж, зардлыг их хэмжээгээр


нэмэгдүүлсэн. Тухайлбал, Засгийн газруудын өр, төлбөр, төсвийн алдагдал ихэссэн, ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт буурсан зэрэг хүчин зүйлс нь зардал өсөхөд шууд нөлөөлсөн ба гол төлөв хөгжиж буй зах зээлтэй орнуудад хүчтэй мэдрэгдсэн байна.

Дүрслэл 6. Хямралаас улбаалсан зардлын хэмжээний өсөлт


ЗГ-ын өр төлбөр (ДНБ-д %)



Бүтээгдэхүүний гарц (%)



Ажилгүйдлийн түвшин (%)



Эх сурвалж: fsb.org

“Их 20”-оос олон улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, хил дамнасан хяналт, зохицуулалтыг сайжруулах, нээлттэй, нэгдмэл санхүүгийн системийг бий болгох, эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх

зорилтын хүрээнд боловсруулсан “Санхүүгийн системийн шинэчлэл”-ийн хөтөлбөрт дараах үндсэн 4 чиглэл тусгагдсан. Үүнд:

I	Санхүүгийн байгууллагуудыг илүү тогтвортой, уян хатан болгох
II	Системийн ач холбогдол бүхий санхүүгийн байгууллагуудыг төлбөрийн чадваргүй болох, дампуурахаас сэргийлэх
III	Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг улам найдвартай, аюулгүй болгох
IV	Сүүдрийн банкны системийг зах зээлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлэх

3.2. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ТОГТВОРТОЙ, УЯН ХАТАН БОЛГОХ

2010 онд “Их 20”-ийн зүгээс банкуудын өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын үзүүлэлтийг сайжруулах зорилтын хүрээнд Базелийн хороог банкны стандарт, дүрэм, журмыг тогтоох, мөрдүүлэх олон улсын зохицуулагч байгууллагаар тодорхойлсон.

“Их 20” болон СТБЗ-ийн бүх гишүүд санхүүгийн хямрал, эдийн засгийн хүндрэлээс сэргийлэхийн тулд Базелийн хорооноос тогтоосон стандартын дагуу холбогдох дүрэм, журмаа шинэчлэн мөрдөж эхэлсэн бөгөөд гишүүд хоорондоо өөрийн орны санхүүгийн зах зээлд тулгарсан саад бэрхшээлийг гэтлэх, зохицуулалтын орчныг сайжруулахад авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний талаар тухай бүр туршлага солилцон хамтран ажилладаг.

2008 оны хямралын үед системийн ач холбогдолтой олон улсын санхүүгийн байгууллага (Global Systemically Important Financial Institutions)-д тооцогдох томоохон хөрөнгө оруулалтын банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ эрс буурсантай холбоотойгоор 2019 он гэхэд банкууд Базелийн хорооноос тогтоосон шинэ зохистой харьцааны шаардлагуудыг мөрдөж дуусахаар болсон. Тухайлбал, СТБЗ-ийн бүх гишүүдэд Базел III стандартын эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг албан журмаар шууд мөрдүүлэх шаардлага тавигдсан ба энэ хүрээнд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцаа (liquidity coverage ratio), санхүүгийн хөшүүргийн харьцаа болон системийн

ач холбогдолтой банкны хүрээг тодорхойлох зэрэг зохицуулалтын төслүүдийг эцэслээд байна.

Базелийн хорооны зүгээс СТБЗ-ийн 7 гишүүн орны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг үнэлж, Базел III-ын стандарттай нийцсэн гэсэн дүгнэлтийг гаргасан. Мөн сүүлийн жилүүдэд Базелийн хорооноос Базел III стандартын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулж дууссан ба хөшүүргийн харьцаа гэдгийг юу гэж тодорхойлох вэ гэдэг дээр нэгдсэн зөвшилцөлд хүрч, цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (Net Stable Funding Ratio)-ны стандартыг баталжээ.


Санхүүгийн байгууллагуудыг илүү тогтвортой, уян хатан болгох асуудал нь зөвхөн банкны салбарт хамаарах бус, Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбоо (International Association of Insurance Supervisors)-ноос 2013 онд олон улсын даатгалын компанийн эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн стандартыг боловсруулж эхэлсэн бөгөөд 2016 оны эцэст уг стандартыг батлахаар төлөвлөж байна.

БАЗЕЛ III СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ

- СТБЗ-ийн нийт 24 гишүүн орон Базел III стандартын эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг мөрдөж байна;
- Нийт 22 гишүүн оронд төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцааны журам мөрдөгдөж байна (Зах зээлийн 98.0 хувь);

- Олон улсын системийн ач холбогдолтой санхүүгийн байгууллагуудын төв байрладаг 10 гишүүн орноос 9 оронд их алдагдлаас хамгаалах шаардлага (higher loss absorbency requirements)-ыг мөрдүүлэхээр болсон ба 2016 оны эхнээс хэрэгжиж эхэлсэн;
- Нийт 14 гишүүн орны системийн ач холбогдолтой санхүүгийн байгууллага (САХСБ)-д мөрдөх их алдагдлаас хамгаалах шаардлага болон үнэлгээний аргачлалыг 2016 оны эхнээс хэрэгжүүлж эхэлсэн (Зах зээлийн 45.0 хувь).

Дүрслэл 7. Банкуудын өөрийн хөрөнгө болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны өөрчлөлт



Эх сурвалж: fsb.org

Дүрслэлээс, Базел III стандартын хэрэгжилтийн үйл явц үр дүнтэй явагдаж байгаа ба олон улсын банкууд үйл ажиллагаагаа шинэ стандарт, шаардлагад нийцүүлэн явуулж эхлээд байгаа нь харагдаж байна. Тухайлбал, олон улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг томоохон банкууд эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн доод хэмжээг бүрэн хангасан бөгөөд эдгээр банкуудын 80.0 хувь нь төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцаа болон цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааны хамгийн бага шаардлагуудыг бүрэн биелүүлжээ.

САХСБ-ын үйл ажиллагааны доголдол нь эргээд зохицуулагч байгууллагууд урт хугацаанд үргэлжлэх санхүүгийн системийн тогтворгүй байдлаас хамгаалах арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагыг бий болгодог ба энэ үед "too big to fail" гэсэн ойлголт хэрэгждэг. "Их 20"-оос өгсөн чиглэлийн дагуу СТБЗ-ийн зүгээс "too big to fail" асуудлыг шийдвэрлэхийн тулд зохицуулалтын орчны хүрээг тодорхойлж, бусад олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтран бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн ба хэрэгжилтийн явцад тухай бүр хяналт тавьж, "Их 20"-д ажлаа тайлагнаж байна.

3.3. СИСТЕМИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САНХҮҮГИЙН БАЙГУУЛАГУУДЫГ ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БОЛОХ, ДАМПУУРАХААС СЭРГИЙЛЭХ

"Lehman Brothers" банкны дампуурал болон зарим компаниудыг төлбөрийн чадваргүй болохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсний дараахан дэлхийн томоохон орнууд санхүүгийн салбарын зохицуулалтын орчноо сайжруулах шаардлагатай гэж үзсэн. 2010 оны "Их 20"-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр тэргүүлэгч орнуудын зүгээс олон улсын системийн ач холбогдолтой санхүүгийн байгууллага (САХСБ)-уудад тулгараад байгаа асуудал болон эрсдэлийг тодорхойлж, төлбөрийн чадваргүй болох, дампуурахаас сэргийлэхийн тулд зохицуулалтын орчныг сайжруулах бодлогын дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг СТБЗ-д үүрэг болгосон.

СТБЗ-өөс САХСБ-ын санхүүгийн системд учруулах эрсдэлийг бууруулахын тулд дараах 3 төрлийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

1	Хууль, эрх зүйн орчинг сайжруулж, зохицуулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэн хил дамнансан үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагад мөрдүүлэх ба ингэснээр эдгээр байгууллагууд дампуурсан тохиолдолд татвар төлөгчдөд учрах хүндрэлийг сааруулах
2	САХСБ-ын санхүүгийн систем, эдийн засагт учруулах хохирлын нөлөө их тул алдагдлаас хамгаалах шаардлагуудыг мөрдүүлснээр эрсдэлийг бууруулах
3	Олон улсын хэмжээнд зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн хил дамнансан санхүүгийн үйл ажиллагаанд үр дүнтэй зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэх

СТБЗ-ийн зарим гишүүн орнууд зохицуулалтын шинэчлэлийг эхлүүлээд байгаа хэдий ч, цаашид зохицуулагч байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн СТБЗ-ийн зүгээс “Их 20”-ийн гишүүн орнуудад 2015 онд баталсан зохицуулалтын чиглэлийг удирдлага болгон санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчинд шинэчлэл хийж, олон улсын стандарт тогтоох байгууллагын стандартуудыг хэрэгжүүлэх шаардлагатай мэдэгдээд байна.

Банкуудын хувьд бүтцийн өөрчлөлт хийж, шинэ стандартуудыг мөрдөх шаардлагатай ба ингэснээр ирээдүйд учирч болох эрсдэлийг тодорхой түвшинд бууруулахаас гадна зохицуулагч байгууллагууд хил дамнасан хяналтыг хэрэгжүүлэхэд чухал. Нөгөөтэйгүүр санхүүгийн нэгдэлд тавих хяналтыг сайжруулахын тулд олон улсын түвшинд нэг стандарт, ижил зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Бүтцийн өөрчлөлт, шинэчлэл нь САХСБ-ын эрсдэлийн түвшинг тодорхойлж, томоохон хэмжээний алдагдлаас хамгаалах механизмыг хэрэгжүүлэх давуу талтай бөгөөд тухайн улс оновчтой бүтцийн бодлогыг хэрэгжүүлснээр бүс нутгийн хэмжээнд мэдээлэл харилцан солилцож, туршлага хуваалцах боломж бүрдэнэ. Энэ хүрээнд СТБЗ-ийн гишүүн орнууд хил дамнасан хамтын ажиллагааг өргөжүүлэн санхүүгийн системийн хэмжээнд хүчтэй нөлөөлж болохуйц эрсдэлд хяналт тавин ажиллаж байна.

Олон улсын хэмжээний санхүүгийн байгууллагад тавих хяналт, шалгалтыг сайжруулах нь САХСБ-ын зохицуулалтын хүрээний чухал хэсгийн нэг боловч хэрэгжүүлж буй бусад зохицуулалтын арга хэмжээтэй харьцуулахад төдийлөн хангалттай бус байна. Хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зохицуулагч байгууллагууд өөрсдөө санхүүгийн болон чадварлаг хүний нөөцтэй, хараат бус байдлыг хангасан тохиолдолд САХСБ-ыг зохистойгоор хянаж, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

- Олон улсын системийн ач холбогдолтой банк (САХБ)-нд мөрдөгдөж байгаа их хэмжээний алдагдлаас хамгаалах шалгуур үзүүлэлт болон ил тод, нээлттэй байдал, санхүүгийн тайлагналтай холбоотой Базелийн хорооноос тогтоосон журмын хэрэгжилт хангалттай түвшинд хүрсэн (Базел III);
- Томоохон банкууд эрсдэлийн тоон мэдээллийн бааз суурийг үүсгэж, эрсдэлийн шинжилгээг тогтмол хийн Базелийн хороонд тайлагнадаг болсон;
- СТБЗ-ийн зүгээс САХБ-д ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалах бүрэн чадавхитай эсэхэд хяналт тавихын тулд олон улсын хэмжээнд нийт алдагдлаас хамгаалах чадавх (total loss-absorbing capacity)-ийг тогтоосон журмыг мөрдүүлэх болсон ба үнэлгээгээр эерэг үр дүн гарч эхэлсэн;
- САХБ-ны зохицуулалтын хүрээ, хяналт, шалгалтын хэрэгжилт сайжирч байгаа хэдий ч, олон улсын хэмжээнд хил дамнасан хяналтыг эрчимжүүлэх шаардлага байсаар байна.

Дүрслэл 8. СТБЗ-ийн гишүүдийн зохицуулалтын дэглэм (гишүүдийн тоо, хувиар)



Эх сурвалж: fsb.org

Дүрслэлээс харахад, зохицуулалтын байгууллагууд банкны салбарт тавих зохицуулалтын чиг үүрэг, эрх мэдлээ сайжруулах ажиллагааг олон улсын түвшинд эрчимжүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна. Хэдийгээр олон улсын САХБ-ын ихэнх нь нөөц төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн нэгжтэй болоод байгаа ч, цаашид үйл ажиллагаандаа мөрдөх стратеги, төлөвлөгөөгөө шинэчлэх хэрэгтэй. Харин САХБ-ын төвүүд байрлаж буй СТБЗ-ийн цөөн гишүүн орнуудын зүгээс банкинд тавих зохицуулалтын чиг үүрэг, эрх мэдлээ тус зөвлөлөөс баталсан зохицуулалтын хүрээний дэглэмтэй нийцүүлэн нэмэгдүүлсэн байна.

НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОХ ШААРДЛАГА

Зохицуулагч байгууллагууд системийн хэмжээнд учрах эрсдэлийг үр дүнтэйгээр удирдахын тулд зохицуулалтын зөрүү /давхардал, эсхүл зохицуулалтгүй орон зай/-г үүсгэхээс аль болох зайлсхийх шаардлагатай тулгардаг. Өөрөөр хэлбэл, зохицуулагч байгууллага зөвхөн нэг салбарт хяналтаа өндөрсгөж, ач холбогдол өгөх нь зохицуулалтын хүрээнд хамрагдаж буй санхүүгийн байгууллагууд зохицуулалт бага байгаа өөр салбарт үйл ажиллагаагаа идэвхжүүлдэг байна.

Санхүүгийн системд хийгдэх шинэчлэлийн бодлого нь зохицуулалтын хүрээг оновчтой тодорхойлсон байхаас гадна санхүүгийн зах зээлийг бүхэлд нь хамарсан үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ зарчмын дагуу СТБЗ-өөс “too big to fail” асуудлыг дуусгавар болгох бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хэлбэр, төрлөөс нь үл хамааран “Системийн хувьд ач холбогдолтой” гэж тодорхойлогдсон бүх санхүүгийн байгууллагуудыг хяналтад хамруулсан. Мөн “Сүүдрийн банкны систем”-ийн зохицуулалт, хяналтыг нэмэгдүүлэх нь зохицуулалтын зөрүүг багасгах талаар хэрэгжүүлж буй бодлогын тэргүүлэх зорилт болоод байна.

3.4. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НАЙДВАРТАЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Үүсмэл санхүүгийн хэрэгслийн биржийн бус зах зээлийн зохицуулалт сул байсан нь 2008 оны санхүүгийн хямрал болоход нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болсон ба түүний сөрөг нөлөөлөл нь макро эдийн засаг, санхүүгийн системийг тогтворгүй байдалд хүргэсэн. Тухайн үед зах зээлд оролцогчдын үүсмэл санхүүгийн хэрэгслийн биржийн бус зах зээл дээрх багцын тоо, хэмжээний талаар зохицуулагч байгууллагууд хангалттай мэдээлэлгүй байснаас системийн хэмжээний эрсдэлийн түвшинг үнэлэх боломжгүйд хүрчээ.

2009 онд “Их 20”-ийн ээлжит уулзалтаар биржийн бус үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээл дэх ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, системийн хэмжээний эрсдэлийг урьдчилан тооцож, зах зээлд гарах аливаа зөрчлөөс хамгаалах зорилгоор шинэчлэлийн хөтөлбөрийг баталсан.

Хөтөлбөрийн дагуу “Их 20”-ийн гишүүн орнууд биржийн бус үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд арилжаалагдаж буй бүх гэрээнүүдийн талаар арилжаа, гүйлгээг бүртгэгч байгууллага буюу “Trade repositories”-д тайлагнах, бүх стандартчилагдсан гэрээг бирж, эсхүл электрон арилжааны платформ дээр арилжаалах, төлбөр тооцооны дундын зуучлалын төв (ССР)-өөр төлбөр тооцоог гүйцэтгүүлэх, уг байгууллагаар төлбөр тооцоо нь хийгдээгүй гэрээний маржин болон хөрөнгийн шаардлагуудыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг 2012 оны эцэс гэхэд хэрэгжүүлж дуусахаар тохирсон.

Биржийн бус үүсмэл санхүүгийн зах зээлийн шинэчлэл удаан хугацаанд явагдаж байгаа хэдий ч, зохицуулалтын хүрээнд тодорхой ахиц дэвшил гарч эхлээд байна. Тухайлбал, үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бирж болоод электрон арилжааны платформоор арилжаалж эхэлсэн нь зах зээлд оролцогчдын эрсдэлийн түвшинг системийн хэмжээнд удирдах боломжтой болов. Мөн төлбөр, тооцооны дундын зуучлалын төв (ССР)-өөр хийгдсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний тоо хэмжээ эрс нэмэгдсэн.


Үүсмэл санхүүгийн зах зээлийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомж, зохицуулалтын орчныг сайжруулах нь эхний алхам бөгөөд гишүүн орнуудын хувьд уг ажиллагаа дуусах шатандаа явагдаж байна. Мөн олон улсын зах зээлд улс орнууд нэг стандарт, журмын зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай ба энэ ажлын хүрээнд гишүүн орнууд хил дамнасан хамтын ажиллагааг өргөжүүлэн олон улсын үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд нэг стандартыг мөрдүүлэх ажлыг эхлүүлээд байна.

БИРЖИЙН БУС ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ШИНЭЧЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

- Төлбөр тооцоог гүйцэтгэгч дундын зуучлагчаар хийгдээгүй гэрээний хувьд барьцаат хөрөнгийн, арилжааны тайлагналын шаардлага өндөрсөн ба дундын төлбөр тооцооны зуучлагч байгууллагаар хийгдэх арилжааны дүн нэмэгдсэн;

- СТБЗ-ийн 3 гишүүн орноос бусад бүх гишүүдэд арилжааны тайлагналын шаардлага мөрдөгдөж эхэлсэн;
- 12 гишүүн орнууд стандартчилагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн төлбөр тооцоог зөвхөн дундын төлбөр, тооцооны байгууллагаар гүйцэтгүүлэхээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулаад байгаа ба эдгээр орнууд зах зээлийн 90.0 хувийг эзэлж байна;
- 8 гишүүн орнууд стандартчилагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг бирж болон электрон арилжааны платформоор гүйцэтгүүлж байгаа ба зах зээлийн 90.0 хувийг эзэлжээ;
- Ихэнх гишүүн орнуудын хувьд төлбөр, тооцоо нь дундын төлбөр тооцооны байгууллагаар хийгдээгүй үүсмэл санхүүгийн хэрэгсэлд тавигдах маржингийн зохицуулалтыг мөрдүүлэх ажил эхлэлийн үе шатанд явагдаж байгаа ба 2016-аас 2019 оны хооронд хэрэгжүүлж дуусгах төлөвтэй байна.

Дүрслэл 9. Томоохон үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй орнуудад хэрэгжилт сайн байна




Эх сурвалж: fsb.org

Олон улсын түвшинд төлбөр тооцоо гүйцэтгэгч дундын байгууллага, арилжааны тайлагналын хэрэглээ өсч байна. Тухайлбал, зээлийн хүү, гадаад валютын арилжааны тайлагнал, дундын зуучлалын төвөөр хийгдэж буй зээлийн хүүгийн үүсмэл санхүүгийн хэрэгслийн төлбөр тооцоо хамгийн өндөр дүнтэй байна.

Дүрслэл 10. ССР, арилжааны тайлагналын хэрэглээ

Арилжааны тайлагнал хувиар Их наяд евро



Эх сурвалж: fsb.org

СТБЗ-ийн гишүүн орнууд төлбөр тооцоо гүйцэтгэгч дундын зуучлалын төв болон арилжааны тайлагналын зохицуулалтуудаа Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын Зах зээлийн дэд бүтэц, төлбөрийн хорооноос баталсан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-тай нийцүүлэн боловсруулж эхлэв.

3.5. СҮҮДРИЙН БАНКНЫ СИСТЕМИЙГ ЗАХ ЗЭЭЛД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ

2014 оны байдлаар СТБЗ-ийн 25 гишүүн болон судалгаанд хамрагдсан 1 орон³ нийлээд дэлхийн санхүүгийн системийн нийт хөрөнгийн 90.0 хувь, дэлхийн эдийн засгийн 80.0 хувийг тус тус бүрдүүлж байна. “Shadow banking system” буюу сүүдрийн банкны тогтолцоо нь санхүүгийн болон зээлийн зуучлалын үйлчилгээг банкнаас бусад санхүүгийн байгууллага, хуулийн этгээд зохицуулалтын гадуур үзүүлэхийг ойлгодог.⁴ Банкны системээс гадуурх зээлийн зуучлалын үйлчилгээ нь иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр болсноор бодит эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болдог.

Сүүдрийн банкны зээл, санхүүгийн зуучлалын суваг нь банкны системтэй дотоод үйл ажиллагаагаараа холбогдож, банкны үзүүлж буй (санхүүгийн хөшүүрэг, хөрвөх чадварын шилжүүлэлт-богино хугацаанд депозит татан урт хугацааны зээлийг санхүүжүүлэх, бусад санхүүгийн үйлчилгээ)-тай ижил үйлчилгээ үзүүлснээр санхүүгийн системд их хэмжээний эрсдэл учруулах аюулд хүргэдэг.

Олон улсын зохицуулагч байгууллагуудын зүгээс сүүдрийн

банкны санхүүгийн системд учруулах эрсдэлийн түвшинг тодорхойлж, зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлсэн. Сүүдрийн банкны үйл ажиллагаа зохицуулалтгүй тул ёс зүйн алдаа, зөрчил гарах явдал элбэг тохиолдож байгаа бөгөөд өнөөгийн нөхцөлд Засгийн газар, төв банкуудаас банк бус зээлийн зуучлалын үйл ажиллагаанд санхүүгийн баталгаа өгөх ямар ч боломжгүй юм.

СТБЗ-өөс олон улсын стандарт тогтоох байгууллагуудтай хамтран сүүдрийн банкны систем дэх эрсдэлийг тогтоож, хяналт тавих зорилгоор “системийн хэмжээнд хяналт тавих хүрээ”-г боловсруулсан бөгөөд сүүдрийн банкны хяналт, зохицуулалтыг сайжруулах хүрээнд дараах 5 бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд:

1	Сүүдрийн банктай үйл ажиллагаагаараа холбогдсон банкуудын эрсдэлийг бууруулах
2	Мөнгөний зах зээлийн сангуудын эрсдэлд өртөгдөх байдлыг бууруулах
3	Санхүүгийн хэрэгслийн үнэт цаасжуулалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх
4	Үнэт цаасны санхүүжилтийн арилжааны эрсдэлийг бууруулах
5	Бусад сүүдрийн банкны байгууллагын эрсдэлийн түвшинг тодорхойлж, үнэлгээ хийх ажиллагааг эрчимжүүлэх

Мөн СТБЗ-ийн зүгээс сүүдрийн банкны системийг тодорхойлох нарийвчилсан болон өргөн хүрээний аргачлалыг боловсруулсан нь сүүдрийн банкны эрсдэлийг үнэлж, эрсдэлд суурилсан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд дөхөм болсон.

НАРИЙВЧИЛСАН АРГАЧЛАЛ

Энэхүү аргачлал нь банк бус санхүүгийн байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааг эдийн засгийн гүйцэтгэх үүргээр нь ангилж, үнэлгээ хийхэд чиглэгдсэн. Уг аргачлалаар

³ 2015 онд СТБЗ-өөс “Олон улсын Сүүдрийн банкны хяналтын тайлан”-г гаргахдаа анх удаа Ирландыг оруулж, судалгааг хийсэн.

⁴ Зарим санхүүгийн зах зээлийн зохицуулагч, оролцогчид Сүүдрийн банкны оронд “зах зээлд суурилсан санхүүжилт” гэж хэрэглэх тохиолдол байдаг. “Их 20” болон СТБЗ зохицуулалтын орчны шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд “Сүүдрийн банк” гэсэн нэршлийг хэрэглэж байгаатай холбоотойгоор түгээмэл хэрэглэгдэх болжээ.

тооцоход 2014 онд СТБЗ-ийн 25 гишүүн болон судалгаанд хамрагдсан 1 орны нийт сүүдрийн банкны системийн хэмжээ 36.0 их наяд ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь эдгээр гишүүн орнуудын ДНБ-ий 59.0 хувьтай тэнцэж байна. Мөн сүүлийн хэдэн жилийн хугацаанд сүүдрийн банкны систем өсч, олон улсын санхүүгийн системийн 12.0 хувьд хүрчээ.

Сүүдрийн банкны нийт хөрөнгийн 80-аас илүү хувь нь өндөр хөгжсөн эдийн засагтай Хойд Америк, Ази, хойд Европын орнуудад төвлөрч байна.

Шинэ аргачлалаар тооцоход хамтын хөрөнгө оруулалтын хэрэгсэл (мөнгөний зах зээлийн сан, хэдж сан, бусад хөрөнгө оруулалтын сангууд)-тэй холбоотой зээлийн зуучлал сүүдрийн банкны системийн 60.0 хувийг бүрдүүлсэн ба өнгөрсөн 4 жилийн хугацаанд дунджаар 10.0 хувиар өсөөд байна. Харин санхүүгийн хямрал болоход гол нөлөөлсөн хүчин зүйлсийн нэг болох үнэт цаасжуулалтад суурилсан зээлийн зуучлалын үйл ажиллагаа буурчээ. Нийт дүнгээр нь авч үзвэл, банк болон банк бус санхүүгийн системийн (бусад санхүүгийн зуучлагч байгууллагуудыг оролцуулахгүйгээр⁵) хоорондын харилцан хамаарал хямралын өмнөх оргил түвшингээс буурсан.

Сүүдрийн банкны системийн эрсдэлийг тооцоход статистик тоон мэдээллийн олдоц хангалтгүй түвшинд байгаа нь ихээхэн хүндрэл учруулж байна. Иймээс СТБЗ-ийн зүгээс гишүүн орнуудад санхүүгийн системийн хэмжээнд эрсдэлийг эрт илрүүлж, бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн үүргийн шинэ аргачлалыг хэрэгжүүлэх чиглэлийг өгөөд байна.

ӨРГӨН ХҮРЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Monitoring Universe of Non-Bank Financial Intermediation (MUNFI) буюу Банк бус санхүүгийн зуучлалын нэгдмэл хяналтын аргачлалаар тооцоход, сүүлийн хэдэн жилийн хугацаанд бусад санхүүгийн зуучлалын байгууллага (БСЗБ), тэтгэврийн сан, даатгалын компаниудын хөрөнгө 9.0 хувиар өсч, нийт 137.0 их наяд ам.долларт хүрчээ. Энэ нь Евро бүс болон СТБЗ-ийн 20 гишүүн орнуудын нийт санхүүгийн системийн хөрөнгийн 40.0 хувийг бүрдүүлж байна⁶. 2014 онд тэтгэврийн сан, даатгалын компаниуд, БСЗБ-ын салбар өссөн бол АНУ-ын мөнгөн тэмдэгийн түвшинд банкны системийн үзүүлэлт бүхэлдээ буурчээ.

Зөвхөн БСЗБ-ын хөрөнгөд суурилан тооцоход, 2014 онд Евро бүс болон СТБЗ-ийн 20 гишүүн орны банк бус санхүүгийн зуучлал 1.6 их наяд ам.доллараар өсч, 80.0 их наяд ам.долларт хүрсэн. Дээрх өсөлтөд банк бус санхүүгийн зуучлагч байгууллагуудын өөрийн хөрөнгийн өсөлт, түүний зээлийн зуучлал болон хөрөнгийн зах зээлтэй холбоотой үйл ажиллагаа нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

2008 оны санхүүгийн хямралыг дагаад банк бус санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа огцом буурсан хэдий ч, сүүлийн хэдэн жилийн хугацаанд уг салбар тогтвортой өсөлтийг харуулж байна. 2014 онд Евро бүс болон СТБЗ-ийн 20

5 Банк, даатгалын компани, тэтгэврийн сан, төрийн өмчит санхүүгийн байгууллага, төв банкнаас бусад санхүүгийн байгууллагууд

6 Нарийвчилсан аргаар тооцсон 25 гишүүд, судалгаанд хамрагдсан 1 орноос илүү өргөн хүрээнд тооцсоныг харуулна.

гишүүн орны БСЗБ-ын хөрөнгө, тэдгээрийн ДНБ-ий 128.0 хувьд хүрсэн бөгөөд 2011, 2013 оны мөн үетэй харьцуулахад 15.0, 6.0 хувиар тус тус өсчээ.

Хөгжиж буй зах зээлтэй орнуудын хувьд, БСЗБ-ын хөрөнгө хамгийн хурдацтай өсч байгаа ба 2014 оны байдлаар 8 улсын хувьд 10.0 хувийн өсөлт үзүүлсэн бол үүнээс 2 орон нь 30-аас дээш хувиар өсчээ. Дээрх орнуудын санхүүгийн системд банк бус санхүүгийн салбарын гүйцэтгэх үүрэг нэмэгдэж байгаа нь цаашид нийт макро эдийн засаг, санхүүгийн зах зээлд учруулахуйц эрсдэлийн түвшинг тооцож, хяналт, зохицуулалтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

2014 онд БСЗБ-ын дэд салбарууд болох итгэлцлийн компани, мөнгөний зах зээлийн сан, өрийн хэрэгслийн болон бусад сангууд хамгийн их хурдацтай өссөн. Итгэлцлийн компаниудын дийлэнх нь Хятад улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд хөрөнгө нь 26.0 хувиар өссөн байна. 2014 онд Хятад болон Европын зарим орнуудад мөнгөний зах зээлийн сангийн хөрөнгө 20.0 хувиар өссөн бол өрийн хэрэгслийн болон бусад сангуудын хөрөнгө 15.0 хувийн өсөлтийг үзүүллээ.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮҮРЭГТ СУУРИЛСАН СҮҮДРИЙН БАНКНЫ СИСТЕМИЙН АРГАЧЛАЛ

2013 онд СТБЗ-өөс анх удаа олон улсын түвшинд сүүдрийн банкны системд үнэлгээ хийх зорилгоор эдийн засгийн үүрэгт суурилсан аргачлалыг нэвтрүүлсэн. Уг аргачлал нь банк бус санхүүгийн байгууллагуудыг эдийн засгийн үүргээр нь 5 ангилсан ба ангилал бүрээр эрсдэл учруулах боломжтой банкны бус зээлийн зуучлалын үйл ажиллагааг хамруулсан.

Өөр өөр төрлийн сүүдрийн банкуудын үйл ажиллагааг эдийн засгийн үүргээр нь ангилснаар санхүүгийн системийн тогтвортой байдалд эрсдэл учруулах сүүдрийн банкинд хамаарч буй банкны бус зээлийн зуучлалын үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж, тогтмол хяналт тавих боломж СТБЗ-д бүрдээд байна.

Эдийн засгийн үүрэгт суурилсан шинэ аргачлал нь дараах 2 үндсэн зорилготой. Үүнд:

Хүснэгт 3. Сүүдрийн банкны системийн аргачлал

1	Бодлого боловсруулагчдад сүүдрийн банкны системийн учруулж болохуйц эрсдэлийн түвшинг үнэлж, тэдгээрийн үйл ажиллагаанд өндөр түвшинд хяналт тавих боломжийг олгох
2	Зээлийн зуучлалд төдийлөн оролцдоггүй, сүүдрийн банктай адил эрсдэл учруулахааргүй банк бус санхүүгийн байгууллагуудыг хасч, сүүдрийн банкны байгууллагуудыг илүү нарийвчлан тодорхойлж, эрсдэлийг үнэлэх боломжийг нэмэгдүүлэх

СТБЗ-ийн бодлогын хүрээний баримт бичигт эдийн засгийн 5 үүрэг тусгагдсан бөгөөд сүүдрийн банкны эрсдэлийг эрт илрүүлж, түргэн хугацаанд бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэгдсэн. Олон улсын түвшинд дээрх

аргачлалыг бүрэн нэвтрүүлж, дуусгахад тодорхой хугацаа шаардагдахаар байгаа боловч гишүүн орнуудын хувьд ахиц гараад байна.

Хүснэгт 4. Эдийн засгийн үүргийн ангилал

Эдийн засгийн үүрэг	Тодорхойлолт	Байгууллагын төрөл
EF1	Үйл ажиллагаа явуулахад эрсдэлд өртөмтгий хамтын хөрөнгө оруулалтын хэрэгслийн удирдлага	Өрийн хэрэгслийн сан, хосолсон сан, зээлийн хэдж сан, үл хөдлөх хөрөнгийн сан
EF2	Богино хугацааны санхүүжилтээс хамааралтай зээл	Санхүүгийн компани, түрээсийн компани, факторингийн компани, хэрэглээний зээлийн компани г.м.
EF3	Богино хугацааны санхүүжилт болон харилцагчийн хөрөнгийн санхүүжилтээс хамааралтай зуучлал	Брокер, дилер
EF4	Зээлийн үйлчилгээг дэмжих	Зээлийн даатгалын компани, санхүүгийн баталгаа гаргагч компани, мэргэжлийн санхүүгийн компани
EF5	Санхүүгийн байгууллагуудын санхүүжилт болон зээлийн зуучлал дээр суурилсан үнэт цаасжуулалт	Үнэт цаасжуулалтын хэрэгсэл

Эх сурвалж: fsb.org

ОЛОН УЛС ДАХЬ СҮҮДРИЙН БАНКНЫ СИСТЕМИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2014 онд СТБЗ-ийн 25 гишүүд, судалгаанд хамрагдсан 1 орны эдийн засгийн үүргээр нь ангилан тооцсон сүүдрийн банкны санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө 1.1 их наяд ам.доллараар өсч, 36.0 их наяд ам.долларт хүрэв. Дээрх аргачлалаар тооцоход, эдгээр орны сүүдрийн банкны нийт хөрөнгө жилд дунджаар 1.3 их наяд ам.доллараар өсч байв.

Хүснэгт 5. Санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө

(25 гишүүд, судалгаанд хамрагдсан 1 орон)

2014 он	Нийт хөрөнгө (их наяд ам.доллар)	Өсөлт (жил, хувь)	Дундаж өсөлт (2011-2014 он, хувь)
Банкууд	135	6.4	5.6
БСЗБ	68	9.0	6.3
Сүүдрийн банк	36	10.1	6.3


Эх сурвалж: fsb.org

2014 онд СТБЗ-ийн 25 гишүүд, судалгаанд хамрагдсан 1 орны БСЗБ-уудад суурилсан аргачлалаар тооцсон банк бус санхүүгийн зуучлагч байгууллагуудын нийт хөрөнгө 1.4 их наяд ам.доллараар өсч, 68.0 их наяд ам.долларт хүрсэн. Харин Евро бүс болон СТБЗ-ийн 20 гишүүн орны хэмжээнд анх удаа сүүдрийн банкны системийг тооцоход 1.6 их наяд ам.доллараар өсч, 80.0 их наяд ам.долларт хүрээд байна.


2014 онд олон улсын хэмжээнд сүүдрийн банкны хөрөнгө өссөн бол эсрэгээр банкны системийн хөрөнгө буурсан байна. Тухайлбал, Олон улсын банкны систем 2011-2012 онд тус тус өссөн бөгөөд СТБЗ-ийн 25 гишүүд, судалгаанд хамрагдсан 1 орны хувьд банкны систем 2013 онд тогтвортой, 2014 онд буурч 135.0 их наяд ам.долларт хүрэв.

Дүрслэл 11. Санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө

Санхүүгийн хөрөнгө (их наяд ам.доллар)



Санхүүгийн хөрөнгөнд эзлэх хувь




Notes: Banks = broader category of 'deposit-taking institutions'; OFIs = Other Financial Intermediaries; Shadow Banking = measure of shadow banking based on economic functions. These are not mutually exclusive categories, as shadow banking is largely contained in OFIs.

Эх сурвалж: fsb.org

2014 онд эдийн засгийн үүрэгт суурилсан аргачлалаар тооцоход, сүүдрийн банк нийт санхүүгийн системийн 12.0 хувийг эзэлжээ. Харин ДНБ-д эзлэх сүүдрийн банкны

систем 59.0 хувьд хүрч, 2012 оноос хойш 4.0 хувиар өссөн бөгөөд энэ нь сүүдрийн банкны системийн өсөлт ДНБ-ий өсөлтийн хурдыг давсан үзүүлэлт болсон.

Дүрслэл 12. Сүүдрийн банк болон ДНБ-ий хамаарал



Эх сурвалж: fsb.org

СТБЗ-ийн гишүүн орнуудын сүүдрийн банкны системд эзлэх хувь


2014 оны жилийн эцсийн байдлаар АНУ хамгийн том сүүдрийн банкны системтэй улс хэвээр байсан бөгөөд уг салбарын хөрөнгийн хэмжээ 14.2 их наяд ам.долларт хүрч, олон улсын сүүдрийн банкны нийт хөрөнгийн гуравны нэгээс илүүг бүрдүүлэв.

Англи улсын хувьд хоёр дахь том сүүдрийн банкны системтэй орон бөгөөд тайлант хугацаанд нийт хөрөнгө нь 4.1 их наяд ам.долларт хүрсэн. Харин сүүдрийн банкны системийн 29.0 хувийг Ази, Европын 4 гишүүн орон бүрдүүлсэн бол 2014 онд Евро бүсийн орнууд⁷ нийлээд нийт сүүдрийн банкны хөрөнгийн 23.0 хувийг бүрдүүлжээ.


7 Франц, Германи, Ирланд, Итали, Голланд, Испани

Дүрслэл 13. Гишүүн орнуудын сүүдрийн банкны системд эзлэх хувь

At end-2010



At end-2014




Note: CA = Canada; CN = China; DE = Germany; EMEs ex CN = Argentina, Brazil, Chile, India, Indonesia, Mexico, Russia, Turkey, Saudi Arabia, South Africa; FR = France; IE = Ireland; JP = Japan; KR = Korea; NL = Netherland; UK = United Kingdom; US = United States.

Эх сурвалж: fsb.org

2010 оноос хойш олон улсын сүүдрийн банкны системд эзлэх хувь нь багассан гол орнууд нь Япон, Франц, Англи, АНУ байсан. Хөгжиж буй зах зээлтэй орнуудын сүүдрийн

банкны системд эзлэх хувь 2014 онд хоёр дахин өсч, 12.0 хувьд хүрсэн ба үүнд голлох нөлөөг Хятад улс үзүүлэв.

Дүрслэл 14. ДНБ-д эзлэх Сүүдрийн банк, БСЗБ, Банкуудын хувь



Note: Banks = broader category of 'deposit-taking institutions'; OFIs = Other Financial Intermediaries; Shadow Banking = economic function-based measure of shadow banking. AR = Argentina; AU = Australia; BR = Brazil; CA = Canada; CH = Switzerland; CN = China; CL = Chile; DE = Germany; ES = Spain; FR = France; HK = Hong Kong; IE = Ireland; ID = Indonesia; IN = India; IT = Italy; JP = Japan; KR = Korea; MX = Mexico; NL = Netherlands; RU = Russia; SA = Saudi Arabia; SG = Singapore; TR = Turkey; UK = United Kingdom; US = United States; ZA = South Africa.

Эх сурвалж: fsb.org

Сүүдрийн банкны салбарт үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагуудын төрөл болон эдийн засгийн онцлогоос хамаараад ДНБ-д эзлэх сүүдрийн банкны хэмжээ харилцан адилгүй байх боломжтой. Тухайлбал, Ирланд, Англи, Швейцар, АНУ-ын хувьд 1,190.0, 147.0, 90.0, 82.0 хувийг тус тус эзэлж байна. Харин сүүдрийн банкны ДНБ-д эзлэх хувь нь 10.0 хувиас доош байгаа орнуудын тоонд Турк, Аргентин, Сауди Араб, ОХУ, Индонез багтжээ. Дийлэнх гишүүн орнуудад банкны систем нь сүүдрийн банкнаасаа том хэмжээтэй байгаа бөгөөд гагцхүү Ирланд улсын хувьд эсрэг дүр зураг ажиглагдаж байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд эдийн засаг өсөхийн зэрэгцээ олон улсын сүүдрийн банкны систем тогтвортой өсөлтийг үзүүлж байгаа бөгөөд 2010-2014 онуудад ДНБ-д эзлэх сүүдрийн банкны хэмжээ огцом нэмэгдсэн. Мөн 2010 оноос хойш сүүдрийн банкны нийт хөрөнгө хурдтай өсч байгаа ба энэхүү өсөлтөд санхүүгийн салбар нь сул хөгжсөн, хөгжиж буй зах зээлтэй орнуудад сүүдрийн банкны оролцоо нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлэв.


СТБЗ-өөс боловсруулсан сүүдрийн банкны зохицуулалтын бодлогын арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн

- Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас баталсан Мөнгөний зах зээлийн сан (МЗЗС)-уудын зохицуулалтын зөвлөмжийн хэрэгжилт СТБЗ-ийн 5 гишүүн оронд сайн байгаа ба эдгээр нь нийт зах зээл (АНУ-ыг оруулаад)-ийн 63.0 хувийг бүрдүүлж байна;
- Ихэнх гишүүн орнууд МЗЗС-уудыг үнэлэхэд бодит үнэ цэнийн аргачлалыг ашиглаж байгаа ба хөрвөх чадварын удирдлагын аргачлалын хэрэгжилт харьцангуй удаан байна;
- 9 гишүүн орнууд МЗЗС-уудыг тогтвортой цэвэр хөрөнгийн үнэ цэнийн аргачлалаар үнэлгээ хийхийг үргэлжлүүлэн зөвшөөрч байгаа ба цаашид уг сангуудад тавигдах хяналтыг сайжруулах шаардлагатай;

Хөгжиж буй зах зээлтэй орнуудад банк бус санхүүгийн зуучлалын байгууллагуудын ДНБ-д эзлэх зээлийн хэмжээ огцом нэмэгдэж байгаа нь эргээд нийт санхүүгийн системд ихээхэн эрсдэл учруулж болохоор байгаа тул СТБЗ-өөс боловсруулсан сүүдрийн банкны зохицуулалтын талаарх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Манай улсын хувьд нийт санхүүгийн зах зээлд эзлэх банкнаас бусад санхүүгийн салбарын оролцоо бага байгаа хэдий ч, зохицуулагч байгууллагын зүгээс сүүдрийн банкны системийн нийт эдийн засаг болон санхүүгийн зах зээлд эзлэх хувь, эрсдэлийн түвшинг тооцож, олон улсын түвшинд хэрэглэгдэж буй зохицуулалтын талаарх бодлогын зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр цаашид банкнаас бусад санхүүгийн салбарын өсөлттэй холбоотойгоор системийн хэмжээнд үүсэх эрсдэлээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бололцоо бүрдэнэ.

Дүрслэл 15 - МЗЗС-ийн бодлогын хэрэгжилт (гишүүн орнуудын тоо хувиар)



Эх сурвалж: fsb.org

- Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас баталсан үнэт цаасжуулалтын зохицуулалтын зөвлөмжийн хэрэгжилт гишүүн орнуудын хувьд харилцан адилгүй байна. Уг зохицуулалт нь тухайн үнэт цаас гаргагчдыг үнэт цаасжуулалтын зээлийн эрсдэлийн 5.0 хувийг хариуцах үүрэгтэй болгосон;
- Бусад сүүдрийн банкны шинэчлэлийн бодлогын хэрэгжилт нь эхлэлтийн үе шатанд тухайлбал, зарим орнуудад бодлогын хэрэгжилт (санд хөрөнгө оруулж буй банкинд тавигдах хөрөнгийн шаардлага, томоохон банкуудын зохицуулалтын хүрээ, сүүдрийн банкны зохицуулалт, хяналт, шалгалтын хүрээ) дөнгөж хэрэгжих шатандаа байна.

БҮЛЭГ 4.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ


Хөрөнгийн зах зээлийн 2016 оны эхний улирлын тоймоор хөгжлийн үзүүлэлтүүд, зах зээлийн оролцогчид, эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлс, дэд бүтцийн статистик мэдээллийг хураангуйлав.

4.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.1.1. Зах зээлийн үнэлгээ

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар зах зээлийн үнэлгээ 1,297.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.04 хувиар буурчээ. Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнийн уналт, манай орны эдийн засгийн өсөлтийн сааралтаас үүдэн уул уурхай болон боловсруулах салбарын компаниудын үнэт цаасыг худалдан авах сонирхол буурсан нь зах зээлийн үнэлгээ багасахад шууд нөлөөлсөн байна.

Дүрслэл 16. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тухайлбал, ТОП-20 индексэд багтдаг уул уурхайн салбарын компаниуд болох “Таван толгой”, “Шивээ овоо”, “Багануур” ХК-уудын хувьцааны ханш 76.5, 52.1, 44.0 хувиар тус тус буурчээ.

Тайлант хугацаанд нийт зах зээлийн үнэлгээний 88.2 хувийг 30 компани бүрдүүлсэн бөгөөд эдгээр компаниудын зах зээлийн үнэлгээ 1,148.1 тэрбум төгрөгт хүрэв.

Хүснэгт 6. Зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй 30 компани

Д/д	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/	Д/д	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/
1	АПУ	275.09	16	Улсын их дэлгүүр	20.43
2	Мик холдинг	232.98	17	Хай би ойл	19.81
3	Говь	63.97	18	Бэрх уул	19.06
4	УБ-БҮК	56.97	19	Баянгол зочид буудал	19.04
5	Таван толгой	45.82	20	Талх чихэр	17.20
6	Сүү	37.84	21	Монголын цахилгаан холбоо	15.73
7	Монгол шуудан	30.37	22	Материал импекс	12.31
8	Шивээ овоо	30.18	23	Атар-өргөө	11.32
9	Багануур	29.36	24	Махимпекс	11.25
10	Би ди сек	28.63	25	Силикат	10.43
11	Гутал	28.33	26	Гермес центр	10.26

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ 2016 - I УЛИРАЛ

12	Монгол секюритиес	26.64	27	Женко тур бюро	7.84
13	Дархан нэхий	22.88	28	Ариг гал	7.69
14	Тахь-ко	22.61	29	Монгол шилтгээн	7.00
15	Шарын гол	20.82	30	Фронтнер лэнд групп	6.26


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.1.2. Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадвар

Тайлант хугацаанд ЗЗҮ-ний нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь

27.6 болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар буурсан, харин хөрвөх чадварын түвшин 0.63 болж өсөлт ажиглагдлаа.

Дүрслэл 17. ДНБ/ЗЗҮ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Сүүлийн 6 жилийн хугацаанд ДНБ-ий хэмжээ өсөлттэй байсан ба харин ЗЗҮ тогтмол буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь манай улсын үнэт цаасны зах зээл болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарал сулаас үнэт цаасны зах зээл өөрөө бодит эдийн засгийг дэмжихэд шууд нөлөө үзүүлж чадахгүй байгааг харуулж байна.

4.1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Тайлант хугацааны ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.4 хувиар буурч, 11,082.6 нэгжид хүрчээ. ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 12,685.9, доод үзүүлэлт 10,673.1, дундаж үзүүлэлт 11,712.4 нэгж байв.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.2 хувиар буурч, 802.9 нэгж болсон бол индексийн дээд үзүүлэлт 892.6 нэгж, доод үзүүлэлт 794.7 нэгж, дундаж үзүүлэлт 849.7 нэгж байлаа.

Дүрслэл 18. ТОП-20 индекс




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Тайлант хугацаанд 1 компани олон нийтэд үнэт цаасаа анх удаа санал болгон гаргаж нээлттэй компанийн хэлбэрт шилжсэнээр Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 300 компани бүртгэлтэй байна.

Дүрслэл 19. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Жич: Хорооны 2016 оны 20 дугаар тогтоолоор “Ай Түүлс” ХХК-ийн нийт 4,324,263 ширхэг хувьцааг бүртгэсэн бөгөөд үүнээс 2,431,548 ширхэг хувьцааг тус компанийн

үүсгэн байгуулагчид, үлдэх 1,892,715 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалахаар үнэт цаасны танилцуулгад тусгагджээ.

Хүснэгт 7. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн хэлбэр	СЗХ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	“ҮЦТТХТ” ХХК
Төрийн өмчит	32	21	22
Төрийн өмчийн оролцоотой	10	16	15
Орон нутгийн оролцоотой	15	-	8
Хувийн өмчит	243	199	276
Нийт	300	236	321

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд “ҮЦТТХТ” ХХК нь 3 ХК-тай ногдол ашиг тараах гэрээ байгуулж, нийт 10,236 харилцагчийн дансанд 90.1 сая төгрөгийн ногдол ашгийг байршуулсан байна.

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үнэт цаасны зах зээлд нийт 115 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа явуулж байгааг бүтцээр нь хүснэгтэд үзүүлбэл:

Хүснэгт 8. Зохицуулалттай этгээдийн тоо

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
3	Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын үйлчилгээ үзүүлэх	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	9
5	Брокер, дилер	61
6	Кастодиан банк	3
7	Андеррайтер /давхардсан тоогоор/	24
8	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	16
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	37

11	Аудитын компани	42
12	Үнэлгээний компани	20
13	Хуулийн компани	17

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн 2 компанид тусгай зөвшөөрлийг олгосон бол Засгийн газрын 2015 оны 147-р тогтоол, Сангийн сайдын 2015 оны 280-р тушаалын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс “ҮЦТТХТ” ХХК-ийг үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий бие даасан 2 хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгууллаа.

Мөн үнэт цаасны арилжаа эрхлэх, тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий “Монголын үнэт цаасны бирж” ХХК нь “Nasdaq OMX” группын цахим арилжааны програмыг ашиглан ойрын ирээдүйд олон нийтээс санхүүжилт татах суваг, сонголтыг нэмэгдүүлэх, ангиллын шалгуур, үйлчилгээний нөхцөл, үнэт цаас гаргагч болон

хөрөнгө оруулагчдыг төрөлжүүлэх зэрэг боломжийг бүрдүүлэх давуу талыг бий болгохоор байна.

4.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар нийт 49.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55.7 хувиар буурчээ. Нийт арилжааны 16.8 хувийг хувьцаа, 75.5 хувийг ЗГҮЦ-ны анхдагч зах зээл, 7.7 хувь нь ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 9. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт

Арилжааны үзүүлэлтүүд	2015 оны 1-р улирал	2016 оны 1-р улирал
Үнэт цаасны тоо ширхэг /сая ширхэг/	14.0	36.1
Нийт үнийн дүн /тэрбум төгрөг/	111.7	49.5

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


4.3.1. Хувьцааны арилжаа

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 60 удаагийн хувьцааны арилжаагаар нийт 91 компанийн 36.1 сая ширхэг хувьцааг 8.3 тэрбум төгрөгөөр арилжсанаас 74.9 хувь буюу 6.3 тэрбум төгрөгийн гүйлгээг хувьцааны анхдагч зах зээл, 3.2 хувь буюу 263.6 сая төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 21.95 хувь буюу 1.8 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлээ. Хувьцааны арилжааны үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 26 компанийн үнэт цаасны үнэ өсч, 61 компанийн ханш буурч, 3 компанийн үнэт цаасны ханш тогтмол байлаа.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар “Монгол Шуудан” ХК-ийн үнэт цаасны 34 хувь буюу 33.8 сая ширхэг хувьцаа 6.3 тэрбум төгрөгөөр арилжигдсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 74.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 20. Шинээр болон нэмж үнэт цаас гаргагчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн журамд зохицуулалтын өөрчлөлт хийгдсэнээр

Хороо болон биржийн чиг үүргийн давхардлыг бууруулж, бүртгэх үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа хэмнэх нөхцөл бүрдээд байна.

4.3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 12 удаа явагдаж, 12, 28, 39, 52 долоо хоногийн хугацаатай нийт 392.9 мянган

ширхэг үнэт цаас 37.4 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан бол хоёрдогч зах зээлийн арилжаагаар 38.7 мянган ширхэг үнэт цаасыг 3.8 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Хүснэгт 10. Хөрөнгийн биржээр хийгдсэн ЗГҮЦ-ны арилжаа

Д/д	Харилцагчийн төрөл	Харилцагчийн тоо	Хэлцлийн тоо	ҮЦ-ны тоо	Үнийн дүн /төгрөг/
1	Арилжааны банк	3	7	218,469	21,035,766,700
2	Иргэн	61	90	18,153	1,690,306,708
3	Төрийн бус байгууллага	1	1	1,000	96,974,000
4	Аж ахуйн нэгж	15	28	155,366	14,578,283,173
	Нийт	80	126	392,988	37,401,330,581

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 11. Монголбанкаар хийгдсэн ЗГҮЦ-ны арилжаа

Д/д	Харилцагчийн төрөл	Харилцагчийн тоо	Хэлцлийн тоо	ҮЦ-ны тоо	Үнийн дүн /төгрөг/
1	Арилжааны банк	4	23	172,550	172,550,000,000
2	Аж ахуйн нэгж	1	11	38,250	38,250,000,000
	Нийт	5	34	210,800	210,800,000,000

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт ЗГҮЦ-ны арилжааны 84.9 хувь нь Монголбанкаар дамжиж, үлдсэн 15.1 хувь нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар хийгдсэн байна.

4.3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Хорооны 2016 оны 2 дугаар тогтоолоор “МИК Актив Найм” ХХК-ийн 1,898,404 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн ба 8 удаагийн үнэт цаасжуулалт хийгдсэнээс нийт 1,787.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгджээ.

Хүснэгт 12. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	“ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо	2016.3.31-ний үлдэгдэл
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,811	257.2
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,384	193.5
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,689	295.2
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,634	422.1
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5,869	280.6
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,225	254.2
“МИК актив долоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,438	290.1
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,305	186.3
Нийт	2,399.2	2,358	48,355	2,179.3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.4. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ТАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛС

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 811,703, холболтоор 136,060 данс нээгдсэн байна. Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 807,164 дотоодын иргэн, 1,866 гадаадын иргэн, 2,496 дотоодын аж ахуйн нэгж, 177 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид

нийт 5,040 данс шинээр нээгдсэнээс 4,999 нь дотоодын иргэн, 25 нь гадаадын иргэн, 15 нь дотоодын аж ахуйн нэгж, 1 нь гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Нээгдсэн дансны тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 7.3 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

Арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалын нийт 87 гүйлгээгээр давхардсан тоогоор 35 ХК-ийн 37,564 ширхэг хувьцаа, бэлэглэлээр 4 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 9 ХК-ийн 24,903 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлжээ.

Хөрөнгө оруулагчдын бүтцийн хувьд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжаанд дотоодын иргэн 9.0 хувь, дотоодын аж ахуйн нэгж 88.0 хувь, гадаадын аж ахуйн нэгж 1.0 хувь, гадаадын иргэн 2.0 хувийг тус тус эзэлж байна. Мөн тайлант хугацаанд хувийн хөрөнгө оруулалтын сангийн 1 компанийн 48.0 тэрбум төгрөгийн нэгж эрхийг бүртгэснээр хувийн хөрөнгө оруулалтын 2 сангийн нийт 98.0 тэрбум төгрөгийн нэгж эрх бүртгэгдээд байна. Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 компанид шинээр олгож, өссөн дүнгээр 9 компани үнэт цаасны зах зээлд тухайн үйл ажиллагааг эрхэлж байна.

4.5. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

4.5.1. Үнэт цаасны арилжааны мөнгөн гүйлгээ

Тайлант хугацаанд төвлөрсөн хадгаламжийн дансаар нийт 598 харилцагчийн дансанд 1,250 удаа 461,192.5 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 934 харилцагчийн 1,341 удаагийн 461,338.9 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ тус тус хийгджээ. Гүйлгээний нийт дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.5 хувиар багасчээ.

Хүснэгт 13. Мөнгөн гүйлгээний задаргаа /сая төгрөг/

Он	Орлого		Зарлага		Нийт	
	Гүйлгээний тоо	Үнийн дүн	Гүйлгээний тоо	Үнийн дүн	Үнийн дүн	Гүйлгээний тоо
2011 оны 1 улирал	2,295	24,775.2	2,590	14,857.7	39,633	4,885
2012 оны 1 улирал	2,433	30,209.7	3,864	29,818.1	60,028	6,297
2013 оны 1 улирал	365	208,181.1	880	209,789.1	417,970	1,245
2014 оны 1 улирал	620	276,054.6	864	281,944.3	557,999	1,484
2015 оны 1 улирал	671	532,369.7	1,255	533,740.7	1,066,110	1,926
2016 оны 1 улирал	1,250	461,192.5	1,341	461,338.9	922,531	2,591

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдсэн арилжааны мөнгөн төлбөрийн тооцоог арилжааны 4 банкаар дамжуулан банк хооронд нийт 6,566.5 сая төгрөгийн төлбөрийн тооцоо гүйцэтгэсэн байна. Үүнд: “Голомт банк” ХХК-аар 2.8 тэрбум төгрөг, “Худалдаа хөгжлийн банк” ХХК-аар 0.641 сая төгрөг, “Хас банк” ХХК-аар 3.1 тэрбум төгрөг, “ХААН банк” ХХК-аар 0.020 сая төгрөгийн гүйлгээ тус тус хийгджээ.

4.5.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 321 ХК-ийн 1.3 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 20.2 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас гадна 26 төрлийн 22.5 сая ширхэг компанийн бонд, 122 төрлийн 4.6 сая ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна. Үүнээс 21 төрлийн 21.9 сая ширхэг компанийн бонд, 45

төрлийн 1.9 сая ширхэг Засгийн газрын бонд биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна. Мөн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай ХК-ийн 150.0 сая ширхэг хувьцаа, “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийн 22.7 сая ширхэг хувьцаа төвлөрсөн хадгаламжид тус тус бүртгэлтэй байна.

4.5.3. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үзүүлэлтүүд

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК дээр тайлант хугацаанд 5,400.0 тонн ноолуур, 26,260.0 тонн хонины ноос, 710.0 тонн тэмээний ноос, 94,300.0 тонн ямааны завод ноос, 11.0 тонн завод ноос, 16.0 тонн бодын хөөврийг нийт 21.3 тэрбум төгрөгөөр арилжсан ба түүхий эдийн бэлтгэл үе хараахан эхлээгүй байсан нь арилжааны хэмжээ доогуур байхад нөлөөлжээ.

Хүснэгт 14. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ

Д/д	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/
1	Ноолуур	5,400	3.10
2	Хонины ноос	26,260	4.30
3	Тэмээний ноос	710	0.35
4	Ямааны завод ноос	94,300	13.50
5	Завод ноос	11	0.00
6	Бодын хөөвөр	16	0.03
	Дүн	126,697	21.29

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

БҮЛЭГ 5.

ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ОРЧИН

Хамтын санхүүжилт /crowdfunding/ нь бизнесийн шинэ санаа, төслийг санхүүжүүлэх зорилгоор цахим технологийг ашиглан хувь хүн, аж ахуйн нэгжээс хөрөнгө татан төвлөрүүлэх үйл ажиллагааг ойлгодог. Сүүлийн жилүүдэд хувьцааны болон зээллэгийн хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ тасралтгүй өсөх хандлага олон улсын санхүүгийн зах зээлд ажиглагдаж байна.

Санхүүгийн салбарт шинээр үүсч буй зохицуулалт, хяналтын орчин нь уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн бичил зээлийн нийлүүлэлтийг бууруулсан. Үүнээс үүдэн бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх салбар болох өрхийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ арга хэрэгслийг бий болгох шаардлага үүссэн бөгөөд энэхүү хэрэгцээг хангах чиглэлээр хөгжингүй болон хөгжиж буй орнуудад хувьцаа, зээллэгийн хамтын санхүүжилтийн үйлчилгээний шинэ хэлбэрүүд үүсч бий болсон.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-ын 2015 оны үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн товхимолд сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрүүд зонхилох хандлага давамгайлж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжихэд зайлшгүй хэрэгцээтэй хэрэгсэл болсон талаар дурьджээ.

Хамтын санхүүжилт нь хувьцаа, зээллэг, олон нийтээс татан төвлөрүүлэх хандив тусламж, шагналын гэсэн үндсэн 4 төрөлтэй бөгөөд хувьцаа, зээллэгийн хамтын санхүүжилтийг санхүүгийн зах зээлийн хэрэгсэл гэж үздэг. Дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээ анх дотоодын зах зээлээс цахим технологиор дамжуулан санхүүжилт татах шинжийг агуулж байсан бол сүүлийн жилүүдэд хил дамнансан орнуудын иргэд, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилт татах хэлбэр рүү өргөжиж байна.

Хамтын санхүүжилт нь харилцагчийн данс тусдаа байх /client segregated account model/, бичиг баримтын баталгаажилт /the notary model/, хувьцааны санхүүжилт гэсэн гурван үндсэн загварын үзэл санаанд тулгуурладаг бөгөөд эхний хоёр загвар нь хамтын зээллэгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, сүүлийн загвар нь хувьцааны хамтын санхүүжилтээр дамжуулан хөрөнгө оруулагчдад ногдол ашгийн өгөөж хүртэх, хувьцааг хуваарилах

тогтолцооны онол арга зүйн үндэс болдог.

Манай орны хувьд хувьцааны болон зээллэгийн хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээ сонгодог утгаар үүсч хөгжөөгүй, зохицуулалт хяналтын орчин байхгүйгээс дээрх хэлбэрээр дамжуулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх боломжийг хязгаарлахад хүргээд байна.

ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД:

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудад хамтын санхүүжилт нь зах зээлийн чиг баримжаанд түшиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болох нь харагдаж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдын хувь оруулсан хөрөнгөө өсгөх, ногдол ашиг хүртэхээс гадна дараах давуу талтай. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг хямд зардлаар бий болгон, ажлын байр нэмэгдүүлэх, улмаар урт хугацаандаа бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих;
- Уламжлалт зээллэгийн үйлчилгээ үзүүлэгч нь зээл хүсэгчээс барьцаа хөрөнгийн болон бусад шаардлага, шалгуурыг тавьдаг бол хамтын зээллэгийн тогтолцоо нь дээрх ажилбарыг хэд дахин хөнгөвчлөх, саад бэрхшээлгүйгээр олон нийтээс зээлийн санхүүжилтийг бүрдүүлэх боломж олгох;
- 2008 оны санхүүгийн хямралаас хойш хөгжингүй болон хөгжиж буй орнуудын Төв банкнаас бодлогын хүүгээр дамжуулан мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлсэн нь үнэт цаасны өгөөжид сөргөөр нөлөөлсөн бол хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хөрөнгө оруулагчдад бага зардлаар өндөр өгөөж хүртэх боломжийг бүрдүүлэх;
- Хувьцааны хамтын санхүүжилт болон зээллэгийн үйлчилгээ нь хөрөнгө оруулагчдад системийн эрсдэлээс сэргийлэх, олон сонголт бүхий багцад байршуулснаар хөрөнгөө оновчтой удирдах програм хангамжийн нөхцөл, боломжийг олгох;
- Дээрх үйл ажиллагаа нь төрийн зохицуулагч байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн олон сонголтот програм хангамжаар дамжуулан хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчид үйл ажиллагааны болон удирдлагын хамгийн бага зардлаар санхүүжилт татах боломж бүрдүүлэх;

- Хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээ олон улсын санхүүгийн зах зээлд эрчимтэй хөгжиж байгаа нь уламжлалт зээллэгийн болон хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээнийхээ өртөг, зардлыг бууруулах чиглэлд анхаарал хандуулах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх шаардлага бий болгох.

Хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд гарах нийтлэг эрсдэлүүд

- Санхүүгийн эрсдэл - Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлт, бизнесийн мөчлөг, удирдлага, маркетингийн үйл ажиллагаанаас хамааран амжилтгүй болох, дампуурах магадлал өндөр байдаг нь эргээд тухайн компанид хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдад санхүүгийн эрсдэлийг бий болгох;
- Хууран мэхлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл - Цахим мэдээллийн сүлжээ, програм хангамжаар дамжуулан хуурамч төсөл, хөтөлбөр танилцуулан хөрөнгө оруулагчдаас санхүүжилт татах, хууль бус мөнгөний гарал үүслийг өөрчлөх зорилгоор хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэх;
- Програм хангамжийн найдваргүй байдал - Хамтын санхүүжилтийн тусгайлсан програм хангамжид саад үүсэх, техникийн аюулгүй байдал алдагдах;
- Хөрвөх чадвар сул байх - Хамтын санхүүжилтээр дамжуулан эзэмшсэн үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжаалах боломжгүй байдаг нь эргээд хөрөнгө оруулагчдад хөрвөх чадварын эрсдэл бий болгох;
- Хэт төвлөрөл болон сонирхлын зөрчил - Хамтын зээллэгийн болон хувьцааны санхүүжилтийн тогтолцоонд цөөн тооны зээлдэгч, хөрөнгө оруулагчид оролцдог нь эргээд хэт төвлөрлийг бий болгох, ил тод байдал алдагдаж, сонирхлын зөрчил үүсэх;
- Мэдээллийн зөрүүтэй байдал /information asymmetry/ - Хамтын санхүүжилт нь олон нийтийн цахим сүлжээ, тусгайлсан програм хангамжаар дамжуулан санхүүжилт татах явцад санхүүгийн мэдлэг, мэдээлэл дутмаг зарим хөрөнгө оруулагчид тухайн төслийн зорилго, ирээдүйд бий болох эрсдэлийг сайн ойлгож, дүн шинжилгээ хийх боломжгүйгээс хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчийн хооронд мэдээллийн зөрүүтэй байдал үүсэх.

Энэхүү үйлчилгээ нь цахим болон мобайл технологид суурилсан програм хангамжаар явагддаг нь сүүлийн жилүүдэд хил дамнан шинжтэй болсон бөгөөд Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас төрийн зохицуулагч байгууллагууд хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэдээлэл солилцох шаардлагатайг зөвлөөд байна. Учир нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хил дамнан шинжтэй луйвар, залилангаас сэргийлэх, мөнгө угаах, буруутай этгээдийг олж тогтоох, хариуцлага хүлээлгэхэд зайлшгүй хамтын ажиллагаа хэрэгтэй.

ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ОРЧИН

Улс орнууд хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалт, хяналтын ялгаатай хандлагыг

хэрэгжүүлж байгаа хэдий ч өнөө үед үнэт цаас гаргагч, зээлдэгч, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчийн харилцаатай холбоотой болон цахим програм хангамжийн техникийн нийтлэг нөхцөлийг агуулсан зохицуулалтын орчин давамгайлж байна.

Хамтын зээллэгийн зохицуулалтын хандлага: Хамтын зээллэгийн зохицуулалтыг дараах үндсэн 4 хандлагад хамруулдаг боловч зарим оронд эдгээр үйлчилгээний талаарх ойлголтын зөрүүгээс шалтгаалан төрийн зохицуулалт, хяналтыг шаардлагагүй гэж үзэж байна.

- Мэргэжлийн зуучлагчийн зохицуулалтын загвар - Зарим орнуудад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийг брокерийн болон зуучлагч гэсэн 2 үндсэн хэсэгт ангилан, ангилал тус бүрийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч этгээд нь төрийн зохицуулагч байгууллагаас тусгай зөвшөөрөл авч, програм хангамжаа бүртгүүлсэн байх шаардлагатай байдаг;
- Арилжааны банкны зохицуулалтын загвар - Хөгжиж буй зарим орнуудад хамтын зээллэгийн үйлчилгээг арилжааны банкны програм хангамжийг ашиглан гүйцэтгэдэг ба тухайн банк нь ашиглаж буй програм хангамжаа зохицуулагч байгууллагад бүртгүүлэн, зээлдэгчид шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь хүргэх, мэдээллийн ил тод байдлын тогтолцоог бүрдүүлэх үүргийг хүлээдэг;
- АНУ-ын зохицуулалтын загвар - Холбооны улсын хэмжээнд хамтын зээллэгийн үйлчилгээ үзүүлэгч нь програм хангамжаа Үнэт цаас, биржийн хороо /SEC/-нд бүртгүүлсэн байх шаардлагатай бөгөөд санхүүжилт татагч этгээд нээлттэй хувьцаат компанийн адил мэдээллийн ил тод байдлыг хангах үүргийг хүлээдэг. Түүнчлэн муж улсуудын түвшинд холбооны ерөнхий зохицуулалт хяналтын дүрэм, журамд нийцүүлэн өөрийн дотоод журмаа боловсруулан хэрэгжүүлдэг;
- Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай нийцүүлсэн зохицуулалтын хандлага - Хамтын зээллэгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын орчинд нийцүүлэх хандлага боловч хамтын зээллэгийн үйлчилгээнд хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг шууд утгаар нь тусган хэрэгжүүлэх нь оновчгүй талаар зарим орнуудын туршлага харуулдаг.

Хувьцааны хамтын санхүүжилтийн зохицуулалтын хандлага: Хувьцааны санхүүжилттэй холбоотой 3 хандлага санхүүгийн зах зээлд давамгайлж байгаа бөгөөд эхний хандлага нь дээрх үйлчилгээг төрийн зохицуулагч байгууллагаас зохицуулах шаардлагагүй, харин хоёр дахь хандлага нь уг үйлчилгээг үзүүлэгч, үнэт цаас гаргагчид чиглэгддэг бөгөөд хувьцааны хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомжид нарийвчлан зааж, төрийн зохицуулагч байгууллагаас програм хангамжийн болон санхүүгийн нөхцөл, шаардлагыг тавих нь зүйтэй гэж үздэг.

Сүүлийн хандлага нь хөрөнгө оруулагчдад чиглэсэн бөгөөд зохицуулагч байгууллагаас хувьцааны хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах оролцогчдын тоо, оруулах хөрөнгийн дээд хязгаарыг хатуу чанга байдлаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Гадаад орнуудын хамтын зээллэг болон хувьцааны

санхүүжилтийн зохицуулалт хяналтын хандлагаас үзэхэд эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах гэсэн хоёр үндсэн зорилгыг уялдуулах чиглэлээр хөгжүүлэхэд анхаарч байна.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас хамтын санхүүжилтийн тогтолцоотой холбоотойгоор төрийн зохицуулагч байгууллагын зохицуулалт, үнэт цаас, зээл

гаргагч, зуучлагч, хөрөнгө оруулалтын болон хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой суурь зарчмуудыг боловсруулан гишүүн байгууллагууддаа мөрдөхийг зөвлөөд байна.

Япон болон Тайланд улсын хамтын санхүүжилтийн зохицуулалт, хяналтын орчинг хүснэгтээр тоймлон үзүүлбэл дараах байдалтай байна:

Хүснэгт 15. Зохицуулалт, хяналтын орчны харьцуулалт

Төрөл, хүрээ	Япон улсын зохицуулалт, хяналтын орчин	Тайланд улсын зохицуулалт, хяналтын орчин
Бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэр	Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн
Хууль эрх зүйн зохицуулалтын орчинг бүрдүүлсэн огноо	2015-05-29	2015-05-16
Өөрийн хөрөнгийн доод хэмжээ	5.0-10.0 сая иен	5.0 сая батт, хэрэв үнэт цаасны мэргэжлийн оролцогч дээрх үйлчилгээг үзүүлбэл 500.0 сая бат
Бүртгэлийн шаардлага	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн байх	Тайланд улсын Үнэт цаас, биржүүдийн хороонд бүртгүүлсэн байх
Бизнесийн үйл ажиллагаа /key conduct/	<ul style="list-style-type: none"> • Үнэт цаас гаргагч нь мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах /due diligence/ • Мэдээлэл, тайлагналын ил тод байдлыг хангах • Санал болгож буй хувьцааны тоо ширхэг, хөрөнгө оруулагчдын оруулах хөрөнгийн дээд, доод хязгаарыг тодорхойлох • Харилцагчийн хөрөнгөөс өөрийн хөрөнгийг тусгаарлах 	<ul style="list-style-type: none"> • Үнэт цаас гаргагч нь мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах /due diligence/ • Мэдээлэл, тайлагналын ил тод байдлыг хангах • Санал болгож буй хувьцааны тоо ширхэг, хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгийн дээд, доод хязгаарыг тодорхойлох • Харилцагчийн хөрөнгөөс өөрийн хөрөнгийг тусгаарлах • Санал болгож буй үнэт цаасны төсөлтэй танилцуулалгүйгээр хөрөнгө оруулалт хийхийг хориглох • Хөрөнгө оруулагчийн мэдээллийг нарийвчлан тодорхойлох • Хөрөнгө оруулагчдаас тусгайлсан мэдлэгийн тестийг бөглөх
Үнэт цаас гаргагчид тавих шаардлага	-	<ul style="list-style-type: none"> • Хуулийн хүрээнд компани бүртгүүлэх • Үнэт цаасны танилцуулгаа үнэн зөв боловсруулах • Санхүүжилт татах нэг төрлийн програм хангамжийг хэрэглэх • Санхүүжилт татах програм хангамжийг зохицуулагч байгууллагад бүртгүүлэх • Өнгөрсөн 2 жилийн хугацаанд хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээллийн түүхгүй байх
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайланг олон нийт мэдээлэх	-	<ul style="list-style-type: none"> • Татан төвлөрүүлсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг 15 хоногийн дотор зохицуулагч байгууллагууд хүргүүлэх
Хөрөнгө оруулагчийн ангилал	-	<ul style="list-style-type: none"> • Жижиг хөрөнгө оруулагч • Мэргэжлийн хөрөнгө оруулагч
Оруулах хөрөнгийн хязгаар	500.0 мянган иен	<ul style="list-style-type: none"> • Жижиг хөрөнгө оруулагч 50,000-500,000 бат • Мэргэжлийн хөрөнгө оруулагч дээд хязгааргүй
Харилцагчаа таньж мэдэх болон бүртгэлийн шаардлага	-	Харилцагчаа таньж мэдэх чиглэлээр хөрөнгө оруулагчдаас тусгайлсан тест, санал асуулгыг бөглүүлж авсан байх
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дээд хязгаар	100.0-500.0 сая иен хүртэл	20.0-40.0 сая бат
Төлбөр тооцоо	Мөнгөн төлбөрийг арилжааны банкаар дамжуулах	Мөнгөн төлбөрийг арилжааны банкаар дамжуулах
Гэрээг цуцлах нөхцөл	8 өдрийн дотор гэрээг цуцлах эрхтэй	48 цагийн дотор гэрээг цуцлах эрхтэй

ДҮГНЭЛТ

Хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг цаашид үнэт цаас, бичил санхүүгийн салбарт хөгжүүлэх чиглэлээр зээллэг болон хувьцааны хэлбэрүүдээр төрөлжүүлэх, үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн зуучлагч, үнэт цаас

гаргагч, хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хувьцааны хамтын санхүүжилт, зээллэгийн бүртгэлийн журмыг олон улсын байгууллагуудын зөвлөмж, стандарт, гадаад орнуудын туршлагад тулгуурлан боловсруулах шаардлагатай.

БҮЛЭГ 6.

ДААТГАЛЫН САЛБАР

6.1 ДААТГАЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Даатгалын салбарын эдийн засаг, санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг тооцохдоо гүнзгийрэлтийн түвшин / penetration/-г голчилдог ба тайлант хугацаанд салбарын хураамжийн орлого болон нийт хөрөнгийг нэрлэсэн ДНБ-д харьцуулахад 0.58, 3.39 хувийг тус тус эзэлж байна.

Энэхүү үзүүлэлтийг ердийн болон урт хугацаат даатгалын хэлбэрээр авч үзвэл урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь 0.0064, 0.16, ердийн даатгалын хураамжийн орлого, нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь 0.57, 3.23 байв. Салбарын гүнзгийрэлтийн түвшинг өмнөх онуудын үзүүлэлттэй харьцуулан дор хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 16. Даатгалын гүнзгийрэлт


Он	Даатгалын салбарын гүнзгийрэлт /%/		Урт хугацаат даатгалын гүнзгийрэлт		Ердийн даатгалын гүнзгийрэлт	
	Хураамжийн орлого/ДНБ	Нийт хөрөнгө/ДНБ	Хураамжийн орлого/ДНБ	Нийт хөрөнгө/ДНБ	Хураамжийн орлого/ДНБ	Нийт хөрөнгө/ДНБ
2009-I	0.37	3.17	0.0007	0.10	0.37	3.06
2010 -I	0.30	2.43	0.0028	0.07	0.30	2.36
2011 -I	0.35	2.30	0.0017	0.08	0.35	2.15
2012 -I	0.56	2.53	0.0031	0.11	0.55	2.47
2013 -I	0.45	2.99	0.0067	0.14	0.45	2.85
2014 -I	0.58	3.02	0.0104	0.14	0.57	2.88
2015 -I	0.78	3.24	0.0113	0.15	0.77	3.10
2016 -I	0.58	3.39	0.0064	0.16	0.57	3.23

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өмнөх оны мөн үеийнхээс хураамжийн орлого 0.02 хувиар буурч, харин нийт хөрөнгийн дүн 0.15 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

Монгол Улсын 2015 оны жилийн эцсийн хүн амын тоонд тулгуурлан даатгалын салбарын нягтралыг тооцоход нэг хүнд ногдох хураамжийн орлого 37,238.0 төгрөг болж, 2014 онтой харьцуулахад 2.6 хувиар өсчээ. Үүнээс урт хугацааны даатгалын нягтрал 541.0 төгрөг, ердийн даатгалын нягтрал 36,698.0 төгрөг байна.

Дүрслэл 17. Даатгалын нягтрал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын салбарын хөрөнгийн бүтэц - Тайлант хугацаанд салбарын нийт хөрөнгийн хэмжээ 159.6 тэрбум төгрөг байгаагаас 60.2 тэрбум төгрөг буюу 38.0 хувийг дүрмийн сан, 33.8 тэрбум төгрөг буюу 21.0 хувийг нөөц сан тус тус эзэлж байв. Дүрмийн сангын 47.7 хувийг банкны хадгаламжид, 3.9 хувийг үнэт цаасанд байршуулсан хөрөнгө оруулалт, 20.2 хувийг үндсэн хөрөнгө, 11.5 хувь нь банкны харилцах, 11.4 хувь нь бусад хөрөнгөд тус тус байршиж байна.

Үүнээс урт хугацааны даатгалын компанийн хувьд дүрмийн сангийнхаа 22.0 хувийг үнэт цаасанд, 34.0 хувийг банкны хадгаламжид, ердийн даатгалын компани 49.1 хувийг банкны хадгаламжид, 2.2 хувийг үнэт цаасанд тус тус байршуулжээ.


Хүснэгт 18. Дүрмийн сангийн бүтэц

	Банкны харилцах	Банкны хадгаламж	Хадгаламжийн сертификат	Үнэт цаас	Үндсэн хөрөнгө	Бусад хөрөнгө	Бэлэн мөнгө ба бусад санхүүгийн байгууллага
Нийт	11.5%	47.7%	4.3%	3.4%	20.2%	11.4%	1.0%
Урт хугацааны	0.0%	34.0%	0.0%	22.0%	44.0%	0.0%	0.03%
Ердийн	12.6%	49.1%	4.7%	2.2%	17.8%	12.5%	1.1%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын салбарын нөөц сангийн 95.6 хувийг ердийн даатгалын компаниуд бүрдүүлж байна. Үүний 65 хувийг банкны хадгаламжид, 26 хувийг банкны харилцахад, 3 хувийг үл хөдлөх хөрөнгөд, 1 хувийг үнэт цаасанд байршуулсан байна.

Дүрслэл 22. Ердийн даатгалын нөөц сангийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

6.2. ДААТГАЛЫН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

6.2.1 Даатгалын салбарын бүтэц

Салбарын бүтцийг хөгжиж буй болон хөгжингүй орнуудад түгээмэл ашиглагдаж буй мэргэжлийн оролцогчид, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үйл хөдлөл, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээр төлөөллүүллээ. Үүнд:

Мэргэжлийн оролцогчид - 2016 оны эхний улирлын байдлаар нийт 3,454 даатгалын компани, зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгч, актуарч Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байгаа нь 2015 оны жилийн эцсийн дүнгээс 237 оролцогчоор буурчээ. Тайлант хугацаанд даатгалын хохирол үнэлэгч 2 компани тусгай зөвшөөрөл шинээр авсан бол 235 даатгалын төлөөлөгчийн эрхийг хүчингүй болгож, 4 даатгалын компани салбараа татан буулгаснаар Хорооноос салбарын зөвшөөрлийг нь цуцалсан байна.

Хүснэгт 19. Даатгалын мэргэжлийн оролцогчид

Он	Ердийн даатгал	Урт хугацааны даатгал	Давхар даатгал	Компанийн салбар	Даатгалын төлөөлөгч	Даатгалын зуучлагч	Хохирол үнэлэгч	Актуарч	Нийт
2007	15	-	-	91	690	2	-	-	707
2008	15	1	-	120	1167	4	-	9	1196
2009	17	1	-	129	1676	5	2	10	1711
2010	16	1	-	138	2061	9	6	12	2105
2011	16	1	-	138	2057	8	9	13	2104
2012	17	1	-	188	2357	17	9	18	2419
2013	16	1	-	251	3187	20	14	15	3253
2014	16	1	-	247	3260	30	20	15	3342
2015	15	1	1	255	3340	37	27	15	3691
2016-I	15	1	1	251	3105	37	29	15	3454

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын эрэлтийг илэрхийлэгч үзүүлэлт - Тайлант хугацаанд 230,871 даатгалын гэрээ байгуулагдсан ба нийт гэрээний 200,517 нь иргэн, 30,354 нь хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ аж. Мөн хугацаанд салбарын хэмжээнд 8.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 15,560 даатгуулагчид төлж, учирсан хохирлыг барагдуулснаас ердийн даатгалын компаниуд 14,935 даатгуулагчид 8.36 тэрбум төгрөгийг, урт хугацааны даатгалын компани 625 даатгуулагчид 0.21 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгожээ.

Салбарын нийлүүлэлтийг илэрхийлэгч үзүүлэлт - Салбарын хэмжээнд сайн дурын болон албан журмын даатгалын хоёр төрлөөр Хорооноос зөвшөөрөгдсөн 23 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүнийг хувь хүн, хуулийн этгээдэд санал болгож ажилласан байна. Ердийн даатгалын компаниуд 17 хэлбэрийн бүтээгдэхүүнээс тайлант улиралд 14 хэлбэрийн бүтээгдэхүүнийг 35,910.54 тэрбум төгрөгөөр үнэлж, 26.9 тэрбум төгрөгийн хураамжтайгаар даатгажээ. Хураамжийн орлогын дүн өмнөх оны мөн үеийнхээс 23.0 хувиар буурчээ.


Нийт даатгасан зүйлийн үнэлгээний 28.2 хувийг барилга угсралтын, 20.7 хувийг агаарийн хөлгийн, мөн 20.7 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, 14.5 хувийг хөрөнгийн, 7.0 хувийг гэнэтийн

осол, эмчилгээний даатгал тус тус эзэлж байгаа бөгөөд дээрх 5 даатгалын хэлбэр нь нийт даатгалын зүйлийн 91.2 хувийг бүрдүүлж байна. Даатгалын компанийн хураамжийн орлогын 92.3 хувийг дээрх 5 төрлийн бүтээгдэхүүнээс бүрдүүлж, 49.2 хувийг хөрөнгийн, 19.4 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын, 9.7 хувийг авто тээврийн хэрэгслийн, 8.2 хувийг гэнэтийн осол, эмчилгээний, 5.9 хувийг хариуцлагын даатгалын хураамж тус тус эзэлж байна.

Урт хугацааны даатгалын компани 6 хэлбэрийн бүтээгдэхүүнээс тайлант улиралд 4 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүнийг 66.3 тэрбум төгрөгөөр үнэлж, 303.3 сая төгрөгөөр даатгасны 67.75 хувийг эрүүл мэндийн даатгал, 31.5 хувь нь хугацаат амьдралын даатгал тус тус эзэлж байна. Урт хугацаат даатгалын хураамжийн орлогын 75.1 хувийг эрүүл мэнд, 10.1 хувийг хугацаат амьдрал, 9.6 хувийг хуримтлал, 5.2 хувийг тэтгэврийн даатгалаас тус тус бүрдүүлсэн байна.

Салбарын хэмжээнд ердийн даатгалын 15 компаниас 5 компани дангаараа нийт хөрөнгийн 54.3 хувийг, хураамжийн орлогын 75.7 хувийг бүрдүүлж байгаа нь зах зээлийн өрсөлдөөнд цөөн компаниуд давамгайл оролцож байгааг илэрхийлж байна.

Дүрслэл 23. Зах зээлийн төвлөрөл




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

6.2.2 Даатгалын салбарын үйл хөдлөл /market conduct/

Даатгалын компаниуд бүтээгдэхүүнээ таниулан сурталчлах, харилцагчдын зан төлвийг судлах чиглэлээр зарцуулсан боруулалт, мартекингийн нийт зардлын 93.5 хувийг нэр

бүхий 5 компани бүрдүүлсэн байна. Үүнд: 45.5 хувийг “Монгол даатгал” ХХК, 15.6 хувийг “Бодь даатгал” ХХК, 13.3 хувийг “Ард даатгал” ХХК, 10.0 хувийг “Номин даатгал” ХХК, 9 хувийг “Тэнгэр даатгал” ХХК-ийн зардал тус тус эзэлжээ.

Дүрслэл 24. Борлуулалт, маркетингийн зардал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

6.2.3. Даатгалын салбарын гүйцэтгэл

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгийн дүн тайлант хугацаанд 159.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 9.0 хувь, 2015 оны жилийн эцсийн дүнгээс 8.0 хувиар тус тус өссөн байна. Нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл, 82.9 хувийг буюу 132.4 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө, 17.1 хувийг буюу 27.2 тэрбум төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байна. Даатгалын компаниудын эх үүсвэрийн 46.7 хувийг буюу 74.7 тэрбум төгрөгийг өр төлбөр, 53.3 хувийг буюу 85.1 тэрбум төгрөгийг эзэмшигчдийн өмч тус тус эзэлж байна.

Салбарын хэмжээнд хураамжийн орлого 27.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 23.0 хувиар буурсан хэдий ч цэвэр ашгийн хэмжээ 3.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13 дахин өссөн үзүүлэлттэй байна. Салбарын цэвэр ашгийн хэмжээ өсөхөд үйл ажиллагааны зардлын 36.4 хувийн буюу 3.9 тэрбум төгрөгийн хэмнэлт нөлөөлсөн бөгөөд урт хугацааны болон ердийн даатгалын компаниудын ашигт ажиллагааны түвшинг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 20. Ашигт ажиллагаа

Он	Даатгалын салбарын ашигт ажиллагаа		Урт хугацаат даатгалын ашигт ажиллагаа		Ердийн даатгалын ашигт ажиллагаа	
	Хөрөнгийн өгөөж	Өөрийн хөрөнгийн өгөөж	Хөрөнгийн өгөөж	Өөрийн хөрөнгийн өгөөж	Хөрөнгийн өгөөж	Өөрийн хөрөнгийн өгөөж
2010-I	2.2%	6.5%	-2.6%	-2.8%	2.4%	7.3%
2011-I	4.0%	9.8%	-4.1%	-4.7%	4.3%	10.8%
2012-I	3.1%	6.7%	-0.8%	-0.9%	3.3%	7.2%
2013-I	1.2%	2.4%	-0.9%	-1.0%	1.3%	2.6%
2014-I	-0.5%	-1.0%	0.6%	0.8%	-0.5%	-1.1%
2015-I	0.2%	0.4%	1.7%	2.2%	0.1%	0.3%
2016-I	2.3%	4.4%	0.2%	0.3%	2.4%	4.7%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

6.3 Даатгалын салбарын дэд бүтэц, зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт

Давхар даатгал: Урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд өссөн дүнгээр гадаадын давхар даатгалд нийт хураамжийн орлогынхоо 48.2 хувийг зарцуулж, 35,914.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй даатгалын зүйлийг давхар даатгуулаад байна.

Ердийн даатгалын компаниуд давхар даатгалд нийт 35,910.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй даатгалын зүйлийг даатгуулж, хураамжид 13.1 тэрбум төгрөгийг шилжүүлснээс, 76.3 хувийг хөрөнгийн, 8.9 хувийг барилга угсралтын, 6.6 хувийг агаарын хөлгийн, мөн 6.6 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын зүйлүүд тус тус зонхилж байна. Харин урт хугацааны даатгалын компанийн хувьд 2 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн болох хугацаат амьдралын болон хуримтлалын даатгалын 3.6 тэрбум төгрөгийн үнэлгээтэй даатгалын зүйлийг 9.0 сая төгрөгөөр давхар даатгуулжээ.

Даатгалын зуучлал, хохирол үнэлэгч: Даатгалын зуучлагчийн үйлчилгээ үзүүлэгч нь 41,775 даатгуулагчийн 1,555.6 тэрбум төгрөгийн үнэлгээтэй даатгалын зүйлийг

даатгахад зуучилж, 4.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг даатгалын компанид бүрдүүлэн, 0.6 тэрбум төгрөгийн зуучлалын шимтгэлийн орлогыг хуримтлуулжээ. Дээрх шимтгэлийн орлогын 78.7 хувийг нэр бүхий 6 даатгалын зуучлагч дангаараа бүрдүүлэв. Даатгалын хохирол үнэлгээний 29 компани даатгалын 3,616 тохиолдлыг 2.2 тэрбум төгрөгөөр үнэлж, 0.8 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлснээс 8 компани нийт орлогын 83.7 хувийг бүрдүүлжээ.

Салбарын зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт: Хорооноос даатгалын салбарын зохицуулалтын орчинд бүрдүүлэх чиглэлээр “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам, дансны жагсаалт”, “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам” болон “Даатгал, түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-уудыг тус тус шинэчлэн баталлаа.

БҮЛЭГ 7.

ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН ХӨГЖИЛ БА ХАНДЛАГА

ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Даатгал нь иргэд, аж ахуйн нэгжийн ирээдүйд бий болох эрсдэлийг бууруулах, нөөц сангаар дамжуулан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулалт хийх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангадаг. Өнөөгийн дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хурдацтай хөгжлийн үр дүнд бизнесийн олон боломжууд бий болж, даатгалын зохицуулалтад томоохон шинэчлэл явагдаж эхэлсэн.

Үүнтэй зэрэгцэн дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн бүс нутгийн хэмжээнд гэнэтийн байгалийн гамшигт үзэгдэл тохиолдох магадлал нэмэгдэж, эргээд даатгалын компаниудыг эд хөрөнгийн даатгал нь их хэмжээний алдагдалд оруулах эрсдэлийг бий болгоод байгаа тул цаашид даатгалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчид гамшгийн загварчлалыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага бий болжээ. Түүнчлэн даатгалын салбарт шинэ эрэлтийг бий болгоход дараах хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна. Үүнд: Мэдээллийн технологийн хувьсал, шинэчлэлтэй холбоотойгоор цахим аюулгүй байдлын эрсдэл, бүс нутгийг хамарсан байгалийн аюулт үзэгдэл, олон улсын терроризм гэх мэт.

Даатгалын салбарын хөгжлийн үйл явцад дэд бүтэц талаас уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн сувгийн томоохон өөрчлөлт, нийлүүлэлтийн талаас үнэт цаасжуулалтын хүчтэй нөлөөлөл, мөн мэдээлэл технологийн хувьсал гэсэн 3 хандлага хүчтэй нөлөө үзүүлж байна.

Уламжлалт даатгалын тогтолцоо нь олон төрлийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрүүдтэй, эрсдэлийг тооцох арга механизм, техник технологийг хөгжүүлсэн хэдий ч бага, дунд орлоготой иргэд, жижиг дунд үйлдвэрлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ хэлбэрүүдийг төдийлөн хөгжүүлж чадаагүй билээ. Гэтэл хөгжиж буй орнуудад бичил, жижиг дунд үйлдвэр эрхлэгч, бага дунд орлоготой иргэдэд чиглэсэн бичил даатгалын хэрэгцээ нэн шаардлагатай байгаа тул хүртээмжтэй даатгалын чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудын туршлагыг үүгээр хураангуйлан хүргэхийг зорилгоо.

“Их 20”-оос гаргасан санхүүгийн хүртээмжийн зарчмын дагуу Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбоо /IAIS/-ноос хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх зөвлөмжийг боловсруулан зохицуулалтын байгууллагуудыг хэрэгжүүлэхийг уриалсан.

Олон улсын түвшинд хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх чиглэлээр IAIS-ны дэргэд Access to insurance initiative, ILO’s, Microinsurance innovation facility, Microinsurance network зэрэг байгууллагууд ажилладаг бөгөөд бүс нутгийн түвшинд мэргэжлийн холбоод, доноруудын идэвхтэй дэмжлэгтэйгээр хүртээмжтэй даатгалыг эрчимжүүлж байна.

Тус холбооноос хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд орлого багатай иргэн, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид чиглэсэн бага хураамжтай даатгалын бичил бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, дээрх үйлчилгээг хүргэх түгээлтийн сувгуудыг дэмжих, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлээр гүйцэтгэхийг тусгайлан онцолжээ.

ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн тэгш бус байдлыг арилгах, нэн ядуу иргэдийн нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд олон нийтийн санхүүгийн суурь боловсролын түвшинг дээшлүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан тогтолцоог бий болгох, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэхэд төрөөс урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр болон зохицуулалт, хяналтын орчинг бүрдүүлэхийг “Их 20”-ийн төрийн тэргүүн нар уриалсан.

Энэ хүрээнд хөгжингүй болон хөгжиж буй орнуудад хүртээмжтэй санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, үр ашигтай хэлбэрээр үйлчилгээг хүртэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, заавар, стандартад үндэслэн үндэсний бодлого, хөтөлбөр, төрийн зохицуулалт, хяналтын орчинг шинэчлэх шаардлага үүссэн. Төрийн зохицуулалт, хяналтын байгууллагууд даатгалын салбарын шударга, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилгоо ханган ажиллахаас гадна иргэд, аж ахуй нэгжүүд ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалахад чиглэгдсэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хүртээмжийг дэмжиж ажиллах давхар үүрэг, хариуцлагын тогтолцоо нэмэгдлээ.

Сүүлийн жилүүдэд хөгжиж буй орнуудын зохицуулалтын байгууллагууд зохистой хяналттай, зөв хөшүүрэгтэй,

хэрэглэгчийн эрх ашгийг дээд түвшинд хамгаалсан, бага орлоготой иргэд, жижиг, аж ахуй нэгжүүдэд зориулан өргөн хүрээг хамарсан, тогтвортой, чанартай санхүүгийн үйлчилгээг бий болгохоор ажиллаж байна.

Төрийн зохицуулагч байгууллагын зүгээс даатгалын компани болон оролцогч талуудтай хамтран даатгалын үйлчилгээ хүртэж чаддаггүй нийгмийн бүлгүүдэд хүрч үйлчлэхийн тулд бүтээгдэхүүн, үйлчилгээний бүтэц, борлуулалт түгээлтийн суваг, технологийн хэрэглээг шинэчлэн хөгжүүлэхэд зохицуулалтын орчноо уян хатан болгох, хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох, боломжит шийдэлд хүрэхэд зорьсон судалгаа, шинжилгээний ажлыг хийх шаардлага тулгарч байна.

Гадаад улсуудын туршлагаас харахад хүртээмжтэй даатгалыг үндэсний хэмжээнд хөгжүүлэхэд урт хугацааны бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, даатгалын бичил бүтээгдэхүүн үйлчилгээнд тавьж буй зохицуулалт, хяналтыг бууруулах, уг үйлчилгээг үзүүлж буй даатгалын компаниудын өөрийн хөрөнгийн болон дүрмийн сангийн хэмжээг бусад даатгалын компаниудтай харьцуулахад багаар тогтоох, олон төрлийн түгээлтийн сувгийг бий болгох зэргээр санхүүгийн хөшүүргийн механизмыг бүрдүүлэх шаардлага харагдаж байна.

Мөн санхүүгийн зах зээлийн хэмжээнд үр ашигтай, тогтвортой хүртээмжийн тогтолцоог бүрдүүлэхийн тулд бага орлоготой нийгмийн бүлэгт чиглэсэн төлбөр тооцоо, бичил зээл, хадгаламжийн болон даатгалын бичил үйлчилгээний хэлбэрүүдийг цогцоор нь бодлогын түвшинд хөгжүүлэх хэрэгтэйг олон улсын байгууллагуудаас зөвлөжээ.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙН ХАМГААЛАЛ

Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх явцад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд төрийн зохицуулагч байгууллагаас даатгалын гэрээ болон гэрээний дагуу хураамжийн орлого цуглуулах, нэхэмжлэл гаргах ажиллагаа, нөхөн төлбөр олгох гэсэн процессийн үйл явцад хяналт тавьж, даатгуулагчийг залилангаас сэргийлэх нь чухал. Нөгөө талаас даатгуулагч нь гэрээний ялгаатай хэлбэр болон бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар дутуу мэдээлэлтэй байдгийн улмаас мэдээллийн тэгш бус байдал үүсч, өөртөө хохиролтой даатгалын гэрээ байгуулахад хүрдэг.

Иймд төрийн зохицуулагч байгууллагаас хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр даатгагч, мэргэжлийн зуучлагчдын санхүүгийн болон үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах, ёс зүйн болон холбогдох дүрэм, журмыг мөрдүүлэх, гэрээний стандарт нөхцлийг тогтоож өгдөг. Манай орны хувьд бага орлоготой иргэдэд чиглэсэн бичил даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үүсэн бий болох шатандаа явагдаж байгаа бөгөөд цаашид хүртээмжтэй даатгалын тогтолцоог хөгжүүлэх, зохицуулалт хяналтын орчинг бүрдүүлэх чиглэлээр гадаад орнуудын туршлагыг судлах шаардлагатай.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

Иргэдийг санхүүгийн болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, мэдээлэл олгох, ирээдүйд учирч болох эрсдэлээ ухамсарлан даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамруулахад төрөөс санхүүгийн суурь боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай. Даатгалын боловсролыг тухайн хүнд тохиолдож болох эрсдэлийг ухамсарлуулах, үүний дараа даатгуулж болох эрсдэлийг тодорхойлох зэрэг үе шаттайгаар олгодог. Тухайлбал, Энэтхэг улсад цаг агаарын таагүй нөхцөл байдлын эсрэг даатгуулахыг сануулах чиг үүрэг бүхий "Цаг агаарын эрсдэлийн удирдлагын үйлчилгээний байгууллага" ажилладаг ба энэ байгууллага нь хүмүүст өнгөрсөн жилүүдийн ургацын алдагдал, урьдчилсан төлөв байдлыг мэдээлэх зэргээр сануулга өгдөг байна.

Манай орны хувьд Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ-наас "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг хамтран боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны хуралдаанаар батлуулан, хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийн үндэсний цахим хуудас бүтээх чиглэлээр Хорооны зүгээс даатгалын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

БИЧИЛ ДААТГАЛ

Өнөөдрийн байдлаар дэлхийн хүн амын 36.0 хувь буюу 2.5 тэрбум нь бага орлоготой, ядуу, нэн ядуу гэсэн нийгмийн бүлэгт хамрагдаж байна. Тиймээс дэлхий нийтээрээ нийгмийн эдгээр бүлэгт амьдарч буй хүмүүсийг байгалийн гамшигт үзэгдэл, галын аюул, өвчин, гэнэтийн золгүй явдал зэрэг эрсдэлтэй учрахад гарсан хохирлыг бие даан шийдвэрлэх чадваргүй гэж үздэг бөгөөд төрийн зүгээс анхаарал хандуулахгүй орхих нь эргээд гэмт хэрэг, ядуурал, нас баралтын түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжлийн түвшин саарахад нөлөөлдөг гэж үзжээ.

Түүнчлэн Олон улсын валютын сангаас хийгдсэн судалгаагаар хөгжиж буй орнуудад 17.0 сая жижиг, дунд бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр аж ахуй нэгжид бүтээгдэхүүний шинэчлэл, технологийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор ирээдүйд бий болох эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх даатгалын механизм бүрдээгүй байгааг онцолсон байна. Арилжааны даатгалын тогтолцоо нь нийгмийн бүлгүүдийг эрсдэлээс хамгаалах чиг үүргийг гүйцэтгэдэг хэдий ч уламжлалт даатгалын тогтолцоо нь бага орлоготой, жижиг бизнес эрхлэгчдэд тохирсон даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хэлбэрүүдийг хөгжүүлдэггүйгээс бага орлоготой, ядуу иргэд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн даатгалын хамралт хангалтгүй түвшинд байна.

Бичил даатгал гэдэг нь бага орлоготой иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчид ирээдүйд учрах санхүүгийн болон бусад эрсдэлээс хамгаалах үүднээс тэдний эрэлт, хэрэгцээ, орлогын хэмжээ, эрсдэлийн түвшин, эрсдэл учрах магадлалд үндэслэсэн бага хураамжтай даатгалын бүтээгдэхүүнийг ойлгох бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээ нь богино хугацааг хамарсан, гэрээний стандарт нь тодорхой

нөхцөл бүхий эрсдэлүүдээр хязгаарлагдсан тогтолцоо юм.

Өрхийн санхүүгийн эрсдэлийг даатгалын механизмаар хамгаалах нь бага орлоготой даатгуулагчдад тохиолдох эрсдэлийг зөв үнэлж, даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд нөхөн төлбөрийг цаг алдалгүй олгох нь эргээд нийгмийн баялгийн дахин хуваарилалтыг оновчтой болгож, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмждэг ба даатгалын бичил бүтээгдэхүүнийг иргэдэд чирэгдэлгүй, өртөг багатайгаар хүргэснээр иргэдийн эрүүл мэндийн түвшин сайжрах, ажил эрхлэлт нэмэгдэх, сургуульд элсэн суралцагчдын тоо нэмэгдэх зэрэг давуу талтай. Төрийн зохицуулагч байгууллагаас бодлогын түвшинд даатгалын эрэлт, нийлүүлэлтийг түгээлтийн сувгаар дамжуулан цогц байдлаар уялдуулан хөгжүүлэх шаардлагатай бөгөөд чиг үүргийг хянавал:

Төрийн үүрэг оролцоо: Иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээгээр хангах үүрэгтэй боловч санхүү, төсвийн хувьд хязгаарлагдмал байдаг тул энэхүү зорилгыг бүрэн хэрэгжүүлж чаддаггүй. Тиймээс хүртээмжтэй даатгалыг даатгалын үйлчилгээ хүрдэггүй нийгмийн бүлэгт чиглүүлэхээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан борлуулалт түгээлтийн сувгийг өргөжүүлдэг.

Нөгөө талаас, бичил даатгалын эрэлтийг дэмжих чиглэлээр хураамжийн орлогод ногдох татварыг хөнгөлж чөлөөлөн, зарим төрлийн татаасыг хувийн даатгалын компанид олгох, олон нийтийн санхүүгийн боловсролын үндэсний хөтөлбөрүүдээр дамжуулан иргэдэд даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг өгөх, ирээдүйд учирч болох эрсдэлийг ухамсарлах чадварыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүртээмжтэй даатгал нь олон нийтийг эрсдэлээс хамгаалах нийгмийн даатгалын орлох бүтээгдэхүүн, нэмэлт үйлчилгээг санал болгодог нь нийгмийн даатгалын салбар дахь төрд ногдож буй ачааллыг бууруулах давуу талтай.

Нийлүүлэлтийн тал буюу даатгагч: Бичил даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд хөгжүүлж, эрсдэлийг хариуцдаг 3 төрлийн даатгагч байдаг:

- Гишүүддээ үйлчилж, эрсдэлийг нь удирдах даатгалын сан;
- Бага орлоготой иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн эрсдэлийг даатгах чиг үүрэг бүхий арилжааны даатгалын компани;
- Үндэсний нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Засгийн газрын байгууллага.

Тухайлбал, даатгалын сангийн гишүүд нь даатгуулагч байх ба нөхөн төлбөрийг цаг тухайд нь олгох, аливаа ёс зүйгүй үйлдлийн хяналт, шалгалтыг оновчтой хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг ойлгодог учраас хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлдэг давуу талтай.

Бага орлоготой иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд бичил даатгалын бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхэд зорилтот даатгуулагчдын зан төлөв, хандлага, итгэл үнэмшлийг өөрчилж, соёлыг төлөвшүүлэх нь хамгийн бэрхшээлтэй суурь асуудал. Иймд түгээлтийн сувгуудыг оновчтой бүрдүүлэх шаардлагатайг хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлага харуулж байна. Ингэснээр урт хугацаандаа хэрэглээний соёл, сонирхол,

сэтгэл ханамжийн үзүүлэлт нэмэгддэг байна.

Орлого багатай иргэд ахуйн олон төрлийн хэрэгцээгээ зэрэг хангахаар тэмүүлдэг нь эргээд даатгалд хамрагдах сонирхлыг бууруулж, үйлчилгээний хураамж төлөх нь тэдний хувьд хүндрэлтэй тул даатгагчийн зүгээс эдгээр бэрхшээлтэй нөхцлийг ойлгон, оновчтой шийдлийг хайх, гэрээ, хэлцлийн зардлыг бууруулах чиглэлээр санхүүгийн дэвшилтэт технологийг ашиглаж, түгээлтийн олон сонголт бүхий сувгийг хөгжүүлэх хэрэгтэйг олон улсын байгууллагуудаас зөвлөсөн.


Энэтхэг, Филиппин, Кени зэрэг улсад хэрэглэгчдийг эрсдэлээс хамгаалах, тэдний хэрэгцээнд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх чиглэлээр бүтээгдэхүүний хөгжлийн эхний шатанд хэрэглэгчийн үнэ цэнийг Product, access, cost, experience /PACE/ үнэлгээний аргачлалаар үнэлж байна. Энэхүү аргачлал нь шинэ бүтээгдэхүүн хэрэглэгчийн хэрэгцээнд хэрхэн нийцэж байгаа, бага орлоготой иргэдийн сонголтод ямар хүчин зүйлс нөлөөлж байгаа, сэтгэл ханамжийн түвшин өмнө нь ямар байсан, даатгуулагчийн ирээдүйд бий болох эрсдэл, эмзэг байдлыг бууруулах зэргийг илрүүлэх санал асуулга, тоон өгөгдлийг ашигладаг шинжилгээ юм.

Тэрээр дор дурдсан урьдчилсан нөхцөл бүрдсэн тохиолдолд бодит үнэлгээ болдог байна. Үүнд:

- Нийгмийн зорилтот бүлгүүдэд тулгарч буй эрсдэлийг даатгалын бүтээгдэхүүнээр удирдах боломж бүрдсэн байх /appropriate/;
- Санал болгож буй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн суваг нь байршлын хувьд зорилтот бүлэгт хүрч чадахуйц байх /accessible/;
- Зорилтот бүлгүүдийн санхүүгийн чадавхид нийцсэн, боломжтой үнийн санал бүрдсэн байх /affordable/;
- Даатгуулагчид олгох нөхөн төлбөрийг цаг тухайд нь олгох, үүнтэй холбоотой нэмэлт зардал шаардахгүй байх, эсрэг тохиолдолд даатгагчаас энэ талаар оновчтой хариу тайлбарыг өгдөг байх /responsive/;
- Зорилтот бүлэгт тохирсон, ойлгож хэрэглэхэд энгийн байх /simple/.

Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлагаас харахад бага орлоготой өрхөд тулгарч буй эрсдэлүүдийг хамарч чадсан, тэдгээрийн эрэлтэд нийцсэн голлогч даатгалын бүтээгдэхүүн нь эрүүл мэнд, амьдралын даатгал аж. Гэсэн хэдий ч даатгагчийн хувьд бага орлоготой өрхийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн шинээр гаргахад даатгуулагчтай холбоотой мэдээллийн сан үүсээгүй тул эрсдэлийг нарийн тодорхойлох боломжгүйгээс өндөр хураамж тогтоож, бүтээгдэхүүний эрэлтийг бууруулахад нөлөөлдөг.

Дүрслэл 25. Бичил даатгалын бүтээгдэхүүний хувьсал



Эх сурвалж: *Protecting the poor: A microinsurance compendium*
Volume II by Craig Churchill and Michal Matul, 2012

Эрэлт бий болох хүчин зүйлс: Бага орлоготой, ядуу иргэдийн хувьд тэдгээрийн олж буй орлого тогтвортой бус, ирээдүйд бий болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр даатгалын бүтээгдэхүүн худалдан авах хураамжийг төлөхөд хүндрэлтэй, даатгал гэж юу болох, өөрт нь учирч болзошгүй эрсдэлийг удирдах талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, даатгалын үйлчилгээг хэрэглэх уламжлал төлөвшөөгүй байдаг. Энэ нь хүртээмжтэй даатгалыг дэлгэрүүлэхэд тулгарч буй нийгэм болон хүн ам зүйн бэрхшээлтэй асуудал болдог.

Иймд хөгжиж буй болон хөгжингүй орнуудад санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрт бичил даатгалыг таниулан сурталчлах дэд хэсгийг тусган хэрэгжүүлж, бага орлоготой иргэдийг эрсдэлээ ухамсарлан зөв сонголт хийхийг таниулах замаар даатгалын эрэлтийг дэмжих арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байна. Манай орны хувьд өмнө дурьдсан “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн санхүүгийн мэдлэг олгох 5 хүрээний нэг болох даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах нь цаашид даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхэц болно.

ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН БОРЛУУЛАЛТ, ТҮГЭЭЛТИЙН СУВАГ

Аливаа даатгалын бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд дөхөм хүргэхэд газар зүйн алслагдмал байдал бэрхшээлийг үүсгэдэг. Тиймээс даатгагчийн зүгээс алслагдсан бүс нутгийн иргэдэд чиглэсэн түгээлтийн сувгуудыг санхүүгийн дэвшилтэт технологид түшиглэн хөгжүүлэх, зуучлалын болон дэд бүтцийн хөшүүргийг уялдуулах нь зүйтэй.

Сүүлийн жилүүдэд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын төрийн зохицуулагч байгууллагаас гар утас, цахим сүлжээгээр дамжуулан хэрэглэгчтэй харилцах, мэдээ,

мэдээллээр хангах, хураамжийн орлого цуглуулах, нөхөн төлбөрийг олгох чиглэлээр ашиглахыг зөвшөөрч, бусад түгээлтийн олон төрлийн сувгийг бодлого, зохицуулалтын түвшинд дэмжиж байна. Түүнчлэн уламжлалт түгээлтийн сувгууд болох даатгалын брокер, банкны зуучлал нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхэд чухал үүрэгтэй хэвээр байгааг онцолсоор байна.

Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбооны тайлан, бусад судалгааны ажлуудад сүүлийн 10 жилийн хугацаанд банк, санхүү, худалдааны байгууллагууд өөрийн үндсэн үйл ажиллагаанаас гадна нэмэлт орлого олох зорилгоор бичил даатгалын үйлчилгээг өртөг багатайгаар нийтэд хүргэж, зуучлалын үйлчилгээг давхар үзүүлэх хандлага ажиглагдаж байгааг дурьдсан байна.

Зарим хөгжиж буй орнуудад зуучлалын үйлчилгээг бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид, төлөөлөгчийн газар, жижиглэн худалдаачид, даатгалын брокерууд, төрийн бус болон нийгэмлэгт суурилсан байгууллагууд, ажил олгогч, сүм, хийд, хөдөө аж ахуйн хоршоод давхар гүйцэтгэж, хэрэглэгч болон гишүүддээ хүргэх үйлчилгээгээ нэмэгдүүлж байна.

Гэвч даатгагч болон түгээлтийн сувгийн хоорондын харилцааг удирдахад санхүүгийн хүндрэл үүсдэг тул даатгагч нь түгээлтийн сувгийн этгээдтэй ашиг хуваалцах механизм, эсвэл компани хамтран эзэмшихээр санал болгох нь үр дүнтэй хөшүүрэг болдог.

Хүртээмжтэй даатгалын түгээлтийн сувгийн тухайд зайлшгүй авч үзэх шаардлагатай зүйл бол шууд болон шууд бус борлуулалтын асуудал юм. Шууд бус борлуулалт гэдэг нь хэрэглэгч даатгалын бүтээгдэхүүнийг худалдан авахдаа хэн нэгэн дундын зуучлагчтай харилцаа үүсгэхгүй, худалдан авах шийдвэр гаргахад хөндлөнгийн этгээд нөлөөлдөггүй хэлбэрийг ойлгоно. Харин шууд борлуулалт гэдэг нь хэрэглэгчийг даатгалын бүтээгдэхүүн худалдан авахад нь

даатгалын төлөөлөгч болон зуучлагч бүтээгдэхүүний үр өгөөжийг таниулан сурталчилж, зөвлөгөө өгч, худалдан авалтын сонголтод хүчтэй нөлөө үзүүлэхийг хэлнэ.

Олон улсын даатгалын зах зээл, даатгалын түгээлтийн сувгуудын хөгжилд даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах, хураамжийн орлогыг цуглуулахаас гадна тухайн даатгалын гэрээний нөхцөлийг өөрчлөх, нөхөн төлбөр

олгох нэг цонхны үйлчилгээний хэлбэрт шилжиж байна. Хэрэглэгч заавал өөрийн биеэр даатгалын бүтээгдэхүүнийг худалдан авахад үүсдэг уламжлалт түгээлтийн сувгийн бэрхшээлүүдийг санхүүгийн шинэ технологид суурилсан түгээлтийн сувгаар шийдэж байгаа нь хэлцлийн зардлыг бууруулах, хурдан шуурхай үйлчилгээний боломжийг бүрдүүлж байна.

Хүснэгт 21. Түгээлтийн сувагт ашиглагддаг технологийн хэлбэрүүд

Хураамжийн төлбөр	Даатгалын тохиолдлын баталгаажуулалт	Хэлцлийн үйл явц	Мэдээний шинжилгээ
Байршил заагчтай гар утас	Радио давтамжийг тодорхойлох хэрэгсэл	Програм хангамж	Мэдээллийн баазын шинжилгээ
Богино мессежийн үйлчилгээ	Биометр	Дуудлагын төв	Цаг агаарын мэдээ
Ухаалаг карт	Цаг агаарын индекс	Удирдлагын мэдээллийн систем	Мэдээг тодорхойлох хиймэл дагуул
ПОС терминал	Сансраас зураг авах технологи	Интернетээр дуу хураагч	
Бүртгэл тодорхойлогч модел	Зайнаас шинжилгээ хийх	Мэдээний стандартчилал	
Утасны төлбөрийн платформ			
Утасгүй интернетийн үйлчилгээг хангагч			
Радио үйлчилгээ /GPRS/			

Эх сурвалж: *Protecting the poor: A microinsurance compendium Volume II* by Craig Churchill and Michal Matul, 2012

Монгол улс дахь бичил даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:

Монгол Улсад бичил даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр 2014 онд суурь судалгааны ажлыг Азийн хөгжлийн банкнаас анхлан хийсэн бөгөөд уг судалгааны тайлангаар манай орны нийт хүн амын 40.0 хувь нь нийслэл, 60.0 хувь нь хөдөө орон нутагт суурьшиж, хүн амын 15.0 хувь нь дундаас дээш орлоготой, 25.0 хувь нь ядуу, нэн ядуу ангилалд багтаж байгааг дурьджээ. Мөн тайланд 430,000 өрх даатгалын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа бөгөөд тэдгээрт бичил даатгалын үйлчилгээ нэн шаардлагатай байгааг онцолжээ.

Судалгааны үр дүнгээр нэн тэргүүн ээлжинд даатгалын үйлчилгээ авч чадахгүй байгаа нийгмийн бүлгүүдэд урт хугацаат эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг нийгмийн даатгалын үйлчилгээний нэмэлт, хавсарга байдлаар хүргэх, үүний тулд бага хэмжээний хураамж тогтоох, хүн амын нягтрал бага, алслагдмал бүс нутгуудад хэлцлийн зардал бага байхаар түгээлтийн сувгуудыг бий болгохыг зөвлөсөн. Түүнчлэн Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компаниудыг бичил бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх чиглэлд дэмжих үүднээс олон улсын донор байгууллагын тусламж, дэмжлэгийг авч хэрэгжүүлэх шаардлагатайг дурьджээ.

Өнөөгийн нөхцөлд бичил даатгалыг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх, даатгалын салбарт оролцогч байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, салбарын ашигт ажиллагааг сайжруулах, уламжлалт бус шинэ түгээлтийн сувгуудыг бий болгох сорилтууд бидний өмнө тулгарч байх тул цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах /Үүнд даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх дэд бүлгийг оруулах/;
- Бичил даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр төрийн зохицуулалт, хяналтын тогтолцоог эрэлт, нийлүүлэлтийг дэмжсэн байдлаар тогтоох;
- Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх.

БҮЛЭГ 8.

БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР

8.1. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА (ББСБ)


8.1.1. Банк бус санхүүгийн байгууллагын эдийн засагт үзүүлэх нөлөө

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт активын хэмжээ 634.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 22.9 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Нийт активын 96.0 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлсэн ба үүнээс 63.2 хувийг зээл, 28.2 хувийг мөнгөн хөрөнгө тус тус бүрдүүлжээ.

Өмнөх оны мөн үеэс ББСБ-уудын тоо 68-аар нэмэгдэж, нийт олгосон зээлийн хэмжээ 20.6 хувиар өссөн нь нийт активын хэмжээ нэмэгдэхэд голлон нөлөөлжээ.

Дүрслэл 26. ББСБ-уудын нийт хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт активын ДНБ-д эзлэх хувь: ББСБ-уудын нийт активын хэмжээ ДНБ-ий 13.5 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2.32 хувиар өссөн байна.

Зээлийн ДНБ-д эзлэх хувь: ББСБ-уудын нийт зээлийн хэмжээ ДНБ-ий 8.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.3 хувиар өсчээ.

Дүрслэл 27. ББСБ-уудын нийт зээл, зээлийн чанар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын олгосон нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 68.3 тэрбум төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн бол чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа 11.4 хувьд хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өсчээ. Чанаргүй зээлд багтах муу зээлийн хэмжээ 2 дахин нэмэгдсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор зээлийн эрсдэлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 11.5 тэрбум төгрөгөөр буюу 61.0 хувиар өссөн байна.


Нийт зээл олголтын хэмжээ нэмэгдэж байгаа хэдий ч, үүнийг дагаад чанаргүй зээлийн хэмжээ огцом нэмэгдсэн нь цаашид салбарын хэмжээнд төлбөрийн чадварын эрсдэлийг нэмэгдүүлэх төлөв байдал ажиглагдлаа. Тухайлбал, нийт чанаргүй зээлийн хэмжээ 45.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс даруй 88.2 хувиар өсчээ.

Нийт зээлийн бүтцийн хувьд төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өссөн бол гадаад валютаар олгосон зээл 1.03 тэрбум төгрөг буюу 3.0 хувиар буурсан байна.

Мөн ББСБ-уудын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулж үзэхэд хоёр дахин их буюу дунджаар 3.5 хувьтай байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд зохицуулагч байгууллагаас зээлийн хүү, эх үүсвэрийн өртгийг бууруулах, зээлийн хүү тооцох аргачлал, журам боловсруулах чиглэлээр холбогдох судалгааг хийн ажиллаж байна.

Тайлант хугацаанд 15 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 2 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт ББСБ-ын тоо 463-д хүрэв.

Дүрслэл 28. Бүртгэлтэй ББСБ-ын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар нэмэгдсэн ба үүнд зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 70, факторингийн үйлчилгээ эрхлэгчид 4, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэгч 3 компаниар тус тус нэмэгдсэн байна.

Нийт ББСБ-аас 426 нь тайлангаа зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд эхлэлтийн санхүүгийн тайлангаар 15 ББСБ нэгтгэлд хамрагджээ.

Хүснэгт 22. ББСБ-уудын статистик үзүүлэлтүүд

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015-I	2016-I
1	ББСБ-ын тоо	395	463
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	830	904
3	Ажиллагсадын тоо	1623	2000
4	Салбар нэгжийн тоо	109	121
5	Харилцагчдын тоо	405,558	445,918
6	Нийт актив /тэрбум төгрөгөөр/	515.9	634.1
	Банкны салбарт эзлэх хувь	2.5%	2.9%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум төгрөгөөр/	332.1	400.5
	Банкны салбарт эзлэх хувь	2.8%	3.5%
8	Нийт эзэмшигчдийн өмч /тэрбум төгрөгөөр/	337.3	455.5
	Банкны салбарт эзлэх хувь	14.1%	17.5%
9	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/	28.4	29.4
10	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /тэрбум төгрөгөөр/	120.8	110.7
	Үүнээс: Богино хугацаат зээл	63.2	59.0

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ 2016 - I УЛИРАЛ

11	Урт хугацаат зээл	57.5	51.6
12	Төслийн зээлийн санхүүжилт	13.3	15.0
13	Нийт орлого	37.0	41.0
14	Нийт зардал	28.0	33.9
15	Тайлант үеийн ашиг	8.9	12.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 23. ББСБ-уудын үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл

Д/д	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын өсөлт /давхардсан тоогоор/		Өөрчлөлт	
		2015-I	2016-I	тоо	хувь
1	Нийт ББСБ	395	463	68	17.2
2	Гадаад валютын арилжаа эрхэлдэг	137	140	3	2.1
3	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	53	51	(2)	(3.8)
4	Зээл	16	20	4	24.0
5	Факторингийн үйлчилгээ	10	13	3	30.0
6	Төлбөрийн баталгаа гаргах	0	0	-	-
7	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	7	1	16.7
8	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	24	27	3	12.5
9	Итгэлцлийн үйлчилгээ	2	1	(1)	(50.0)
10	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	25	32	7	28.0
11	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	53	51	(2)	(3.8)

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт ББСБ-ын 88.3 хувь нь зээлийн үйл ажиллагаа, 6.9 хувь нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.8 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 4.3 хувь нь факторингийн үйлчилгээ, 2.8 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 1.5 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.2 хувь буюу 1 компани богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлж байна.

ББСБ-уудын тоо нэмэгдэж байгаа хэдий ч, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын тоо төдийлөн нэмэгдэхгүй байна. Тухайлбал, нийт ББСБ-аас 88.8 хувь нь Улаанбаатар хотод, 11.2 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

8.1.2. Банк бус санхүүгийн байгууллагын үр ашигт байдал

ББСБ-уудын нийт эх үүсвэрийн 26.1 хувийг өр төлбөр, 73.9 хувийг эзэмшигчдийн өмч эзэлж байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөрийн хэмжээ 10.1 хувиар буурч, эзэмшигчдийн өмч 35.0 хувиар өсчээ. Мөн тайлант хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 79.2 тэрбум төгрөг буюу 30.2 хувиар өсөхөд ББСБ-уудын тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 24. ББСБ-уудын санхүүгийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014	2015	2016-I
Нийт актив	128.6	205.4	252.1	381.1	508.0	623.1	634.1
Нийт олгосон зээл	78.1	119.0	157.8	223.7	303.1	391.2	400.5
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	128.6	205.4	252.1	381.1	508.0	623.1	634.1
Нийт өр төлбөр	36.6	67.2	80.7	146.8	164.6	175.6	160.5
Эзэмшигчдийн өмч Үүнээс:	92.0	138.2	171.3	234.3	332.1	424.2	455.5
Хувьцаат катитал	80.0	116.5	137.9	183.7	258.2	308.4	341.2
Бусад өмч	0.5	3.2	7.6	7.2	7.2	12	11.2
Сангууд	1.1	1.1	0.1	0.2	0.2	0.3	0.5
Хуримтлагдсан ашиг/алдагдал	9.4	14.7	24.2	41.7	64.0	102	101.7

Хоёрдогч өглөг	0.9	2.7	1.6	1.6	2.4	1.4	0.8
Нийт орлого	30.1	46.3	70.5	106.6	132.9	156.3	41.0
Нийт зарлага	22.9	34.9	51.9	76.8	96.5	110	33.9
Татварын дараах цэвэр ашиг	7.1	11.4	18.6	29.8	36.4	46.3	12.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт цэвэр ашгийн хэмжээ 12.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 тэрбум төгрөг буюу 42.3 хувиар өссөн байна. Дээрх өсөлтөд нийт хүүгийн орлого 25.7 хувь, үндсэн бус үйл ажиллагааны орлого 66.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.

Нийт зардлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.19 тэрбум төгрөг буюу 0.7 хувиар, үүний дотор хүүгийн зардал

4.1, болзошгүй эрсдэлийн зардал 31.1, орлогын татварын зардал 25.3 хувиар тус тус өссөн бөгөөд үндсэн үйл ажиллагааны зардлууд харьцангуй бага өсөлттэй байхад, болзошгүй эрсдэлийн зардлын хэмжээ өндөр хувьтай байгаа нь чанаргүй зээлийн хэмжээ өсч байгааг харуулж байна. Тухайлбал, нийт чанаргүй зээлийн хэмжээ 45.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 88.2 хувиар өссөн бөгөөд нийт зээлийн 11.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 25. Орлого, зарлага, ашигт ажиллагаа /тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2016-I
1	Нийт орлого	41.0
	Хүүгийн орлого	33.4
	Хүүгийн бус орлого	6.8
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	0.7
2	Нийт зардал	28.2
	Хүүгийн зардал	4.3
	Хүүгийн бус зардал	16.5
	Болзошгүй эрсдэлийн зардал	5.6
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.21
3	Орлогын татварын зардал	1.6
4	Татварын дараах цэвэр ашиг	12.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлт: Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан "ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын дагуу зохистой харьцааны

үзүүлэлтийг 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын хэмжээнд хэрхэн хангаж байгаа талаар хүснэгтлэн дор үзүүлэв.

Хүснэгт 26. Зохистой харьцааны үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Шаардлагат түвшин	2016-I
1	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт:		
	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	10%<=	84.4
	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	20%<=	85.0
	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%<=	67.8
2	Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт:		
	Итгэлцлийн үйлчилгээний өглөг ба хувьцаат капиталын хувьцаа	80%>=	6.4
3	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар:		
	Түргэн борлогдох актив, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа	8%<=	103.9
4	Үндсэн хөрөнгийн үзүүлэлт:		
	Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн ба нийт активын харьцаа	15%>=	1.8

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

ББСБ-уудын нийт чанаргүй зээлийн хэмжээ өсч байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:


- Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээнд ББСБ-уудыг бүрэн хамруулах;
- Хугацаа хэтэрсэн зээл болон чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа байдалд дүгнэлт хийж, арга хэмжээ авах;
- ББСБ-уудын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг сайжруулах, зайны болон газар дээрх шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, тайлан мэдээг цаг хугацаанд нь хүлээн авч байх тал дээр анхаарч ажиллах.

8.2. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО (ХЗХ)

8.2.1. Хадгаламж, зээлийн хоршоодын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө

Тайлант хугацааны ХЗХ-дын нийт активын ДНБ-д эзлэх хэмжээ 2.2 хувьд хүрсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувиар өсчээ. Нийт активын хэмжээ 101.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.4 хувиар өсөөд байна.

Дүрслэл 29. Хадгаламж, зээлийн хоршоодын актив /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн үзүүлэлт: ХЗХ-дын нийт зээлийн хэмжээ 80.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.2 хувиар өссөн. Тайлант хугацааны ДНБ-д

эзлэх нийт зээлийн хэмжээ 1.71 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.16 хувиар өслөө.

Дүрслэл 30. ХЗХ-дын нийт зээлийн чанар /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын нийт хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 3.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 67.4 хувиар, нийт чанаргүй зээлийн хэмжээ 75.9 хувиар тус тус өссөн байна. ХЗХ-дын нийт зээлийн хэмжээ өсөхөд ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үеэс 64-өөр буюу 30.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хадгаламжийн үзүүлэлт: 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ 62.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.14 тэрбум төгрөг буюу 10.8 хувиар өссөн. Тайлант хугацаанд ДНБ-д эзлэх хадгаламжийн хэмжээ 1.3 хувьд хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувиар өссөн байна.

Дүрслэл 31. ХЗХ-дын нийт хадгаламж /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ нийт эх үүсвэрийн 61.9 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 60.5 тэрбум төгрөг буюу 96.4 хувь нь хугацаатай хадгаламж бол 3.6 хувь нь хугацаагүй хадгаламж байлаа.

Өр төлбөр, өөрийн хөрөнгө: ХЗХ-дын хоршоологчдын өмч

9.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.3 хувиар өссөн. ХЗХ-дын хувь хөрөнгө 11.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар, нийт өр төлбөрийн хэмжээ 18.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 73.3 хувиар тус тус өсчээ.


Дүрслэл 32. ХЗХ-дын өөрийн хөрөнгө, өр төлбөр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-ны үйлчилгээний хүртээмж: Нийт 271 ХЗХ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 33. ХЗХ-дын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ 2016 - I УЛИРАЛ

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт ХЗХ-дын гишүүдийн тоо 41,817-д хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9,039 гишүүнээр нэмэгдсэн байна.

ХЗХ-дын үр ашигт байдал: ХЗХ-дын нийт орлого 6.08 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.03 тэрбум төгрөг буюу 20.4 хувиар өссөн бол нийт зардлын хувьд

өмнөх оны мөн үеийнхээс 19.6 хувиар өссөн үзүүлэлттэй тус тус гарчээ. Ингэснээр нийт цэвэр ашиг 0.62 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 28.8 хувиар өссөн. Нийт зардлын хэмжээ өсөхөд хүүгийн зардал 15.5, үйл ажиллагааны зардал 37.5 хувиар тус тус өсч, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 46.2 хувиар буурсан зэрэг нь ашигтай гарахад нөлөөлөв.

Дүрслэл 34. ХЗХ-дын ашигт ажиллагаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хэдийгээр болзошгүй эрсдэлийн сангийн зардал буурсан ч, нийт чанаргүй зээлийн хэмжээ 1.5 тэрбум төгрөгөөр буюу 75.9 хувиар өссөн байна. Мөн эдийн засгийн өсөлт саарч байгаатай холбоотойгоор ХЗХ-дын гишүүдийн орлогын эх үүсвэр тасалдах, буурах зэрэг хүчин зүйлс чанаргүй зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлж, олгогдсон зээл хугацаандаа төлөгдөхгүй байх нөхцөл үүсч байгаа тул ХЗХ-дод тавигдах шалгуурыг өндөрсгөх, тэдгээрийг чадавхижуулах, хяналт шалгалтын оновчтой бодлого хэрэгжүүлэхэд анхаарах нь зохистой.

8.2.2. Зээлийн батлан даалтын сан

Тайлант хугацаанд зээлийн батлан даалтын сан (ЗБДС)-аас 407 аж ахуйн нэгж, иргэний 72.8 тэрбум төгрөгийн

зээлэнд 30.0 тэрбум төгрөгийн батлан даалт гаргажээ. Уг сангаас гаргасан батлан даалтын дээд хэмжээ 500.0 сая төгрөг, доод хэмжээ 1.0 сая төгрөг байв. ЗБДС нь нийт 12 банк, 8 ББСБ, 1 ХЗХ-той хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 9 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэжээ.

Нийт гаргасан батлан даалтад 24.6 хувийг Голомт банк, 20.9 хувийг Хас банк, 14.7 хувийг Хаан банк, 18.4 хувийг Төрийн банк, 12.5 хувийг Капитал банк, 8.1 хувийг Худалдаа хөгжлийн банк, 0.2 хувийг Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Ариг банкуудын гаргасан зээл тус тус эзэлжээ.

Хүснэгт 27. Батлан даалт гаргасан байдал

Д/д	Банк, санхүүгийн байгууллага	Батлан даалтын тоо	Зээлийн хэмжээ / төгрөг /	Батлан даалтын хэмжээ /төгрөг/	Батлан даалтад эзлэх хувь	Хувийн жин
1	Голомт банк	100	18,866,010,000.0	8,219,817,000.	27.4	24.6
2	Капитал банк	51	7,074,100,000.0	2,812,238,200.0	9.4	12.5
3	Төрийн банк	75	10,321,200,000.0	3,666,865,000.0	12.2	18.4
4	ХААН банк	60	14,755,289,470.0	6,151,240,545.0	20.5	14.7
5	Хас банк	85	9,177,000,000.0	4,199,263,500.0	14.0	20.9
6	Чингис хаан банк	0	-	-		
7	Худалдаа хөгжлийн банк	33	12,214,600,000.0	4,740,007,800.0	15.8	8.1
8	ҮХО-н банк	1	140,000,000.0	80,880,800.0	0.3	0.2
9	Капитрон банк	1	20,000,000.0	3,100,000.0	0.0	0.2
10	Ариг Банк	1	200,000,000.0	120,000,000.0	0.4	0.2

11	Улаанбаатарбанк	0	-	-		
12	Богд банк	0	-	-		
	Нийт дүн	407	72,768,199,470.0	29,993,412,845.0	100	100

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Зээлийн батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн зээлийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 83.3, батлан даалтын дүн нь 84.0 хувиар тус тус буурсан бөгөөд энэ нь банкуудын зээлийн хязгаарлалт болон төсөл хөтөлбөрийн зээл олголтын хэмжээ буурсантай холбоотой.

Хүснэгт 28. Батлан даалтын тоо

Д/д	Үзүүлэлтүүд	2015-1	2016-1	Өөрчлөлт % Бууралт (-) Өсөлт (+)
1	Батлан даалтын тоо	24	4	-83.3
2	Батлан даалтын дүн	1,543,024,945	249,600,000	-84
	Зээлийн дүн	4,395,189,470	535,000,000	-88

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Батлан даалтын үйлчилгээний хүртээмжийн хувьд нийт батлан даалтын 64.9 хувь нь Улаанбаатар хотод гаргасан батлан даалт, 35.1 хувь нь орон нутгийн зээлд гаргасан батлан даалт тус тус эзлэж байна.

Хүснэгт 29. Батлан даалтын хүртээмж

Д/д	Үзүүлэлтүүд	Батлан даалтын тоо	Батлан даалтын дүн / төгрөгөөр/	Батлан даалттай зээлийн дүн /төгрөгөөр/	Хувь
1	Орон нутаг	143	6,760,211,200.00	13,752,950,000.00	35.1
2	Улаанбаатар	264	23,233,201,645.00	59,015,249,470.00	64.9
	Нийт дүн	407	29,993,412,845.00	72,768,199,470.00	100

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Нийт батлан даалтын 24.0 хувь нь ҮХААЯ-ны төсөл, 29.2 хувь нь банкны, 24.3 хувь нь ЖДҮХС-ын төсөл, 22.5 хувь нь бусад эх үүсвэртэй зээл олголтод гаргасан байна.

Хүснэгт 30. Санхүүжилтийн эх үүсвэр

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлан даалтын тоо	Батлан даалтын хэмжээ	Батлан даалттай зээлийн хэмжээ	Батлан даалтад эзлэх хувь
1	Өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих сан	3	37,200,000.0	74,000,000.0	0.12
2	Банк	141	8,772,932,945.0	20,785,089,470.0	29.2
3	БХБЯ-ны төсөл	1	250,000,000.0	1,000,000,000.0	0.83
4	ЖАЙКА	33	4,309,998,800.0	10,028,800,000.0	14.4
5	ЖДҮХС-ын төсөл	90	7,293,836,700.0	17,662,300,000.0	24.3
6	ҮХААЯ-ны төсөл	67	7,183,375,000.0	18,487,810,000.0	24
7	ХЭДС	50	140,485,000.0	268,600,000.0	0.5
8	Монгол 888 төсөл	11	1,572,389,000.0	3,632,600,000.0	5.2
9	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл	2	21,000,000.0	60,000,000.0	0.07
10	НЖДҮХС	9	412,195,400.0	769,000,000.0	1.4
	Нийт дүн	407	29,993,412,845.0	72,768,199,470.0	100

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Нийт батлан даалтын эх үүсвэрийн 29.2 хувийг банк, 24.0 хувийг ҮХААЯ-ны төсөл, 24.3 хувийг ЖДҮХС-ын төсөл, 14.4 хувийг ЖАЙКА-ийн төсөл тус тус бүрдүүлжээ.

БҮЛЭГ 9.

ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨРИЙН БОДЛОГО

Үнэт цаасны зах зээл нь эдийн засгийн өсөлт болон санхүүгийн тогтвортой байдалд гол нөлөөг үзүүлдэг бөгөөд урт хугацаанд хэрэгжих төсөл, хөтөлбөрт шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг олон нийтээс татан төвлөрүүлэх замаар нөөцийн хуваарилалт болон түүний дахин хуваарилалтыг хэрэгжүүлэх санхүүгийн арга хэрэгсэл юм.

Даатгалын салбар нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчдад ирээдүйд учрах эрсдэлээ удирдах, шилжүүлэх, төвлөрүүлсэн нөөц хөрөнгөөр дамжуулан урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох замаар эдийн засгийн бодит өсөлтийг дэмждэг.

Энэхүү хоёр салбарын хөгжлийн үзүүлэлтүүдийг өсгөх, зуучлалын тогтолцоог боловсронгуй болгож, хөрөнгө оруулагч, даатгуулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд төрийн зохицуулалтын тогтолцоо зайлшгүй шаардлагатай. Үнэт цаасны зах зээл болон даатгалын салбарыг зохицуулах, хяналт тавих чиглэлээр төрөөс шууд болон шууд бус бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд бодлогын арга хэрэгслүүдийг хэрхэн оновчтой бүрдүүлж, хоорондын уялдааг хангаснаас зах зээлийн гарц буюу хөгжил шууд хамаардаг.

ТӨРИЙН ШУУД БУС ЗОХИЦУУЛАЛТЫН БОДЛОГО

Төрийн мөнгөний болон сангийн бодлого нь үнэт цаас, даатгалын салбарт шууд бусаар урт болон дунд хугацаанд нөлөө үзүүлдэг. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-ын 2016 оны үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн товхимолд хөгжиж буй болон хөгжингүй орнуудын үнэт цаасны зах зээлд арилжигдаж буй санхүүгийн хэрэгслийн үнэ ханшид төв банкны бодлогын хүү, нээлттэй захын үйл ажиллагаа хүчтэй нөлөөлж байгааг дурьдаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргажээ.

Манай орны хувьд үнэт цаас, даатгалын салбарын нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ доогуур, санхүүгийн зуучлалын дийлэнх үйлчилгээг банкны салбар гүйцэтгэдэг, төв банкнаас нээлттэй захын үйл ажиллагааны хэрэгслийг түлхүү ашигладаггүй нь эдгээр салбарт мөнгөний бодлогын үзүүлэх нөлөөлөл сул байх шалтгаан нь болж байна.

Сангийн бодлогын хувьд Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны нийлүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн арилжааны хэмжээ, хөрвөх чадварт шууд нөлөөлж байна. 2015 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан

510.3 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалагдсан нь нийт арилжааны 98.0 хувийг эзэлсэн бөгөөд үнэт цаасны зах зээлд оролцож буй хөрөнгө оруулагчид ЗГҮЦ-д хөрөнгө оруулах сонирхол өндөр байсан нь ажиглагдаж байна. Үнэт цаасны зах зээлд сангийн бодлогын нөлөөлөл мөнгөний бодлогоос илүү хүчтэй нөлөөлж байна.

Даатгалын тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиудад салбарын бодлогуудыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөрөнгө оруулалт, эдийн засгийн нэгдсэн бодлоготой уялдуулан тодорхойлох, төрийн зохицуулагч байгууллага нь салбарын үйл ажиллагааг зохицуулах, хянах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааж, шууд болон шууд бус бодлогуудын хоорондын ялгааг нарийвчлан зохицуулсан.

Хөгжиж буй болон хөгжингүй орнуудад үнэт цаас, даатгалын салбарт шаардлагатай дэд бүтцийн чухал институцыг үүсгэн бий болгох үүргийг хувийн хэвшил, эсхүл төрийн мөнгөний болон сангийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага нь хариуцан, бүрэлдэн бий болсон институцын үйл ажиллагааг зохицуулах, хянах, хоорондын уялдааг төрийн зохицуулалт, хяналтын байгууллага чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх хандлага давамгайлж байна.

ТӨРИЙН ШУУД ЗОХИЦУУЛАЛТЫН БОДЛОГО

Үүнд төрийн зохицуулагч байгууллагаас үнэт цаасны зах зээл болон даатгалын салбарыг зохицуулах, хяналт тавих чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, түүний хэрэгслүүдийг /regulation, supervision, enforcement/ ойлгох бөгөөд Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага болон даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбооноос гаргасан зөвлөмж, зарчим, стандартуудыг мөрдөн ажиллах, системийн эрсдэлээс сэргийлэх, хөрөнгө оруулагч, даатгагчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад төрийн шууд бус бодлогын хэрэгслүүдийг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэхэд чиглэгддэг.

2008 оноос хойш санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хямрал дахин давтагдахаас сэргийлэх чиглэлээр СТБЗ-өөс үнэт цаас, даатгал, банкны салбаруудын олон улсын зохицуулагч байгууллагын холбоодын үйл ажиллагааг уялдуулах, зохицуулалт, хяналтын арга хэрэгслүүдийг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж, стандартыг боловсруулсан.

Түүнчлэн Япон улсын Санхүүгийн үйлчилгээний агентлаг / Financial Services Agency/, Англи улсын CRA International зэрэг байгууллагууд нь үнэт цаасны зах зээлийн хяналт, зохицуулалтын орчин, түүний зах зээлийн хөгжлийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг судлаад, “Үр ашигтай зохицуулалтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх дамжуулах механизм” гэх шинэ загварчлалыг бий болгожээ.

Төрийн шууд зохицуулалтын бодлогын хэрэгслүүд нь үнэт цаас гаргагч, даатгалын компани, мэргэжлийн зуучлагчдын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагч, даатгуулагч, харилцагчийн зах зээлд хандах хандлагад нөлөөлөх замаар гарцын буюу зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг жолоодох бололцоог бүрдүүлдэг. Салбаруудын хөгжлийн үзүүлэлтүүд нэмэгдсэнээр нийт санхүүгийн зах зээлд эзлэх зуучлалын хувь хэмжээ өсөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, даатгуулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл олшрох, орлогын хуваарилалтаар дамжин эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлэх боломжтой.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ

Үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хяналт тавихад төрийн зохицуулалт /regulation/, хяналт, шалгалт /supervision/, хууль тогтоомжийг мөрдүүлэх /enforcement/ гэсэн гурван үндсэн хэрэгслүүд ашиглагддаг ба эдгээр хэрэгслийг хэрхэн зөв зохистойгоор уялдуулан хэрэгжүүлж чадсанаар үнэт цаасны зах зээлийн хөгжлийн гарцын үзүүлэлтүүдийг оновчтойгоор удирдах боломж бүрдэнэ.

Үнэт цаасны зохицуулалтын арга хэрэгсэл - Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын чиглэлээр 3 үндсэн зорилтыг дэвшүүлэн, тэдгээрийг хэрэгжүүлэх 7 хүрээнд 38 зарчмыг баталж, өөрийн гишүүн байгууллагуудад мөрдөхийг зөвлөсөн байна. Энэхүү зарчмууд нь үнэт цаасаа олон нийтэд санал болгох /public issues of securities/, мэргэжлийн зуучлагч, өөрийгөө зохицуулах байгууллага /ӨЗБ/, хамтын санхүүгийн хэрэгсэл /collective investment scheme/, хоёрдогч зах зээл /secondary market/-ийн үйл ажиллагаанд тавих зохицуулалтын хүрээг хамардаг.

- Үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргахад тавигдах зохицуулалтын арга хэрэгслийн зорилго нь үнэт цаас гаргагч хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээллийг үнэн зөв, цаг тухайд нь мэдээлэх, мэдээлэл тайлагнал, засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр төрийн зохицуулагч байгууллагаас тавьж буй хяналт, зохицуулалт;
- Мэргэжлийн зуучлагчийн хувьд зах зээлд ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр бизнес эрхлэх, харилцагчтайгаа сонирхлын зөрчил үүсгэхгүй байх, мэргэжлийн ёс зүйг сахиулах чиглэлээр төрийн зохицуулалт, хяналтын зарим чиг үүргийг өөртөө шилжүүлсэн өөрийн зохицуулалт /self regulation/;
- Хөрөнгө оруулалтын менежментийн компаниас санд хөрөнгө татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээллийг хүргэх, тайлагналын ил тод байдлыг бүрдүүлсэн байдалд тавьж буй хамтын санхүүгийн хэрэгслийн зохицуулалт, хяналт;

- Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн зохицуулалт нь дэд бүтцийн байгууллагуудын уялдааг хангах, төлбөр, тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх, үнэт цаасны ханш зах зээлийн бодит зарчмаар тогтох, зах зээлийг урвуулан ашиглах үйлдлээс сэргийлэх, дотоод мэдээлэл эзэмшин арилжаанд оролцохыг таслан зогсооход чиглэгдэж байна.

Өөрөөр хэлбэл, үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллага нь үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зуучлагч болон хөрөнгийн бирж болон түүний гишүүдийн хооронд бий болсон мэдээ, мэдээллийн гажуудлыг зохицуулснаар /asymmetries of information/, харилцагч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг /enforcement/ бий болгодог.

Үнэт цаасны зах зээлийн хяналт, шалгалтын арга хэрэгсэл - Хууль эрх зүйн орчин, хяналт, шалгалтын тогтолцоо, хууль мөрдүүлэх арга хэмжээ гэсэн үндсэн 3 арга хэрэгслээс тэргүүлэх ач холбогдолтой нь хяналт, шалгалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх явдал.

2008 оны санхүүгийн хямралаас хойш СТБЗ-өөс улс орнуудад санхүүгийн дэд бүтцийн тогтолцоог бэхжүүлэх, уян хатан санхүүгийн институци /resilient financial institutions/-ийг бий болгох чиглэлээр хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгохыг зөвлөөд байна.

Дээрх хямралаас хойш дийлэнх орнуудад хяналт, шалгалтыг дүрэм, журамд суурилсан тогтолцоо /rule based/-ноос зарчим /principle based/-д болон институцид суурилсан /institutions based/ тогтолцоонд шилжих чиглэлийг баримтлан эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлж байна.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаа, мэргэжлийн зуучлагч, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд тавих тусгайлсан хяналт, шалгалтын зөвлөмж, зааврыг гаргасан. Үүнд:

- Үнэт цаасаа олон нийтэд санал болгох, компанийн засаглал, мэдээлэл, тайлагналын ил тод байдлын тогтолцоонд тавих хяналт, шалгалтыг ӨЗБ хариуцан гүйцэтгэж, төрийн байгууллагаас нарийвчилсан хяналт, шалгалт гэхээсээ илүүтэйгээр хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, ерөнхий зохицуулалтын бүтцэд өөрийгөө зохицуулах зохицуулалтыг оруулах;
- Төрийн зохицуулагч байгууллагаас мэргэжлийн зуучлагчид тавих хяналт, шалгалт нь зуучлагч байгууллага дампуурах, үйл ажиллагаа нь доголдсон тохиолдолд харилцагчдын хөрөнгийг хамгаалах, томоохон дүнтэй арилжааны төлбөр, тооцоо хийгдээгүйгээс үүсэх эрсдэлийг бууруулах, харилцагчтайгаа сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлэх 3 зорилтыг агуулах ба хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрлийн шаардлага, үйл ажиллагааны болон дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын стандарт, бизнесийн ёс зүйн дүрмийг тогтоож өгөх;
- 2008 оны санхүүгийн хямралаас хойш дүрэм, журамд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоо үр дүнгүй болох нь батлагдсан бөгөөд хөгжиж буй болон хөгжингүй

орнуудад үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх хандлага давамгайлж байна. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалт

нь эрт илрүүлэх систем, тайлагналын ил тод байдал, мэргэжлийн зуучлагч байгууллага эрсдэлээ өөрөө үнэлэх аргачлалыг агуулдаг бөгөөд дараах хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Үүнд:

Хүснэгт 31. Эрсдэлийн удирдлагын аргачлал

Д/д	Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын хүрээ	Эрсдэлийн удирдлагын бүтцийн хяналт	Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх хэрэгсэл
1.	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага	Хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийн шаардлага	Зуучлагчийн хөрөнгө оруулагчдад хүргэж буй мэдээллийн хяналт
2.	Компанийн засаглалын дүрэм, журам	Эрсдэлийг тодорхойлох, тогтоох, хянах загварчлал	Өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын хяналт
3.	Хөрөнгө оруулалтын дүрэм, журам	Хөрөнгө оруулалтын багц дахь үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг үнэлэх аргачлал	Зуучлагчийн үндсэн үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөнд тавих хяналт
4.	Хөндлөнгийн аудит болон дотоод хяналтын тогтолцоо	Стресс тест хийх шалгуур, аргачлал	Зуучлагчийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн аудит дүгнэлт
5.	Мэдээлэл, тайлагналын шаардлага	Эрсдэлийг тараан байршуулах бодлого	Зуучлагчийн тайлагнал, мэдээллийн ил тод байдалд тавих хяналт
6.	Өөрийн хөрөнгө, нөөц хөрөнгийн бүтэц	Компанийн засаглал, тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуур	Зуучлагчийн үйл ажиллагаа болон арилжааны хяналт
7.	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, татан буулгах нөхцөл	Дотоод хяналтын тогтолцоо, бие даасан хараат бус аудитын дүгнэлт Цахим системийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр Хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийн найдвартай байдал	

- Мэргэжлийн зуучлагчдын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналтыг сайн төлөвлөсөн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх, ингэснээр тэдгээрийн үйл ажиллагааг урт хугацаанд хэвийн тогтвортой явуулах, системийн эрсдэлээс сэргийлэх;
- Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн дэд бүтцийн уялдааг хангах чиглэлээр тавигдах хяналт, шалгалт нь үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл эзэмшигч арилжаанд оролцохоос сэргийлэх, дээрх үйлдлийг таслан зогсоох чиглэлээр хийгддэг арилжааны хяналт, шалгалтыг /surveillance/ авч үздэг. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас хөгжиж буй болон хөгжингүй үнэт цаасны зах зээлтэй орнуудад хийгдсэн судалгааны ажлуудад дурьдсанаар арилжааны хяналт, шалгалт нь 3 үндсэн төрөлтэй. Энэ нь төрийн зохицуулагч байгууллага өөрөө, эсхүл ӨЗБ-тай хамтран мөн ӨЗБ дангаараа хэрэгжүүлдэг ба дийлэнх орнуудад арилжааны хяналтын чиг үүргийг ӨЗБ хэрэгжүүлэх хандлага давамгайлж байна. Учир нь үнэт цаасны арилжаанд ӨЗБ бодит цагийн горимоор, харин төрийн зохицуулагч байгууллага хугацааны хожимдолтойгоор хяналт, шалгалтыг хэрэгжүүлдэг бөгөөд төрийн зохицуулагч байгууллага арилжааны явцад илэрсэн зөрчлийг хуулиар, ӨЗБ дотоод дүрэм, журмаар хариуцлага хүлээлгэдэг;
- Хамтын санг үүсгэх, түүний хөрөнгийг удирдах ажиллагаанд тавих төрийн хяналт, шалгалт нь хөрөнгө оруулагчийг хамгаалах, market integrity буюу зах зээлийн шударга байдал, сангийн удирдлага, зохион байгуулалтын оновчтой байдлыг хангах чиглэлээр хэрэгждэг. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас хөгжиж буй орнуудын зохицуулагч байгууллагуудад хандаж хамтын сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг дараах хүрээнд хэрэгжүүлэхийг зөвлөжээ. Үүнд:
 - Бизнесийн ёс зүйн хэм хэмжээний биелэлт;
 - Сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх;
 - Сангийн нэгж эрхийн тооцоолол, үнэлгээ;
 - Сангийн хөрөнгө оруулалтын бодлого, стратеги;
 - Сангийн хөрөнгийн хадгалалт, хөрөнгийн тусгаарлалт;
 - Сангийн үйл ажиллагааны зардал, шимтгэлийн хувь хэмжээ;
 - Сангийн дотоод хяналтын тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилт;
 - Мэдээлэл, тайлагналын ил тод байдал;
 - Сангийн үйл ажиллагааг зогсоох үндэслэл, татан буулгах.

Цаашид үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас хөгжиж буй орнуудын зохицуулагч байгууллагуудад хандан гаргасан зөвлөмж, зааврын хүрээнд мэргэжлийн зуучлагч, хөрөнгө оруулалтын сан, сангийн удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоонд шилжүүлэх, арилжааны хяналт, хувьцаат компанийн засаглал, мэдээлэл, тайлагналын хяналт, шалгалтыг ӨЗБ-д шилжүүлэх нь зүйтэй.

Түүнчлэн дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоо хангах, нэн шаардлагатай институцийг үүсгэх чиглэлээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төв банктэй хамтран ажиллах шаардлагатай.

Үнэт цаасны зах зээлийн хяналт, шалгалтын хандлага - 2008 оны хямралаас хойш СТБЗ, Европын холбооны комисс, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас үнэт цаасны зах зээлд үүсч болзошгүй хямралаас сэргийлэх чиглэлээр зах зээлийн дэд бүтцийн томоохон институци болох нэгдсэн тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг өндөрсгөх, тооцооны байгууллагын барьцаа хөрөнгийн шаардлагыг оновчтой байдлаар тогтоох, биржийн бус зах зээл /ОТС/-д арилжаалагдаж буй үүсмэл үнэт цаас, бусад актив суурилсан жижиглэнгийн үнэт цаасны /retail linked product/ төлбөр тооцоог нэгдсэн тооцооны төвөөр дамжуулан гүйцэтгүүлэх, зах зээлийг урвуулан ашиглах үйлдлээс сэргийлэх чиглэлээр зөвлөмж, стандартыг боловсруулан өөрийн гишүүн орнуудад хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

Манай орны хувьд үнэт цаасны тооцооны нэгдсэн байгууллага хараахан төлөвшөөгүй, үүсмэл үнэт цаас, хамтын санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд хараахан нэвтрээгүй байгаа хэдий ч цаашид тэдгээрийн хяналт, шалгалтын чиглэлээр Хорооны боловсон хүчинг мэргэшүүлэх шаардлага үүсээд байна.

Хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх зохицуулалтын арга хэрэгсэл /enforcement/ - Төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх өөр нэг үндсэн арга хэрэгсэл бол хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх /enforcement/ явдал юм. Зохицуулагчийн хяналт, шалгалтын арга хэрэгсэл нь зах зээлд оролцогч зохицуулалттай болон зохицуулалтгүй этгээд нь хууль, журмыг хэрхэн мөрдөж буйг тогтоох, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх /ex-ante/ чиглэлд анхаардаг бол хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх гэдэгт хууль, тогтоомжийг санаатай болон санамсаргүйгээр мөрдөөгүйгээс үүссэн үр дагаврыг арилгах, зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, буруутай үйлдэлд хариуцлага ногдуулах /ex-post/ ажиллагааг авч үздэг.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын үнэт цаасны зах зээлийн суурь зарчмуудын 8-10 хэсэгт төрийн зохицуулагч байгууллага нь газар дээрх хяналт, шалгалт /inspection/, мөрдөн шалгах /investigation/, арилжааны хяналт /surveillance/-ын оновчтой бүтцийг бий болгохыг өөрийн гишүүн орнуудад зөвлөсөн. Манай орны хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар газар дээрх болон арилжааны хяналтыг хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалтыг тусгасан хэдий ч ижил төстэй гадаад орны зохицуулагчаас хэрэгжүүлдэг мөрдөн шалгах зарим чиг үүргийг хэрэгжүүлэх боломж бүрдээгүй байна.

Олон улсын валютын сангийн санхүүжилтээр хийгдсэн “Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх ажиллагаа” сэдэвт судалгаагаар 6 үндсэн хүрээнд хамруулан хөгжингүй болон хөгжиж буй орнуудын төрийн зохицуулагч байгууллагуудаас хэрэгжүүлж хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх ажиллагааг дараах байдлаар ангилжээ. Үүнд:


- Төрийн зохицуулагч байгууллага нь хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх ажиллагааг хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх /clear mandate/;
- Зохицуулалттай болон зохицуулалтгүй этгээдээс нотлох баримт цуглуулан мөрдөн шалгах, газар дээрх үзлэг, шалгалт хийж, хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх / broad authority to investigate and obtain evidence/;
- Зах зээлд үүссэн эрсдэлийг бууруулах ажиллагааг цаг алдалгүй хэрэгжүүлэх /ability to immediately/;
- Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлагыг хүлээлгэх /authority to bring charges and impose a wide range sanctions/;
- Хууль тогтоомжийг зөрчиж зах зээлийн нэр хүнд, хэвийн ажиллагааг алдагдуулсан, хөрөнгө оруулагчдын эрх ашигт ноцтой хохирол учруулсан этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэх, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, нотлох мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх /active criminal enforcement/;
- Хил дамнасан шинжтэй арилжаа, төлбөр тооцооны хяналтыг хэрэгжүүлэх, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх, мэдээлэл солилцох, хариуцлага хүлээлгэх чиглэлээр гадаад орны ижил төстэй зохицуулагч байгууллагуудтай хоёр болон олон талт санамж бичгийн хүрээнд ажиллах.

Манай орны хувьд зохицуулагч байгууллага нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын албан ёсны гишүүн боловч үнэт цаасны зах зээлийн суурь 8-10 зарчмуудыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхэд дараах боломж нөхцөл хараахан бүрдээгүй байна.

Үүнд: Зохицуулагч байгууллагын хүний нөөцийн чадавх сул, хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх бие даасан мэргэшсэн нэгж бий болоогүй, эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн шалгах чиг үүргийг хүчний байгууллага дагнан хэрэгжүүлдэг, хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаа удаашралтай, хууль, хяналтын байгууллагын үнэт цаасны зах зээлийн хэрэг, маргааны талаарх мэдлэг хомс, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоо бүрэн нэвтрээгүй зэрэг болно.

Үнэт цаасны зах зээлийг зохицуулах төрийн бодлогын механизм - Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын зохицуулагч байгууллагуудаас сүүлийн жилүүдэд “Үр ашигтай зохицуулалтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх дамжуулалтын механизм” гэх шинэ загварчлал, хандлагыг түлхүү баримталж байгаа бөгөөд энэхүү хандлага нь орцын буюу бодлогын арга хэрэгслүүдээр дамжуулан зах зээлийн оролцогчдын үйл хөдлөлд нөлөөлөх замаар зах зээлийн гарцын буюу хөгжлийн үзүүлэлтүүдийг жолоодоход чиглэж байна. Үнэт цаасны зах зээлийн гарцын буюу хөгжлийн үзүүлэлтүүд нь дунд болон урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих үндсэн нөхцөл юм.

Дүрслэл 35. Бодлогын сувгийн нөлөөлөл



Манай орны хувьд үнэт цаасны зах зээлийн суурь тавигдсанаар даруй 20 жилийг ардаа орхисон хэдий ч хөгжлийн түвшингээр хөгжиж буй зах зээлийн шинжийг агуулсан, дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоо сул, нэгдсэн төлбөр, тооцооны байгууллага үүсэн бий болох шатандаа явагдаж байгаа, мэргэжлийн зуучлагчдын санхүүгийн чадвар сул, өөрийгөө зохицуулах байгууллагууд хараахан бэхжээгүй, гадаад, дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын зохистой бүтэц бүрдээгүй, олон нийтийн санхүүгийн боловсрол, эрхийн хамгаалалт дутмаг байгаа нь зах зээлийн хөгжилд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Өнөөгийн үнэт цаасны зах зээлийн төрийн зохицуулалт, хяналт нь зах зээлийн гарц буюу хөгжлийн үзүүлэлтүүдэд шууд болон дам байдлаар нөлөөлөх нөлөө сул, эрсдэлд суурилсан хяналт гэхээсээ илүүтэйгээр дүрэм, журамд суурилсан төлөвлөгөөт шинжийг өөртөө агуулж байна. Тиймээс төрийн байгууллагуудаас зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр төрийн сангийн болон мөнгөний уян хатан, нээлттэй тэлэх бодлогыг баримтлан, бодлогын арга хэрэгслүүдийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, хоорондын уялдааг нэгдсэн байдлаар хангах, зах зээлийн дэд бүтцийн шаардлагатай институциудыг бий болгож дэмжих нь зүйтэй.

ДААТГАЛЫН САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ

Даатгалын зохицуулалтын арга хэрэгсэл - Даатгалын салбарт байнга үүсдэг сөрөг үзэгдлүүд болох зах зээлийн гажуудал /market failure/ болон асуудал /market problem/ нь манай оронд мөн л тулгарч байгаа бөгөөд эдгээрийг арилгаж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад зайлшгүй төрийн зохицуулалт шаардлагатай.

Зах зээлийн гажуудал үүсэх нь эргээд гарцын буюу хөгжлийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх, нийгмийн нийтлэг эрх ашигт харшлах, шударга өрсөлдөөнийг хязгаарлах, зарим оролцогчдод давуу байдлыг олгох зэрэг нөхцлийг бүрдүүлдэг тул уг гажуудлаас сэргийлэх үүднээс хөгжиж буй болон хөгжингүй орнуудын даатгалын зохицуулагч байгууллагууд санхүүгийн болон зах зээлийн

зохицуулалтын арга хэрэгслийг уялдуулан түгээмэл хэрэгжүүлж байна.

Санхүүгийн зохицуулалт нь даатгуулагчийг хамгаалах зорилгоор даатгалын компанийн төлбөрийн чадварын болон санхүүгийн стандарт шаардлагуудыг хангуулах юм. Харин зах зээлийн зохицуулалт нь даатгалын зах зээлд зөв зохистой өрсөлдөөний орчинг төлөвшүүлэх, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн болон гэрээний стандарт, нөхцлийг бий болгоход чиглэгддэг.

2008 оны санхүүгийн хямралын дараагаас даатгалын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн нэгдэл компаниудын үйл ажиллагаанд тавих зохицуулалт, хяналтын тогтолцоог хөгжүүлэх, системийн ач холбогдолтой даатгагчийг тодорхойлох, бүс нутгийн болон олон улсын түвшинд санхүүгийн нэгдсэн зохицуулалт, хяналтын орчинг төлөвшүүлэх шаардлага үүссэн. Мөн СТБЗ, Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбоо /IAIS/-ны зүгээс нийт даатгалын компаниуд, олон улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй даатгалын группууд /Internationally Active Insurance Group-IAIGs/, системийн ач холбогдолтой даатгагч /G-SIIs/-дын үйл ажиллагааных нь онцлогт нийцүүлсэн зохицуулалт, хяналтын орчинг шинэчлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбооноос даатгалын суурь зарчмууд /Insurance Core Principles/-ыг Олон улсын валютын сан, Дэлхийн банкны санхүүгийн секторын үнэлгээний хөтөлбөрүүдэд үндэслэн шинэчлэх ажил эрчимтэй явагдаж байгаа ба суурь 26 зарчмыг үндсэн 5 бүлэгт хуваан үзжээ. Үүнд:

- Хянан шалгагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх зарчмууд /ICP-1, 2, 4, 6, 9-12/;
- Төлбөрийн чадварын зарчмууд /ICP-13-17/;
- Даатгалын компанийн нэгдлийн хяналт шалгалт, хямралын удирдлагын зарчмууд /ICP-3, 23-26/;
- Бизнесийн ёс зүй, зуучлагч болон зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх /ICP-18-19, 21-22/;
- Даатгалын компанийн засаглал, тайлагналын ил тод байдал /ICP -5, 7, 8, 20/.

Олон улсын даатгалын зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа эрхлэгч групп компани /AIGs/-уудад тавигдах хяналт, шалгалтын чиглэлээр өөрийн хөрөнгийн тоон болон чанарын стандартууд, үйл ажиллагааг нь тодорхойлох шалгуур үзүүлэлт болон хяналт, шалгалт /ComFrame/-ыг шинэчлэх, өөрчлөн боловсруулах ажлыг Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбооноос хийж байна. Мөн системийн ач холбогдол бүхий даатгагчийг тодорхойлох, хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор СТБЗ-тэй хамтран системийн ач холбогдлыг тодорхойлох шалгуур /G-SIs package/, суурь өөрийн хөрөнгийн шаардлага /Basic capital requirement/, их дүнтэй алдагдлыг нөхөх харьцаа /Higher loss absorbency/-г боловсруулан өөрийн гишүүн орнуудад хэрэгжүүлэхийг зөвлөөд байна.

Манай орны хувьд үндэсний даатгалын компаниуд бүс нутгийн болон олон улсын түвшинд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэггүй, санхүүгийн зах зээлд эзлэх хувь бага энэ үед төрийн зохицуулагч байгууллагаас зохицуулалт, хяналтын орчинг даатгалын суурь зарчмуудад нийцүүлэн шинэчлэх, даатгалын компанийн оролцоотой санхүүгийн нэгдлийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтыг боловсронгуй болгох тохиромжтой цаг үе ирээд байна.

Даатгалын хяналт, шалгалтын арга хэрэгсэл - Даатгалын компанийн санхүүгийн болон үндсэн үйл ажиллагаанд тавьж буй хяналт, шалгалт улс орон болгонд өөрийн гэсэн онцлогтой бөгөөд Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбооноос зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг оновчтой уялдуулж, хэрэгжүүлэх тоо болон чанарын аргачлал, хяналт, шалгалтын хүрээг багтаасан нарийвчилсан хөтөлбөртэй байхыг зөвлөсөн.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага /OECD/-аас Азийн 12, төв Европын 14 орнуудыг хамруулсан даатгалын зохицуулалт, хяналтын орчин сэдэвт судалгааны ажилд даатгалын зайны болон газар дээрх хяналт шалгалтын дараах нийтлэг хүрээг тодорхойлжээ:

- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд компанийн хэлбэр, бизнес төлөвлөгөө, хураамжийн хувь хэмжээ, стандарт гэрээний нөхцөл, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, давхар даатгалын гэрээ, санхүүгийн болон бүртгэлийн стандарт шаардлагууд, салбар болон төлөөлөгчийн газрын мэдээлэл;
- Тасралтгүй үргэлжлэх хяналт, шалгалт /Ongoing supervision/-ыг төлбөрийн чадварын зохистой харьцаа, техникийн нөхцлүүд, хөрөнгө оруулалтын хязгаарлалт, үнэлгээ;
- Давхар даатгалын компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн хүндрэлд орсон даатгалын компаниудад тавигдах арга хэмжээ;
- Даатгуулагчийг хамгаалах сангийн болон албан журмын даатгал, түгээлтийн суваг, актуар, аудитын үйл ажиллагаа;
- Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүү, дотоод хяналт, хууль, тогтоомж, зохицуулах байгууллагаас баталсан дүрэм, журмын хэрэгжилтэд тавих газар дээрх хяналт, шалгалт гэж төрөлжүүлжээ.

Даатгалын салбарын хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх зохицуулалтын арга хэрэгсэл /enforcement/ - Даатгалын хяналт, зохицуулалтын олон улсын холбооны даатгалын суурь зарчмын 11 дүгээрт энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, мэдээлэх үүргийг тусгаж, дараах 3 хүрээнд хэрэгжүүлэхийг зөвлөжээ. Үүнд:

- Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагаанд хязгаарлалт тавих /Restrictions on business activities/. Үүнд: даатгалын шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгон гаргах, нэгдэж нийлэх, өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгөө бусдад шилжүүлэх, охин, хараат компани байгуулах зэргийг хязгаарлах;
- Санхүүгийн бэрхшээлтэй даатгалын компанид эрсдэлээ бууруулах, төрөлжүүлэх, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхийг шаардах, хувьцаа эзэмшигчдэд тараах ногдол ашгаас бусад төлбөрийг зогсоох, компанийн хувьцааны арилжааг зогсоох;
- Захиргааны хариуцлага хүлээлгэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийг бусад даатгалын компанид шилжүүлэх, цаашид даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглох.

ДҮГНЭЛТ

Эндээс даатгалын салбарт хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх ажиллагаа нь үнэт цаасны зах зээлээс мөрдөн шалгах ажиллагааны чиг үүргээрээ ялгаатай нь харагдаж байна. Цаашид даатгалын салбар дахь төрийн зохицуулалт, хяналтын орчинг боловсронгуй болгох чиглэлээр олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөмж, стандартад нийцүүлэн шинэчлэх, зах зээлд нэгэнт бий болсон даатгалын компанийн оролцоотой санхүүгийн нэгдлийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтыг оновчтой болгох, зохицуулагч байгууллагын албан хаагчдыг эконометрик, стохастик шинжилгээ судалгаагаар мэргэшүүлэх нь зүйтэй.

Үнэт цаас, даатгалын салбарт төрийн зохицуулагч байгууллагаас хэрэгжүүлдэг зохицуулалт, хяналт, шалгалтын арга хэмжээний хүрээг төрөлжүүлэн хураангуйлахыг зорьсон бөгөөд цаашид нэгдсэн бодлого, зохицуулалтын журмыг боловсруулах, хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, зайны болон газар дээрх хяналт шалгалтын бодлогыг боловсруулахдаа олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөмж, стандартад нийцүүлэх шаардлагатай.

